



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
НИЙСЛЭЛИЙН НИЙТИЙН ТЭЭВРИЙН БОДЛОГЫН ГАЗАР



2024 ОНЫ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

УЛААНБААТАР ХОТ
2024 ОН



АГУУЛГА

БҮТЭЦ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ..... 5

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ..... 5

1.1.“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд:
..... 6

1.2.Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хэрэгжилт. 6

1.2.1.Сурагчийн автобусны парк шинэчлэлт хийнэ. 6.3.13.1 7

1.2.3. Цахилгаан эх үүсвэрээр ажилладаг тээврийн хэрэгслүүдийг цэнэглэх цэгүүдийн байршлыг тодорхойлж цэгүүдийг холбогдох мэргэжлийн байгууллагуудын оролцоотойгоор байгуулна. 6.3.14.1. 8

1.2.4.Нийтийн тээврийн үйлчилгээний автобусны парк шинэчлэлтийг олон улсын стандартад нийцүүлэн хийж гүйцэтгэнэ. 6.3.14.2..... 9

1.2.4.1.“Нийтийн тээврийн автобус (Улаанбаатар) төсөл арга хэмжээний хүрээнд байгуулагдсан НЗДТГ/202310014 дугаартай “Нийтийн тээврийн автобус нийлүүлэх гэрээ”-ний хэрэгжилт. 10

1.2.5.Ачаа тээврийн удирдлагын системийн нэмэлт хөгжүүлэлтийн программ хангамж боловсруулж, ачаа тээвэрлэлт, түгээлтийн үйл ажиллагааг үе шаттайгаар шөнийн горимд шилжүүлнэ. НЗДҮАХ 6.3.18..... 13

1.2.5.1.НИТХ-102 дугаар тогтоолд нэмэлт өөрчлөлт оруулан НЗД-аар батлуулна. 13

1.2.5.2.“Нийслэлийн гудамж, замын хөдөлгөөнд ачааны автомашиныг цагийн хязгаартайгаар оролцуулах, түр зөвшөөрөл олгох журам”-ыг шинэчлэн боловсруулах тухай..... 14

1.3. Шинэ техник, технологийг нутагшуулах, системийн хэвийн ажиллагааг хангах
..... 16

1.3.1. Нийтийн тээврийн үйлчилгээний хөдөлгөөний бүртгэл, мэдээлэл хяналт, зохицуулалтын удирдлагын төв байгуулна. НЗДҮАХ 6.3.19..... 18

1.3.2.Удирдлага, мэдээллийн болон цахим төлбөрийн системийн программ хангамжийн мэдээлэлд тулгуурлан нийтийн тээврийн үйлчилгээнд ажилласан нийт тээврийн хэрэгслүүдийн өдөр тутмын ажлын гүйцэтгэлд бүртгэлээр хяналт тавих..... 20

1.4.Зам, тээврийн сайд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч нар зам тээврийн салбарт 2021-2024 онд хамтран ажиллах арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлын хүрээнд: 27

1.4.1.Зорилт 2. Байгаль орчинд ээлтэй, тогтвортой, хүртээмжтэй, аюулгүй, олон төрөлт, ухаалаг нийтийн тээврийн үйлчилгээг хөгжүүлж, Улаанбаатар хотын зорчигчдын ариун цэвэр, аюулгүй байдлыг хангасан, нийтийн тээврийн буудлуудыг бий болгох, ачаа тээврийн нэгдсэн логистикийг хөгжүүлэх; 27

ХОЁРДУГААР БҮЛЭГ. НИЙТИЙН ТЭЭВРИЙН БОДЛОГЫН ГАЗРЫН ДҮРМЭЭР

ХҮЛЭЭСЭН ҮҮРГИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН..... 33

2.1.Нийтийн тээврийн үйлчилгээний зорчих үнэ, тариф, машин цагийн зардлыг шинэчлэн тогтоох тооцоо, судалгааг хийж, санал боловсруулах, нийтийн тээврийг хөгжүүлэх сантай холбоотой асуудлыг эрх бүхий байгууллагаар шийдвэрлүүлэх, хяналт тавих; 4.1.1.1..... 33



2.2.Хууль тогтоомж, дүрэм, журмын хүрээнд тээвэрлэлт гүйцэтгэх аж ахуйн нэгж, байгууллагыг сонгон шалгаруулах, стандартын шаардлагыг хангаж буй эсэх талаар дүгнэлт гаргах, түвшин тогтоох /аттестатчилал/ явуулах; 4.1.1.2.	33
2.3.Хотын доторх болон хот орчмын нийтийн зорчигч тээврийн сүлжээ, төлөвлөлт, үйлчилгээний чиглэлийг тогтоох, чиглэл, зогсоолыг шинээр нээх, хаах, өөрчлөх, бүртгэлжүүлэх, цагийн хуваарь тогтоох; 4.1.2.2.	35
2.4.Нийтийн тээврийн үйлчилгээний автобусны эцсийн болон дундын зогсоолын барилга байгууламжийн ашиглалтад хяналт тавьж, тохижилт болон урсгал засварын ажлыг зохион байгуулах; 4.1.2.3.	38
2.5.Нийтийн тээврийн хэрэгсэл, сургуулийн болон ажилчдын автобус, нийслэлийн төр, захиргааны автотээврийн хэрэгсэлд техникийн хяналтын үзлэг хийх ажлыг зохион байгуулах; 4.1.2.5.	43
2.6. Нийтийн тээврийн үйлчилгээний байгууллагуудад ангилал тогтоох, бүртгэх үйл ажиллагааг нийслэлийн хэмжээнд зохион байгуулах; 4.1.3.1.	48
2.7.Нийтийн тээврийн салбарт мөрдөж байгаа хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, дүрэм, журмын биелэлт, стандартын хэрэгжилтийг хангуулах зорилгоор автотээврийн улсын хяналт хэрэгжүүлэх; 4.1.4.1.	52
2.7.4.Нийтийн тээврийн салбарт мөрдөж байгаа хууль тогтоомж, дүрэм, журмын биелэлт, стандартын хэрэгжилтийг хангуулах зорилгоор Автотээврийн улсын хяналт хэрэгжүүлнэ.	54
2.7.5.Нийтийн тээврийн хэрэгсэл, сургуулийн болон ажилчдын автобус, нийслэлийн төр, захиргааны автотээврийн хэрэгсэлд техникийн хяналтын үзлэг хийх ажилд хяналт шалгалт хийнэ.	55
2.7.6.Аюултай болон тусгай ачаа тээврийн зохицуулалтад хяналт тавина.	55
2.7.8.Нийслэлийн нутаг дэвсгэрт ачаа тээвэрлэлтийн үйл ажиллагаа эрхэлж буй тээврийн хэрэгслийн өдөр тутмын үйл ажиллагаанд хяналт тавина.	55
2.7.9.Нийтийн тээврийн үйлчилгээний хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор автобус, таксийн зогсоол, чиглэлийн тээврийн хэрэгслийн эгнээ байранд саад учруулж буй тээврийн хэрэгслийг чөлөөлөх, хариуцлага тооцно.	56
2.7.10.Нийтийн тээврийн үйлчилгээний чанар, соёлыг сайжруулах ажлыг тасралтгүй зохион байгуулах ажлын хүрээнд сургалт зохион байгуулна.	56
2.7.11.Нийтийн тээврийн үйлчилгээнд ажиллаж байгаа залуу жолооч нар тэдгээрийн гэр бүлд зориулсан “Түмний жолооч -Түшигтэй гэр бүл” сэдэвт соён гэгээрүүлэх, урлаг, уран сайхны нэгдсэн арга хэмжээ.	59
ГУРАВДУГААР БҮЛЭГ. НИЙТИЙН ТЭЭВРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ОРЛОГО ТӨСӨВТ ТӨВЛӨРҮҮЛЭХ.	61
3.1.Нийтийн тээврийн үйлчилгээний орлого:	61
3.1.1.Төсөвт төвлөрүүлэх орлогын талаар:	61
3.2.Нийтийн тээврийн автобусны тээврийн хэрэгслийн даатгал:	61
3.2.1.Каунти маркийн автобусны тээврийн хэрэгслийн даатгал:	61
3.2.2.“Yutong bus ZK6186HG загварын угсраа 31 автобусны даатгал:	61
3.3.Тэнүүн-Огоо ХХК-ийн хөрөнгийн үнэлгээний талаар:	61
3.4.Нийтийн тээврийн үйлчилгээний орлого, зардлын зөрүү санхүүжилт:	61



3.5.Суутгалтай холбоотой:	61
3.6.Сургуулийн автобусны талаар:	61
3.7.Нөхөн олговрын талаар:	61
3.8.Баяр наадмын талаар:	61
3.9.Өглөг, авлагыг барагдуулах чиглэлээр:	61
3.10.Санхүүгийн тайлантай холбоотойгоор:	61
3.11.Аудитын байгууллагын дүгнэлт:	61
3.12.Байгууллагын хөрөнгийн тооллогын ажлын талаар:	61
3.13. Өглөг, авлагыг барагдуулах чиглэлээр:	61
ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. АРХИВ, АЛБАН ХЭРЭГ ХӨТЛӨЛТИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХЭРЭГЖИЛТ	61
ТАВДУГААР БҮЛЭГ. БУСАД АЖЛЫН ХҮРЭЭНД:	72
ХИЙГДСЭН АЖЛЫГ НЭГТГЭН ДҮГНЭХЭД.	80
ЦААШИД ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН САНАЛ.	82




БҮТЭЦ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын болон Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл, Монгол Улсын Засгийн газар болон Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Зам, тээврийн хөгжлийн сайд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч нар Зам, тээврийн салбарт 2021-2024 онд хамтран ажиллах “Санамж бичиг”-т тусгагдсан зорилтуудыг, Автотээврийн тухай хууль болон бусад холбогдох хууль, тогтоол, дүрэм журмын хүрээнд хэрэгжүүлж ажиллалаа.

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 81 дүгээр тогтоолоор Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны бүтэц, Нийслэл, дүүргийн Засаг даргын Тамгын газар, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны орон тооны хязгаарыг шинэчлэн баталсан бөгөөд “Нийтийн тээврийн газар”-ын нэрийг өөрчлөн “Нийтийн тээврийн бодлогын газар” гэж баталсан.

Үүний дагуу Нийслэлийн Засаг даргын 2024 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн А/443 дугаар захирамжаар тус газрын зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаарыг шинэчлэн, зохион байгуулалтын бүтцийг 8 хэлтэс, 350 хүртэл орон тооны хязгаартай ажиллахаар баталсан.

Нийслэлийн Засаг даргын 2024 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн А/1403 дугаар захирамжаар Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/443 дугаар захирамжийн нэгдүгээр хавсралтын 1 дэх хэсэгт заасан “Нийтийн тээврийн бодлогын газрын зохион байгуулалтын бүтцийн нэгжид “9.Хуулийн хэлтэс” гэж нэмснээр 9 хэлтэс, 350 албан хаагчтайгаар үйл ажиллагаа явуулж байна.



350

Зураг № 1. Нийтийн тээврийн бодлогын газрын бүтэц

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ

“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх зорилго, зорилт, үйл ажиллагааны 2024 оны жилийн эцсийн хэрэгжилтийн дундаж 87,5 хувь;

“Шинэ сэргэлтийн бодлого”-ын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх хөгжлийн төслийн 2024 оны жилийн эцсийн хэрэгжилтийн дундаж 100 хувь;

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт туссан тус газарт хамаарал бүхий арга хэмжээний хэрэгжилтийн дундаж 100 хувь;

Зам, Тээврийн Хөгжлийн сайд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч нарын Зам, тээврийн салбарт 2020-2024 онд хамтран ажиллах “Санамж бичиг”-т туссан хамаарал бүхий арга хэмжээний 2024 оны жилийн эцсийн хэрэгжилт 99,4 хувь;

Тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийн 20 арга хэмжээний хэрэгжилт 86,3 хувь;

“Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах салбар зөвлөлийн”-ийн хэрэгжилтийн дундаж 100 хувь;


“Нийтийн тээврийн бодлогын газрын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө”-ний 2024 оны жилийн эцсийн хэрэгжилтийн дундаж 98,3% байна.



1.1. “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд:

Тусгагдсан арга хэмжээ 9.2.13. Авто тээврийн хэрэгслээс ялгарч байгаа хорт бодисын хэмжээг бууруулж, гэр хорооллын дахин төлөвлөлтийн ажлыг эрчимжүүлэн, агаарын бохирдлын идэвхжил ихтэй бүсийг орон сууцжуулах асуудлыг шат дараатай, системтэй хэрэгжүүлж агаарын бохирдлыг бууруулна.

Нийслэлийн нийтийн тээврийн бодлогын газрын Даргын “Хаврын ээлжит техникийн хяналтын үзлэг зохион байгуулах тухай” 2024 оны А/37 дугаар тушаалаар батлагдсан хуваарийн дагуу үзлэгийг 2024 оны 04 дүгээр сарын 03-ны өдрөөс 05 дугаар сарын 24-ний өдрийн хооронд зохион байгуулан ажилласан.



Зураг №2. “Хаврын ээлжит техникийн хяналтын үзлэг зохион байгуулах тухай” тушаал

Нийслэлийн Засаг даргын Тамгын газар болон Yutong Bus Co.,Ltd хооронд 2023 оны 12 дугаар сарын 15-ны өдөр байгуулагдсан Нийтийн тээврийн автобус нийлүүлэх НЗДТГ/202310014 дугаартай гэрээнд захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэн, Нийслэлийн засаг даргын 2024 оны А/15 дугаар захирамжаар дээрх гэрээний дагуу нийлүүлэгдэх их багтаамжийн нийтийн тээврийн автобусыг чанар стандартад нийцүүлэн хүлээн авах ажилд дэмжлэг үзүүлэх, холбогдох заавар зөвлөмжөөр хангах, хяналт тавин ажиллахаар 2024 оны 01 дүгээр сарын 08-аас 2024 оны 02 дугаар сарын 05-ны өдөр хүртэл Нийтийн тээврийн газрын 3 албан хаагч, холбогдох албаныхны хамт Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Өвөр Монголын Өөртөө Засах орны Эрээн хотод очин захиалагчийн хяналт тавин, хуваарийн дагуу 565 автобус нийт 600 автобусыг Улаанбаатар хот хүртэл тээвэрлэх ажлыг зохион байгуулсан.

“Нийтийн тээврийн автобус (Улаанбаатар) төсөл арга хэмжээний хүрээнд байгуулагдсан “Нийтийн тээврийн автобус нийлүүлэх гэрээ”, НЗДТГ/202310014-02 дугаартай нэмэлт гэрээ”-нд заасан “Нийтийн тээврийн автобус нийлүүлэх нэмэлт гэрээ”-нд заасан чанар, стандарт, шаардлагад нийцсэн их багтаамжийн 31 автобусыг холбогдох хууль, журмын дагуу хүлээж авах үүрэг бүхий ажлын хэсгийн Нийслэлийн засаг даргын 2024 оны 09 дүгээр сарын 24-ний өдрийн А/1117 дугаар “Гадаад томилолтын тухай” захирамжийн хүрээнд Нийтийн тээврийн бодлогын газрын даргын 2024 оны 09 дүгээр сарын 24-ний өдрийн “Гадаадад томилолтоор ажиллуулах тухай А/111 дүгээр тушаалын батлагдаж, нийтийн тээврийн зориулалттай их багтаамжийн 31 автобусыг 2024 оны 09 дүгээр сарын 24-ний өдрөөс 2024 оны 10 дугаар сарын 02-ны хооронд техникийн тодорхойлолт, ажлын даалгаврын дагуу шалгаж, хүлээн авч үйлчилгээнд гаргаад байна.

1.2. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хэрэгжилт.

НЗДҮАХ-ийн 6.3. “Улаанбаатар хотын хөгжлийг хангасан, стандартад нийцсэн инженерийн дэд бүтцийг хөгжүүлж, эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэх, иргэдийн ая тухтай амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ.” гэсэн тэргүүлэх зорилтын хүрээнд:



1.2.1. Сурагчийн автобусны парк шинэчлэлт хийнэ. 6.3.13.1

Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, “Моннис Моторс” ХХК-тай байгуулсан НЗДТГ-20/А-463-2-01 дугаар гэрээний дагуу нийт 75 хүүхдийн сургуулийн автобус нийлүүлэхээс 2020 онд “Зорчигч тээвэр гурав” ОНӨААТҮГ-т сургуулийн хүүхдийн 5 автобус, 2022 онд сургуулийн хүүхдийн 20 автобусыг “Зорчигч тээврийн нэгтгэл” ОНӨААТҮГ-т, 2023 оны 02 дугаар сард сургуулийн 50 автобус шинээр орж ирснээр 2020-2023 онд сургуулийн 75 автобусаар парк шинэчлэлт хийсэн.



Зураг № 3. Сурагчийн автобусны парк шинэчлэлт

Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/110, А/546, А/1285 дугаар захирамжийн хүрээнд сургуулийн автобусны үйлчилгээнд ажилласан ОНӨААТҮГ-ын 2 аж ахуйн нэгж байгууллага, нийслэлийн 9 дүүргийн тээврийн хэрэгслийн ажлын гүйцэтгэлийн мэдээг тээвэр зохицуулагч нараас ирүүлсэн өдөр бүрийн мэдээллийг замын хуудастай тулгаж хяналт тавьж нэгтгэн сар бүрийн рейсийн гүйцэтгэлийн мэдээг Санхүү, аж ахуйн хэлтэст хүргүүлж ажилласан.

2023-2024 оны хичээлийн жилд 69 сургуулийн 58 чиглэлд сургуулийн хүүхдийн 58 автобусаар 1339493 сурагч тээвэрлэсэн байна.

2024-2025 оны хичээлийн шинэ жилд сургуулийн автобусны үйлчилгээнд Нийслэлийн 5 ОНӨААТҮГ, алслагдсан 3 дүүргээс 2024 оны 12 дугаар сарын байдлаар өссөн дүнгээр 83 сургуулийн 69 чиглэлд 69 сургуулийн хүүхдийн автобусаар 721210 хүүхэд тээвэрлэсэн байна.

Сургуулийн автобусны үйлчилгээний мэдээлэл

Хүснэгт 1

Сургуулийн автобусны рейсийн гүйцэтгэл /2022-2024/								
Он	Сар	ААНБ-ын тоо	Чиглэлийн тоо	Сургуулийн тоо	Тээврийн хэрэгслийн тоо	Ажилласан өдөр	Гүйцэтгэсэн рейс	Тээвэрлэсэн хүүхдийн тоо
2022	9	3	23	23	23	20	901.5	74431
	10	3	23	23	23	21	956.5	86994
	11	3	23	23	23	15	653.5	62905
	12	3	22	22	22	12	517.5	48423
2022 оны дүн							3029	272753
2023	1	2	19	22	22	18	729	64224
	3	2	19	22	19	18	681	59995
	4	11	69	86	57	20	1939.5	149890
	5	11	69	86	58	23	4531	165302
	6	4	21	43	21	6	286	4606
	9	11	56	51	56	20	4076	163664
	10	11	58	56	58	22	4381	190526
	11	11	53	56	53	16	3303	135434
2023 оны дүн							22984.5	1062300
2024	1	11	53	51	53	3	23619	158312
	2	11	54	51	54	20	763	186989
	3	11	58	56	58	20	730	153553
	4	11	58	69	58	17	661	171846
	5	11	57	67	57	22	843	26891
	6	11	43	53	43	10	358	721210
2024-2025 оны хичээлийн жил							3355	721210
2024	9	8	69	83	69	21	4990	164944
	10	8	62	77	62	22	4376.5	171406
	11	8	66	81	66	19	4902	185590
	12	8	65	80	65	20	5296	195406
	2024 оны 09-12 дугаар сарын дүн							19564.5
2024 оны 01-12 дугаар сарын дүн							22919.5	1438556
2022-2024 НИЙТ ДҮН							48933	2773609



Зураг № 5. Цахилгаан тээврийн хэрэгслийн ашиглалттай холбоотой асуудлаар уулзалт зохион байгуулж буй байдал

1.2.4. Нийтийн тээврийн үйлчилгээний автобусны парк шинэчлэлтийг олон улсын стандартад нийцүүлэн хийж гүйцэтгэнэ. 6.3.14.2.

Нийслэлийн нийтийн тээврийн парк шинэчлэлтийн ажлын хүрээнд:

2020 онд: 8 автобус

- Зорчигч тээврийн нэгтгэл” ОНӨААТҮГ нь БНХАУ-аас 2020 оны 01 дүгээр сард **8** их багтаамжийн /цахилгаан хөдөлгүүртэй автобус/

2021 онд: 35 автобус

- “Зорчигч тээвэр гурав” ОНӨААТҮГ нь Хөгжлийн банкны зээлийн хөрөнгөөр Бүгд Найрамдах Хятад Ард Улсаас 2021 оны 06 дугаар сард **35** их багтаамжийн автобус /цахилгаан хөдөлгүүртэй автобус/

2022 онд: 71 автобус

- **10** ширхэг давхар автобус /цахилгаан хөдөлгүүртэй автобус/
- **1** ширхэг их багтаамжийн цахилгаан автобус
- Xiamen golden dragon bus xml6105j15c загварын их багтаамжийн **60** автобус /Дизель/

2023 онд: 364 автобус

1. **224** /Дизель/
2. 55 ширхэг автобус /цахилгаан хөдөлгүүртэй автобус/ -/20 Дарханд өгсөн./
3. 35 ширхэг автобус /Дизель/
4. 50 ширхэг каунти /Дизель/


2024 онд: 596 Дизель

1. **565** автобус /Дизель/
2. **31** их багтаамжийн угсраа автобус /Дизель евро-5 хөдөлгүүртэй/

Парк шинэчлэлтийн хүрээнд нийлүүлэгдсэн автобусны тоо

Хүснэгт 2

Д/д	Евро-5 /Дизель/	Цахилгаан	Нийт
2020		8	8
2021		35	35
2022	60	11	71
2023	224+35+50	55	364
2024	565+31		596
Нийт	965	109	1074





Зураг № 6. Шинээр нийлүүлэгдсэн их багтаамжийн угсраа 31 автобусыг нийтийн тээврийн үйлчилгээнд гаргасан байдал

1.2.4.1. “Нийтийн тээврийн автобус (Улаанбаатар) төсөл арга хэмжээний хүрээнд байгуулагдсан НЗДТГ/202310014 дугаартай “Нийтийн тээврийн автобус нийлүүлэх гэрээ”-ний хэрэгжилт.

Нийслэлийн Засаг даргын Тамгын газар “Тэнүүн-Огоо” ХХК-тай 2023 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн Нийтийн тээврийн автобус худалдан авах ННТГ23001 дугаартай гэрээ, 2023 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн Нийтийн тээврийн автобус худалдан авах ННТГ23001-01 дугаартай нэмэлт гэрээг хэсэгчлэн цуцалсантай холбогдуулан Нийслэлийн Засаг даргын 2023 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн Эрх шилжүүлэх тухай А/1224 дугаартай захирамж батлагдсан. Улсын төсвийн хөрөнгөөр 2023 онд Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах ажлын хүрээнд их багтаамжийн дизель хөдөлгүүртэй 600 автобус худалдан авах ажиллагааг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулахаар 2023 оны 10 дугаар сарын 24-ний өдрөөс 1 сарын хугацаатай олон улсын тендер нээлттэй зарлан, Yutong Bus Co.,Ltd шалгарсан.

Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах зорилгоор Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж буй “Нийтийн тээврийн автобус (Улаанбаатар) төсөл арга хэмжээний хүрээнд байгуулагдсан НЗДТГ/202310014 дугаартай “Нийтийн тээврийн автобус нийлүүлэх гэрээ”-нд заасан чанар, стандарт, шаардлагад нийцсэн их багтамжийн автобусыг холбогдох хууль, журмын дагуу хүлээж авах үүрэг бүхий ажлын хэсэг Нийслэлийн засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн А/1458 дугаартай захирамжаар байгуулагдсан.

Дээрх ажлын хэсэг 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдөр хуралдан их багтаамжийн автобус хүлээлцэх ажлын календарчилсан төлөвлөгөө гарган, 2023 оны 12 дугаар сарын 27-аас 28 өдрүүдэд Бүгд Найрамдах Хятад Ард Улсын эрээн хотод очиж Yutong Bus Co.,Ltd-ийн үйлдвэрлэсэн их багтаамжийн дизель евро-5 хөдөлгүүртэй 35 ширхэг автобус хүлээн авч, үйлчилгээнд гаргасан.

Нийслэлийн Засаг даргын тамгын газар болон Yutong Bus Co.,Ltd хооронд 2023 оны 12 дугаар сарын 15-ны өдөр байгуулагдсан Нийтийн тээврийн автобус нийлүүлэх НЗДТГ/202310014 дугаартай гэрээнд захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэн, Нийслэлийн засаг даргын 2024 оны А/15 дугаар захирамжаар дээрх гэрээний дагуу нийлүүлэгдэх их багтаамжийн нийтийн тээврийн автобусыг чанар стандартад нийцүүлэн хүлээн авах ажилд дэмжлэг үзүүлэх, холбогдох заавар зөвлөмжөөр хангах, хяналт тавин ажиллахаар 2024 оны 01 дүгээр сарын 08-аас 2024 оны 02 дугаар сарын 05-ны өдөр хүртэл Нийтийн тээврийн газрын 3 албан хаагч, холбогдох албаныхны хамт Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Өвөр Монголын Өөртөө Засах орны Эрээн хотод очин захиалагчийн хяналт тавин, хуваарийн дагуу 565 автобус, мөн “Нийтийн тээврийн автобус (Улаанбаатар) төсөл арга хэмжээний хүрээнд байгуулагдсан “Нийтийн тээврийн автобус нийлүүлэх гэрээ”, НЗДТГ/202310014-02 дугаартай нэмэлт гэрээ”-нд заасан “Нийтийн тээврийн автобус нийлүүлэх нэмэлт гэрээ”-нд заасан чанар, стандарт, шаардлагад нийцсэн их багтаамжийн 31 автобусыг холбогдох хууль, журмын дагуу хүлээж авах үүрэг бүхий ажлын хэсгийн Нийслэлийн засаг даргын 2024 оны 09 дүгээр сарын 24-ний өдрийн А/1117 дугаар “Гадаад томилолтын тухай” захирамжийн хүрээнд Нийтийн




тээврийн бодлогын газрын даргын 2024 оны 09 дүгээр сарын 24-ний өдрийн “Гадаадад томиллолтоор ажиллуулах тухай А/111 дүгээр тушаалын батлагдаж, нийтийн тээврийн зориулалттай их багтаамжийн 31 автобусыг 2024 оны 09 дүгээр сарын 24-ний өдрөөс 2024 оны 10 дугаар сарын 02-ны хооронд техникийн тодорхойлолт, ажлын даалгаврын дагуу шалгаж, хүлээн авч үйлчилгээнд гаргаад байна.



Зураг № 7. СХД 22 дугаар хороо, Тахилтын "Зорчигч тээвэр гурав" ОНӨААТҮГ-ын шинэ авто баазад автобус байршуулсан байдал



Зураг № 8. ХУД "Зорчигч тээврийн нэгтгэл" ОНӨААТҮГ-ын 1 дүгээр баазад автобус байршуулахын өмнөх байдал



Зураг № 9. Шинээр нийлүүлэгдсэн автобусанд төлбөрийн систем суурилуулж буй байдал



Зураг № 10. Шинээр нийлүүлэгдсэн автобусыг нийтийн тээврийн үйлчилгээнд гаргасан байдал


Нийтийн тээврийн автобусны даатгалын зардалд 2.9 тэрбум төгрөг батлагдсанаас YUTONG маркийн 589 автобусны 1 жил 2 сарын даатгалын төлбөрт 1.6 тэрбум төгрөг, 47 ш каунти автобусны даатгалын төлбөрт 85.1 сая төгрөг, YUTONG маркийн 31 угсраа автобусны даатгалын төлбөрт 172.2 сая төгрөг буюу нийт 1.8 тэрбум төгрөгийг зарцуулж 1.1 тэрбум төгрөгийн хэмнэлт гаргасан.



Зураг № 11. Их багтаамжийн ЕВРО-5 дизель хөдөлгүүртэй угсраа автобусны тоноглоудыг шалгаж байгаа нь.



Шинээр орж ирсэн Yutong маркийн угсраа автобуснуудыг Улаанбаатар хотын авто замын сүлжээнд тулгуурлан огцом эргэлт багатай, өгсүүр хэсэггүй, шулуун авто замаар зорчдог нийтийн тээврийн үйлчилгээний М:1 “5 шар-Офицеруудын ордон”, М:3 “Архивын ерөнхий газар-120 мянгат-Сүхбаатарын талбай” чиглэлүүдийг сонгон, мөн иргэдийн зорчилт хөдөлгөөн ихтэй чиглэлийн замналд үйлчилгээнд гаргасан.



Зураг № 12. Их багтаамжийн ЕВРО-5 дизель хөдөлгүүртэй угсраа автобусны үйлчилгээний чиглэл маршрут

1.2.5. Ачаа тээврийн удирдлагын системийн нэмэлт хөгжүүлэлтийн программ хангамж боловсруулж, ачаа тээвэрлэлт, түгээлтийн үйл ажиллагааг үе шаттайгаар шөнийн горимд шилжүүлнэ. НЗДҮАХ 6.3.18

Ачаа тээврийн түгээлтийн эрх зүйн орчныг бүрдүүлэх ажлын хүрээнд:

1. Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгж, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба хамтран 2023 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн 12 цагаас Соёлын төв өргөөнд “Тээвэр логистикийн оновчтой шийдэл” сэдвээр худалдаа үйлчилгээ эрхлэгчидтэй уулзалтыг зохион байгуулсан. Уулзалтад 9 дүүргийн худалдаа үйлчилгээ эрхлэгч 700 гаруй байгууллагын төлөөлөл оролцсон. Уулзалтаар бараа бүтээгдэхүүний шөнийн түгээлтийн талаар санал асуулга явуулахад худалдаа үйлчилгээ эрхлэгчдийн дийлэнх хувь нь боломжгүй гэсэн хариуг өгсөн. Уулзалт дээр Нийслэлийн Засаг дарга Х.Нямбаатар шөнийн түгээлтийг хийхгүй байхаар шийдвэр өгсөн.



Зураг №13. Соёлын төв өргөө, “Тээвэр, логистик оновчтой шийдэл” хэлэлцүүлэг

1.2.5.1. НИТХ-102 дугаар тогтоолд нэмэлт өөрчлөлт оруулан НЗД-аар батлуулна.

Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/1381 дүгээр захирамжийн хавсралтаар баталсан Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон



сууцжуулах тухай хууль, “Нийслэлийн нутаг дэвсгэрийн замын хөдөлгөөнд ачааны, түгээлт, хүргэлтийн үйлчилгээний автомашиныг хязгаарлалттайгаар оролцуулах, дэмжлэг үзүүлэх журам”-ын төслийг 2024 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн 01/04/1247 дугаартай албан бичиг, 2024 оны 08 дугаар сарын 29-ний өдрийн 02/04/2134 дугаартай албан бичгээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын хууль тогтоомж, гэрээ, эрх зүйн газарт тус тус хүргүүлсэн.

Шинэчлэн боловсруулсан журмын хууль, эрх зүйн үндэслэл, журамд тусгасан саналын дэлгэрэнгүй хэлэлцүүлгийг 2024 оны 05 дугаар сарын 06-ны өдөр зохион байгуулж хэлэлцүүлэгт Зам, тээврийн хөгжлийн яам, Тээврийн цагдаагийн алба, Нийслэлийн замын хөгжлийн газар, Замын хөдөлгөөний удирдлагын төв ОНӨТҮГ холбогдох мэргэжлийн байгууллагууд оролцсон.

Нийслэлийн засаг даргын Тамгын газрын Хууль тогтоомж, гэрээ, эрх зүйн газрын Эрх зүйн бодлого, зохицуулалтын газраас ирүүлсэн зөвлөмжийн хүрээнд 2023 оны 04 дүгээр сарын 11-ний өдрөөс 2024 оны 10 дугаар сарын 21-ний өдрөөс 23 хоногийн хугацаанд Нийтийн тээврийн бодлогын газрын <https://transport.ub.gov.mn/> сайтад байршуулан 232 иргэд танилцан санал өгч, 198 буюу 85,5% саналтайгаар дэмжигдсэн байна.

Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйлд Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч нь энэ зүйлийн 22.1.13 дахь заалтыг үндэслэн шинэчилсэн журмыг Нийслэлийн засаг даргын захирамжаар батлуулах саналын төслийг боловсруулан Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын дарга нараас санал авч дэмжигдсэн. 2024 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулан, дэмжигдсэн.

1.2.5.2. “Нийслэлийн гудамж, замын хөдөлгөөнд ачааны автомашиныг цагийн хязгаартайгаар оролцуулах, түр зөвшөөрөл олгох журам”-ыг шинэчлэн боловсруулах тухай.

Журмыг шинэчлэн боловсруулах үндэслэл:

Нийслэлийн Засаг даргын Зөвлөлийн 2023 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн 05 дугаар хуралдааны тэмдэглэлд тус журмыг Захиргааны ерөнхий хуульд нийцүүлэн, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.5 дахь хэсэгт заасны дагуу Нийслэлийн Засаг даргын захирамжаар батлуулахыг үүрэг болгосон, мөн Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах Үндэсний хорооны 2023 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 02 дугаар хуралдаанаас уг журмыг хүчингүй болгох зөвлөмж ирсэн.

Захиргааны ерөнхий хууль, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хууль, Монгол Улсын Замын хөдөлгөөний дүрэм, Ачаа тээвэрлэх дүрэм, “Автотээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих ерөнхий шаардлага” MNS 4598:2020 стандарт зэрэг хууль эрх зүйн орчин шинэчлэгдсэн.

Автотээврийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.4, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.5 дахь хэсэгт заасны дагуу нийслэлийн нутаг дэвсгэрт ачаа тээврийн үйлчилгээ эрхэлж буй иргэн, хуулийн этгээдийн тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд зохицуулалт хийх замаар замын хөдөлгөөний түгжрэл, саатлыг бууруулахад дэмжлэг үзүүлэх зорилгоор тус журмыг шинэчлэн боловсруулсан.

Нийслэлийн гудамж замын хөдөлгөөний ачаалал, нягтралын бүсэд өөрчлөлт орж, хүн амын суурьшлын бүсүүд шинээр бий болсноор зарим шаардлагатай гудамж, замыг хамруулах, тэмдэг, тэмдэглэлээр зохицуулах, түүнчлэн төв замын зөвшөөрөл олгох үйл ажиллагааг цахимжуулсантай холбоотойгоор зарим төрлийн үйл ажиллагаанд өөрчлөлт орсон зэргээс шалтгаалан дээрх журмыг Нийслэлийн Засаг даргын захирамжаар батлах хэрэгцээ шаардлага үүсээд байна.

Хууль эрх зүйн орчны талаар:

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 102 дугаар тогтоолоор баталсан захиргааны хэм хэмжээний актад бүртгэгдээгүй “Нийслэлийн гудамж, замын хөдөлгөөнд ачааны автомашиныг цагийн хязгаарлалттайгаар оролцуулах, түр зөвшөөрөл олгох журам”-ыг баримтлан ажиллаж байна.

Дээрх журмыг баталсан Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 102 дугаар тогтоолын үндэслэл нь 2006 оны Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.3, 20.1.7 дахь эрх зүйн зохицуулалт байх бөгөөд энэ хуулийг 2020 оны 12 дугаар сарын 24-ний өдөр баталсан Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль



/Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн эхлэн хүчингүй болсонд тооцсон.

2020 оны Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай /шинэчилсэн найруулга/ хуулийн 35 дугаар зүйлийн 35.2 дахь хэсэгт “Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал дараах журмыг батална.” гэж захиргааны хэм хэмжээний акт батлах тусгайлсан эрхийг олгосон жагсаалтад “Нийслэлийн гудамж, замын хөдөлгөөнд ачааны автомашиныг цагийн хязгаарлалттайгаар оролцуулах, түр зөвшөөрөл олгох журам” тусгагдаагүй байна.

Иймд Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 102 дугаар тогтоолоор баталсан “Нийслэлийн гудамж, замын хөдөлгөөнд ачааны автомашиныг цагийн хязгаарлалттай оролцуулах түр зөвшөөрөл олгох журам”-ыг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоолоор хүчингүй болгох хууль зүйн үр дагавар бий болсон байна.


“Нийслэлийн нутаг дэвсгэрийн замын хөдөлгөөнд ачааны, түгээлт, хүргэлтийн үйлчилгээний автомашиныг хязгаарлалттайгаар оролцуулах, дэмжлэг үзүүлэх журам”-ын шинэчлэн боловсруулсан төслийн танилцуулга, хэлэлцүүлгийг зохион байгуулсан.



Зураг №14. НТБГ-ын хурлын танхим хэлэлцүүлэг

Тус газрын Захиргаа, удирдлагын хэлтсийн дарга З.Цэвээндорж, Ачаа тээвэр, логистикийн хэлтсийн ахлах мэргэжилтэн Ч.Ариунтуяа, мэргэжилтэн Ц.Базаррагчаа, Зам, тээврийн хөгжлийн яамны Автотээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын ахлах мэргэжилтэн З. Чүнсэрээ, Тээврийн цагдаагийн албаны Замын цагдаагийн газрын Зам, тээврийн хяналтын хэлтсийн дарга, цагдаагийн хурандаа М.Ариунболд, ахлах зохицуулагч хошууч Б.Амарсанаа, ахлах зохицуулагч ахмад Б.Мөнгөн, Нийслэлийн замын хөгжлийн газрын засвар арчлалтын хяналтын хэлтсийн ахлах мэргэжилтэн Б.Ганбат, Б.Ширэндэв, Замын хөдөлгөөний удирдлагын төв ОНӨТҮГ-ын хөдөлгөөн зохицуулалт, хяналтын хэлтсийн дарга Н.Намуу нар оролцож санал солилцлоо.

Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/1381 дүгээр Захирамжийн хавсралтаар баталсан Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хууль болон дагалдан гарсан бусад хуулиудад тусгагдсаны дагуу боловсруулах шаардлагатай баримт бичгийн жагсаалтын 11 дэх хэсэгт заасан “Нийслэлийн нутаг дэвсгэрийн замын хөдөлгөөнд ачааны, түгээлт, хүргэлтийн үйлчилгээний автомашиныг хязгаарлалттайгаар оролцуулах, дэмжлэг үзүүлэх журам”-ын төслийг боловсруулаад байна.



Зураг №15. НЗДТГ-т хүргүүлсэн албан бичиг

1.3. Шинэ техник, технологийг нутагшуулах, системийн хэвийн ажиллагааг хангах

Нийтийн тээврийн удирдлагын төвийг шинэчлэх ТЭЗҮ болон зураг төсөл боловсруулах зөвлөх үйлчилгээний ажлыг гүйцэтгүүлэхээр Улаанбаатар хотын тогтвортой авто зам, тээврийн төслийн нэгжтэй хамтран ажиллаж байна. Төслийн нэгжээс нийтийн тээврийн удирдлагын төвийн ТЭЗҮ болон зураг төсөл боловсруулах зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендер шалгаруулалтыг дахин зарлахаар бэлтгэсэн бөгөөд тус газраас ажлын даалгаварт тусгах саналыг хүргүүлж, төслийн нэгжээс ажлын даалгаврыг шинэчилж, өөрчлөлт оруулсан ажлын даалгавар болон сонирхлоо илэрхийлэх хүсэлтийн зарлалыг Дэлхийн банкаар хянуулахаар 2024 оны 05 дугаар сарын 17-ны өдөр хүргүүлсэн байна. Нийтийн тээврийн үйлчилгээний төлбөрийн менежментийн системийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд автобуснуудад зорчигч тоолох систем, онлайн камерыг суурилуулсан.

UB карт аппликейшн хөгжүүлэлтийг эхлүүлж, тус аппликейшнаар “QR” код уншуулж сайжруулсан түлшийг борлуулалтын цэгээс авдаг байх талаар 2024 оны 10 дугаар сарын 31-ний 01/03/2777 дугаартай албан бичгээр хамтарч ажиллах хүсэлтийг Ай Си Ти групп ХК-нд хүргүүлсэн.

Нийслэлийн Агаарын бохирдолтой тэмцэх газрын дарга Б.Мөнхбаатар, Ай Си Ти групп ХК-ийн гүйцэтгэх захирал А.Баттамир нартай 2024 оны 11 дүгээр сарын 07-ны өдөр уулзалт зохион байгуулж, UB картыг иргэд сайжруулсан түлш худалдан авахдаа ашиглах болон Таван толгой түлш ХХК-ийн VTGT систем, UB карт аппликейшныг холбох боломжийн талаар хэлэлцсэн.

Удирдлага, мэдээллийн болон цахим төлбөрийн системийн программ хангамжийн мэдээлэлд тулгуурлан нийтийн тээврийн үйлчилгээнд ажилласан нийт тээврийн хэрэгслүүдийн өдөр тутмын ажлын гүйцэтгэлд бүртгэлээр хяналт тавьж Улаанбаатар смарт карт ХХК-аас гарган ирүүлсэн 2024 оны эхний 11 сарын нийтийн тээврийн үйлчилгээний чиглэл бүрийн рейсийн болон цагийн гүйцэтгэл, тээврийн хэрэгсэл, цаг, рейсийн гүйцэтгэлийн хувь, нэмэгдэж хасагдсан цагийн тооцоог системийн мэдээлэлтэй тулган шалгаж, нэгтгэн гаргасан.

2024 оны эхнээс 11 сарын 20-ны байдлаар хөдөлгөөнд оролцоогүй сул зогссон боловч ажлын гүйцэтгэлд тооцогдсон 3905 зөрчлийн 1038 цагийн гүйцэтгэлийг ажлын гүйцэтгэлээс хасч тооцуулсан.

Удирдлага, мэдээллийн болон цахим төлбөрийн системээр нийтийн тээврийн үйлчилгээний автобусны хөдөлгөөн бүртгэл /GPS-ын мэдээлэл/ болон цахим төлбөртэй /цахим төлбөрийн мэдээлэл/ холбоотой цугларсан мэдээллийг холбогдох төрийн байгууллагын серверт байршуулж мэдээллийн сан үүсгэнэ. Мөн нийслэлийн мэдээллийн нэгдсэн сан болох “ХУР” системд шаардлагатай өгөгдлөөр хангаж хамтран ажиллах арга хэмжээний хүрээнд Нийслэлийн Цахим хөгжил мэдээллийн технологийн газрын хөгжүүлж буй “Нэг тархи нэг систем” төслийн хүрээнд Удирдлага, мэдээллийн болон цахим төлбөрийн



системээр цугларсан GPS болон цахим төлбөрийн мэдээллийг Нийслэлийн дата төвд байршуулж холбогдох газруудыг шаардлагатай мэдээллээр ханган ажиллаж байна.

Танилт нэвтрэлтийн ДАН систем ашиглан нэвтрэч санал хүсэлт, өргөдөл гомдол илгээх боломжтой болсон.


Нийслэлийн мэдээллийн нэгдсэн сан болох “ХУР” системд холбогдож шаардлагатай өгөгдлөөр хангаж ажиллаж байна.

Азийн хөгжлийн банкны төсөл хэрэгжүүлэгч Инфокон ХХК-тай төслийн тайлангийн явцтай танилцах уулзалтад оролцсон.

Системтэй танилцах 2 удаагийн уулзалт зохион байгуулж, мэдээллийн сангийн шинэчилсэн программыг турших ажиллагаа хийгдэж байна. Нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч 18 аж ахуйн нэгж, байгууллагын 47, такси, буухиа үйлчилгээний 12 аж ахуйн нэгж, байгууллагын 17 ажилтан албан хаагчдад мэдээллийн нэгдсэн санд нэвтрэх эрхийг олгуулсан.

Мэдээллийн нэгдсэн сангийн мэдээллийг шинэчлэх ажилтай холбогдуулж 2024 оны 03 дугаар сарын 20, 2024 оны 04 дүгээр сарын 15, 2024 оны 04 дүгээр сарын 29-ний өдрүүдэд бүртгэлийн санд бүртгэлтэй байгууллагуудын нэр регистр, жолоочийн нэр, регистр, тээврийн хэрэгслийн мэдээллийг хүргүүлсэн. Мөн бүртгэлийн санд бүртгэлтэй такси, хүүхдийн болон ажилчдын автобус, жолоочийн нэр, регистр дугаар зэрэг мэдээллийг хүргүүлж ажилласан. 2024 оны 08 дугаар сарын 05-ны өдөр Азийн хөгжлийн банкны төсөл хэрэгжүүлэгч нарын төслийн товч танилцуулга дээр сууж, одоогийн ашиглаж буй бүртгэлийн сангийн мэдээллийг шинэчлэх, даалгаврын талаар мэдээллийг өгч санал солилцсон. Азийн хөгжлийн банкны төсөл хэрэгжүүлэгч Инфокон ХХК-нд системтэй холбоотой сайжруулах шаардлагатай мэдээг удаа дараа цахимаар хүргэсэн. Мэдээллийн сангийн шинэчилсэн программыг турших ажиллагаа хийгдэж ААНБ-уудаас ирүүлсэн жолооч болон тээврийн хэрэгслийн мэдээг баталгаажуулж, системийн ажиллагаанд хяналт тавин ажилласан.

Өргөдөл гомдлын мэдээллийн санг бусад мэдээллүүдтэй нь холбох зорилгоор тээврийн хэрэгслийн, жолоочийн, хүний нөөцийн, зөрчлийн санал хүсэлт, өргөдөл, гомдол талархлын, чиглэл, зогсоолын зэрэг 6 төрлийн мэдээллийн сангийн хөгжүүлэлт хийгдэж дууссан бөгөөд нийт зөрчлийн тайлангийн модулийн хөгжүүлэлт дуусч Нийтийн тээврийн мэдээллийн нэгдсэн системийг танилцуулах, ашиглалтын талаарх зааварчилгаа өгөх 2 удаагийн сургалтыг зохион байгуулав.



Зураг №16. Мэдээллийн санд үүсгэсэн жолооч бүртгэх хэсэг

Нийтийн тээврийн үйлчилгээнд төлбөр тооцооны шинэ систем нэвтрүүлэх ажлын хүрээнд иргэд нийтийн тээврээр зорчихдоо банкны картаар болон бэлэн мөнгөөр зорчих боломжийг бүрдүүлсэн. Төлбөр төлөх олон хэлбэрийг нэвтрүүлснээр 2024 оны эхний 11 сарын байдлаар 1,5 тэрбум төгрөгийн орлогыг нэмж төвлөрүүлсэн.




2024 оны банкны картаар зорчилтын мэдээ

Хүснэгт 3

Д/д	Огноо	Зорчигчийн тоо	Орлого
1	2024.07	65	294,220.00
2	2024.08	6910	3,142,518
3	2024.09	18914	9,661,099
4	2024.10	75,133	37,343,580
5	2024.11	181,128	93,181,830
Дүн		282150	143,623,247.0

График 1



2024 оны бэлэн мөнгөөр зорчилтын мэдээ

Хүснэгт 4


Д/д	Огноо	Зорчигчийн тоо	Орлого
1	2024.05	45248	11,370,910.0
2	2024.06	374213	190,024,593.0
3	2024.07	297200	236,862,636.0
4	2024.08	565708	283,862,636.0
5	2024.09	555453	294,326,506.0
6	2024.10	663985	331,992,385.0
Дүн		2,501,807	1,348,439,666.0

1.3.1. Нийтийн тээврийн үйлчилгээний хөдөлгөөний бүртгэл, мэдээлэл хяналт, зохицуулалтын удирдлагын төв байгуулна. НЗДҮАХ 6.3.19

Нийтийн тээврийн удирдлагын төвийг шинэчлэх ТЭЗҮ болон зураг төсөл боловсруулах зөвлөх үйлчилгээний ажлыг гүйцэтгүүлэхээр Улаанбаатар хотын тогтвортой авто зам, тээврийн төслийн нэгжтэй хамтран ажиллаж байна.



Төслийн нэгжээс нийтийн тээврийн удирдлагын төвийн ТЭЗҮ болон зураг төсөл боловсруулах зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендер шалгаруулалтыг дахин зарлахаар бэлтгэсэн бөгөөд тус газраас ажлын даалгаварт тусгах саналыг хүргүүлж, төслийн нэгжээс ажлын даалгаврыг шинэчилж, өөрчлөлт оруулсан ажлын даалгавар болон сонирхлоо илэрхийлэх хүсэлтийн зарлалыг Дэлхийн банкаар хянуулахаар 2024 оны 05 дугаар сарын 17-ны өдөр хүргүүлсэн.


Нийслэлийн нутгийн захиргааны байрны Б блокийн 4-р давхарт 2024 оны 07 дугаар сард Нийтийн тээврийн бодлогын газар нүүж ирсэнтэй холбогдуулан тээвэр зохицуулагч нарыг 2024 оны 08 дугаар сарын 19-ний өдөр нүүлгэж ирүүлсэн.



Зураг №17. Удирдлагын төвийн өрөө

Улмаар Нийтийн тээврийн төлбөрийн менежментийн системийг хэрэгжүүлэх төслийн хүрээнд Нийслэлийн нутгийн захиргааны байрны Б блокийн 1-р давхарт “Тээврийн удирдлагын төв”-д дэлгэц, дэлгэцийн гадна дизайн, дотор засал чимэглэл, интернэтийн давхар хоорондын сүлжээг хийж, цахилгааны хүчин чадлыг нэмэгдүүлэн өндөр хүчин чадалтай компьютер суурилуулж 2024 оны 09 дүгээр сарын 17-ны өдрөөс үйл ажиллагааг эхлүүлсэн.





Зураг №18. Удирдлагын төвийн хяналтын дэлгэц

1.3.2.Удирдлага, мэдээллийн болон цахим төлбөрийн системийн программ хангамжийн мэдээлэлд тулгуурлан нийтийн тээврийн үйлчилгээнд ажилласан нийт тээврийн хэрэгслүүдийн өдөр тутмын ажлын гүйцэтгэлд бүртгэлээр хяналт тавих.

Улаанбаатар смарт карт ХХК-аас ирүүлсэн 2024 оны эхний 10 сарын нийтийн тээврийн үйлчилгээний чиглэл бүрийн рейсийн болон цагийн гүйцэтгэл, тээврийн хэрэгсэл, цаг, рейсийн гүйцэтгэлийн хувь, нэмэгдэж хасагдсан цагийн тооцоог системийн мэдээлэлтэй тулган шалгаж, нэгтгэн гаргасан.

2024 оны эхнээс 11 сарын 20-ны байдлаар хөдөлгөөнд оролцоогүй сул зогссон боловч ажлын гүйцэтгэлд тооцогдсон 3905 зөрчлийн 1038 цагийн гүйцэтгэлийг ажлын гүйцэтгэлээс хасч тооцуулсан.

Удаан зогссон зөрчлөөр хасагдсан цаг

Хүснэгт 5

Үзүүлэлт		1 сар	2 сар	3 сар	4 сар	5 сар	6 сар	7 сар	8 сар	9 сар	10 сар	11 сар	Нийт дүн
Тээвэр зохицуулагчид хяналт тавьсан	Зөрчлийн тоо	526	430	416	403	376	379	230	326	309	315	195	3905
	Хасагдах цаг	144:15:00	119:42:00	121:34:00	104:23:00	105:03:00	97:13:00	56:55:00	53:51:00	89:22:00	89:52:00	56:36:00	1038:46:00
Нийт дүн	Зөрчлийн тоо	526	430	416	403	376	379	230	326	309	315	195	3905
	Хасагдах цаг	144:15:00	119:42:00	121:34:00	104:23:00	105:03:00	97:13:00	56:55:00	53:51:00	89:22:00	89:52:00	56:36:00	1038:46:00

Нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч 16 аж ахуйн нэгж байгууллагын өссөн дүнгээр 21 чиглэлийн 102 зогсоолын зогсоол хоорондын хугацаанд өөрчлөлт оруулах саналыг Тээврийн бодлого, судалгааны хэлтэст гарган өгч холбогдох өөрчлөлтийн оруулж, ажлын гүйцэтгэл үнэн зөв тооцогдох нөхцөлийг ханган ажилласан.

Зогсоол хоорондын хугацаанд өөрчлөлт оруулахаар Тээврийн бодлого, судалгааны хэлтэс өгсөн саналын тоо

Хүснэгт 6

Сар	ААНБ	Чиглэл	Зогсоол
2	2	6	26
3	3	3	7
4	5	3	16
5	1	1	8
8	5	8	45
НИЙТ	16	21	102

Зам засвар, шинэчлэлтийн ажилтай холбоотой тухайн авто замыг дайран өнгөрөх нийтийн тээврийн чиглэлүүдийн ажлын гүйцэтгэлийг системээс хянаж Тээврийн бодлого, судалгааны хэлтсээс Улаанбаатар смарт карт ХХК-д зам засвартай холбоотой ажлын



гүйцэтгэл тооцох 11 удаагийн албан бичгийн төсөлд саналаа өгч ажлын гүйцэтгэл үнэн зөв тооцогдох нөхцөлийг ханган ажилласан.

Авто замын ачаалал, цаг агаар, зам засвар шинэчлэлтийн ажлуудаас шалтгаалж оройн буултын цагаас хоцорч буух өөр зогсоолд буух зөрчлүүдийн мэдээ, судалгааг гаргаж эхний байдлаар саналаа танилцуулсан.

2023-2024 оны буух цэгийн зөрчил (04-09 дүгээр сар)

Хүснэгт 7

Он	Үзүүлэлт	4 сар	5 сар	6 сар	7 сар	8 сар	9 сар	Нийт
2023	Зөрчлийн тоо	530	1774	1685	1266	1873	1819	8947
	Хасагдсан минут	27242	89332	84450	63047	93290	91001	448362
2024	Зөрчлийн тоо	1353	1216	968	813	1075	1345	6770
	Хасагдсан минут	60818	58307	45459	38148	52467	64079	319278

2023-2024 оны 1-09-р сарын буух цэгийн зөрчил

График 2



Графикаас харахад 2024 оны буух цэгийн зөрчлийн тоо, зөрчлөөр хасагдсан минут 2023 оноос буурсан үзүүлэлттэй харагдаж байна.

Тэвэр зохицуулагч нараас 7 хоног бүр ажил үйлчилгээ сайжруулах, зөрчлийг давтан гаргахгүй ажиллах талаар аж ахуйн нэгж байгууллагад хүргүүлсэн мэдэгдлийн хүрээнд сар тутам ажлын гүйцэтгэлд нь хяналт тавьж машин цаг, рейсийн судалгаа гаргаж танилцуулсан.

Тайлант хугацаанд 01, 02, 03, 04, 05 дугаар саруудын цаг рейсийн судалгааг 3 удаа харьцуулж гаргасан.

2024 оны 01,02 дугаар сарын ажлын гүйцэтгэлийг харьцуулахад тээврийн хэрэгслийн гүйцэтгэл 1,2 хувиар өссөн, машин цагийн гүйцэтгэл 0,3 хувиар буурсан үзүүлэлттэй гарсан.

2024.01-2024.02 саруудын харьцуулсан мэдээ

(Тээврийн хэрэгсэл, цаг рейсийн хувь)

Хүснэгт 8

№	Аж ахуйн нэгж байгууллага	01 дүгээр сар					02 дугаар сар					01-02 дугаар сар харьцуулсан		
		Явуулсан бичгийн тоо	Хариу ирүүлсэн тоо	Гүйцэтгэлийн хувь			Явуулсан бичгийн тоо	Хариу ирүүлсэн тоо	Гүйцэтгэлийн хувь			Тээврийн хэрэгслийн гүйцэтгэл /хувь/	Машин цагийн гүйцэтгэл /хувь/	Рейсийн гүйцэтгэл /хувь/
				Тээврийн хэрэгсэл	Цаг	Рейс			Тээврийн хэрэгсэл	Цаг	Рейс			
0	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14
1	Зорчигч тээврийн нэгтгэл ОНӨААТҮГ	5	5	95.1	90.9	63.9	4	4	88.7	81.0	57.0	-6.5	-9.9	-6.9
2	Зорчигч тээвэр гурав ОНӨААТҮГ	5	3	88.9	82.9	58.1	4	4	93.6	84.9	62.3	4.8	2.0	4.3
3	Автобус нэгдэл ХХК	5	2	74.3	69.4	54.9	4	1	93.5	85.3	77.8	19.2	15.9	22.9
4	Автотерминал ХХК	5	3	98.0	90.5	62.3	4	3	94.6	87.2	56.7	-3.4	-3.3	-5.5
5	Дюц ХХК	5	0	61.9	55.5	44.1	4	0	76.3	67.3	53.7	14.4	11.8	9.6
6	Сутайн буянт ХХК	5	3	94.8	88.4	60.9	4	4	98.2	93.8	65.7	3.4	5.4	4.8
7	Мярапзаа ХХК	5	4	86.9	76.2	59.1	4	4	93.1	83.4	64.2	6.2	7.2	5.0
8	Трансбус ХХК	5	1	85.1	74.7	56.6	4	1	87.5	75.6	54.6	2.3	0.9	-2.1
9	Эрдэмтранс ХХК	5	4	91.0	81.9	59.1	4	4	95.0	82.3	59.4	4.0	0.4	0.3
10	Тэнүүн огоо ХХК	5	2	81.5	68.4	46.0	4	0	90.7	75	50.2	9.2	6.6	4.2
11	Тэнүүн огоо гуравдугаар бааз ХХК	5	2	90.5	78.2	57.1	4	0	94.7	83.6	58.4	4.2	5.4	1.4
12	ГБУС ХХК	5	4	73.6	59.8	41.2	4	0	82.1	69.2	51.0	8.5	9.4	9.8
13	Блюбус ХХК	5	0	96.9	89.6	68.8	4	2	89.4	82.2	64.8	-7.5	-7.4	-4.0
14	Эмсид ХХК	5	5	91.0	80.6	64.3	4	4	98.4	92	82.2	7.4	11.4	17.9
15	Сайхан ирээдүй ХХК	5	0	98.9	91.8	83.9	4	1	98.3	93.4	76.9	-0.6	1.6	-7.0
16	Эс энд эй транс ХХК	3	1	100.0	98.6	71.3	0	0	100.0	98.5	73.9	0.0	-0.1	2.6
17	Үнэгтийн уул ХХК	5	0	77.2	69.1	56.7	4	0	77.3	67.5	53.2	0.1	-1.6	-3.5
18	Буурал мянган ХХК	2	0	90.3	86.5	82.4	4	0	75.9	65.1	69.8	-14.5	-21.4	-12.6
	НИЙТ	85	39	90.7	83.1	60.1	68	32	91.9	82.8	60.1	1.2	-0.3	0.0



2024.03-2024.04 саруудын харьцуулсан мэдээ
(Тээврийн хэрэгсэл, цаг рейсийн хувь)

Хүснэгт 9

№	Аж ахуйн нэгж байгууллага	03 дугаар сар					04 дүгээр сар					03-04 дүгээр сар харьцуулсан		
		Явуулсан бичгийн тоо	Хариу ирүүлсэн тоо	Гүйцэтгэлийн хувь			Явуулсан бичгийн тоо	Хариу ирүүлсэн тоо	Гүйцэтгэлийн хувь			Тээврийн хэрэгслийн гүйцэтгэл /хувь/	Машин цагийн гүйцэтгэл /хувь/	Рейсийн гүйцэтгэл /хувь/
				Тээврийн хэрэгсэл	Цаг	Рейс			Тээврийн хэрэгсэл	Цаг	Рейс			
0	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14
1	Зорчигч тээврийн нэгтгэл ОНӨААТҮГ	4	4	98.4	93.4	70.3	5	5	99.5	95.6	70.7	1.1	2.2	0.4
2	Зорчигч тээвэр гурав ОНӨААТҮГ	4	4	99.7	94	74.8	5	4	99.6	95.5	72.2	-0.1	1.5	-2.6
3	Автобус нэгдэл ХХК	4	2	98.6	95.2	91.6	2	0	100.0	98.6	94.1	1.4	3.4	2.5
4	Автотерминал ХХК	4	3	99.0	93.2	63.4	5	3	99.8	96.4	62.6	0.9	3.2	-0.8
5	Дюц ХХК	3	0	100.0	96.5	77.1	1	0	99.8	98.6	77.3	-0.2	2.1	0.2
6	Сутайн буянт ХХК	4	4	99.5	97.7	73.7	4	4	100.0	98.9	73.2	0.5	1.2	-0.5
7	Мяралзаа ХХК	4	3	99.7	92.2	73.2	3	1	100.0	95.8	72.6	0.3	3.6	-0.6
8	Трансбус ХХК	4	3	99.5	93.6	68.8	5	4	98.2	93.5	65.4	-1.3	-0.1	-3.4
9	Эрдэмтранс ХХК	4	3	99.2	90.1	68.1	5	4	100.0	94.1	68.8	0.8	4.0	0.7
10	Тэнүүн огоо ХХК	4	0	89.8	73.1	50.9	5	1	96.8	82.2	54.7	7.0	9.1	3.8
11	Тэнүүн огоо гуравдугаар бааз ХХК	4	1	92.3	75.7	59.4	5	1	95.1	81.8	63.8	2.8	6.1	4.4
12	ГБУС ХХК	4	1	97.1	93.2	75.6	4	2	99.8	95.7	68.5	2.7	2.5	-7.1
13	Блюбус ХХК	4	1	98.8	95.2	76.2	5	2	99.7	96.8	74.1	0.9	1.6	-2.1
14	Эмсид ХХК	4	3	99.9	97	89.5	2	2	100.0	98.6	86.9	0.1	1.6	-2.6
15	Сайхан ирээдүй ХХК	3	2	97.2	92.9	81	0	0	100.0	97.4	83.7	2.8	4.5	2.7
16	Эс энд эй транс ХХК	0	0	100.0	99.1	76.5	0	0	100.0	99.1	75.9	0.0	0.0	-0.6
17	Үнэгтийн уул ХХК	4	2	96.4	84.1	67.2	5	0	85.0	77.9	61.7	-11.4	-6.2	-5.5
18	Буурал мянган ХХК	1	0	100.0	95.3	97.6	4	0	96.7	87.3	88.3	-3.3	-8.0	-9.3
	НИИТ	63	36	98.3	92.0	71.1	65	33	99.4	93.2	71.4	1.1	1.2	0.3

2024 оны 03, 04 дүгээр сарын харьцуулсан үзүүлэлтээр тээврийн хэрэгслийн гүйцэтгэл 1,1 хувь, машин цагийн гүйцэтгэл 1,2 хувь, рейсийн гүйцэтгэл 0,3 хувиар өссөн.

2024 оны 04, 05 дугаар сарын харьцуулсан үзүүлэлтээр тээврийн хэрэгслийн гүйцэтгэл 0,1 хувиар буурсан, машин цагийн гүйцэтгэл 2,7 хувиар өссөн, рейсийн гүйцэтгэл 2,6 хувиар буурсан байна.

2024.04-2024.05 саруудын харьцуулсан мэдээ
(Тээврийн хэрэгсэл, цаг рейсийн хувь)

Хүснэгт 10

№	Аж ахуйн нэгж байгууллага	04 дүгээр сар					05 дугаар сар					04-05 дугаар сар харьцуулсан		
		Явуулсан бичгийн тоо	Хариу ирүүлсэн тоо	Гүйцэтгэлийн хувь			Явуулсан бичгийн тоо	Хариу ирүүлсэн тоо	Гүйцэтгэлийн хувь			Тээврийн хэрэгслийн гүйцэтгэл /хувь/	Машин цагийн гүйцэтгэл /хувь/	Рейсийн гүйцэтгэл /хувь/
				Тээврийн хэрэгсэл	Цаг	Рейс			Тээврийн хэрэгсэл	Цаг	Рейс			
0	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14
1	Зорчигч тээврийн нэгтгэл ОНӨААТҮГ	5	5	99.5	95.6	70.7	4	4	99.5	96.0	67.6	0.0	0.4	-3.1
2	Зорчигч тээвэр гурав ОНӨААТҮГ	5	4	99.6	95.5	72.2	4	1	99.7	97.0	69.7	0.1	1.5	-2.5
3	Автобус нэгдэл ХХК	2	0	100.0	98.6	94.1	0	0	100.0	98.8	94.4	0.0	0.2	0.3
4	Автотерминал ХХК	5	3	99.8	96.4	62.6	4	3	99.9	96.9	60.4	0.1	0.5	-2.2
5	Дюц ХХК	1	0	99.8	98.6	77.3	3	2	100.0	97.2	70.6	0.2	-1.4	-6.7
6	Сутайн буянт ХХК	4	4	100.0	98.9	73.2	4	2	100.0	98.8	71.1	0.0	-0.1	-2.1
7	Мяралзаа ХХК	3	1	100.0	95.8	72.6	3	1	100.0	98.6	69.3	0.0	2.8	-3.3
8	Трансбус ХХК	5	4	98.2	93.5	65.4	4	1	99.0	95.6	63.9	0.8	2.1	-1.5
9	Эрдэмтранс ХХК	5	4	100.0	94.1	68.8	4	2	100.0	94.4	67.3	0.0	0.3	-1.5
10	Тэнүүн огоо ХХК	5	1	96.8	82.2	54.7	4	0	85.9	72.9	45.2	-10.9	-9.3	-9.5
11	Тэнүүн огоо гуравдугаар бааз ХХК	5	1	95.1	81.8	63.8	4	0	79.6	67.9	50.8	-15.5	-13.9	-13.0
12	ГБУС ХХК	4	2	99.8	95.7	68.5	3	1	100.0	97.1	67.0	0.2	1.4	-1.5
13	Блюбус ХХК	5	2	99.7	96.8	74.1	4	0	99.8	96.5	71.3	0.1	-0.3	-2.8
14	Эмсид ХХК	2	2	100.0	98.6	86.9	3	1	99.9	99.2	81.4	-0.1	0.6	-5.5
15	Сайхан ирээдүй ХХК	0	0	100.0	97.4	83.7	1	1	100.0	98.0	81.8	0.0	0.6	-1.9
16	Эс энд эй транс ХХК	0	0	100.0	99.1	75.9	1	0	100.0	99.1	76.3	0.0	0.0	0.4
17	Үнэгтийн уул ХХК	5	0	85.0	77.9	61.7	4	0	92.7	85.3	62.3	7.7	7.4	0.6
18	Буурал мянган ХХК	4	0	96.7	87.3	88.3	2	0	90.3	85.0	88.7	-6.4	-2.3	0.4
	САЛБАРЫН ДҮН	65	33	99.4	93.2	71.4	56	19	99.3	95.9	68.8	-0.1	2.7	-2.6



2024.09-2024.10 саруудын харьцуулсан мэдээ
(Тээврийн хэрэгсэл, цаг рейсийн хувь)

Хүснэгт 11

№	Аж ахуйн нэгж байгууллага	09 дүгээр сар					10 дугаар сар					09-10 дугаар сар харьцуулсан		
		Явуулсан бичгийн тоо	Харууруулсан тоо	Гүйцэтгэлийн хувь			Явуулсан бичгийн тоо	Харууруулсан тоо	Гүйцэтгэлийн хувь			Тээврийн хэрэгслийн гүйцэтгэл /хувь/	Машин цагийн гүйцэтгэл /хувь/	Рейсийн гүйцэтгэл /хувь/
				Тээврийн хэрэгсэл	Цаг	Рейс			Тээврийн хэрэгсэл	Цаг	Рейс			
0	1	7	8	9	10	11	12	13	14	15	16	17	18	19
1	Зорчигч тээвэр нэг ОНӨААТҮГ	5	4	99.6	97.7	64.5	4	4	100.0	97.9	69.8	0.4	0.2	5.2
2	Зорчигч тээвэр хоёр ОНӨААТҮГ	5	5	100.0	95.0	66.9	3	3	99.1	94.1	66.1	-0.9	-0.9	-0.8
3	Зорчигч тээвэр дөрөв ОНӨААТҮГ	5	5	100	98.3	69.732	4	4	100.0	98.5	67.2	0.0	0.2	-2.5
4	Зорчигч тээвэр тав ОНӨААТҮГ	4	4	99.9	94.3	69.5	4	4	100.0	96.1	69.6	0.1	1.8	0.1
5	Зорчигч тээвэр гурав ОНӨААТҮГ	5	4	100.0	96.0	65.8	3	3	100.0	97.2	65.9	0.0	1.2	0.1
6	Автобус нэгдэл ХХК	3	1	97.4	97.6	87.7	1	1	100.0	98.6	87.5	2.6	1.0	-0.3
7	Автотерминал ХХК	5	5	99.9	96.4	57.8	4	4	99.7	97.5	58.2	-0.2	1.1	0.4
8	Дюц ХХК	4	4	100.0	98.3	69.0	1	1	100.0	98.4	71.1	0.0	0.1	2.2
9	Сутайн буянт ХХК	5	5	100.0	98.7	67.4	4	4	100.0	99.0	68.3	0.0	0.3	0.9
10	Мяралзаа ХХК	3	2	100.0	97.1	69.3	3	3	100.0	98.1	68.2	0.0	1.0	-1.1
11	Трансбус ХХК	5	4	99.2	96.8	63.0	4	4	100.0	97.4	64.7	0.8	0.6	1.6
12	Эрдэмтранс ХХК	5	5	99.4	94.0	64.2	2	2	100.0	96.4	64.7	0.6	2.4	0.5
13	Тэнүүн огоо гуравдугаар бааз ХХК	5	2	100.0	87.5	54.1	3	3	100.0	87.8	57.4	0.0	0.3	3.3
14	ГБУС ХХК	4	0	100.0	95.9	59.9	1	1	100.0	97.4	57.5	0.0	1.5	-2.4
15	Блюбус ХХК	5	3	100.0	92.2	65.5	3	3	99.1	95.3	69.0	-0.9	3.1	3.5
16	Эмсид ХХК	4	3	100.0	98.3	78.5	1	1	99.6	98.1	77.3	-0.4	-0.2	-1.1
17	Сайхан ирээдүй ХХК	1	0	100.0	97.4	76.7	0	0	100.0	97.2	80.1	0.0	-0.2	3.4
18	Эс энд ай транс ХХК	4	0	99.5	97.9	72.6	2	2	99.4	97.0	70.3	-0.1	-0.9	-2.3
19	Үнэгтийн уул ХХК	3	0	94.2	87.8	80.1	0	0	89.6	86.3	76.9	-4.5	-1.5	-3.2
	САЛБАРЫН ДҮН	80	56	99.7	96.1	66.9	47	47	99.8	96.9	67.7	0.1	0.8	0.8

2024 оны 09, 10 дугаар сарын харьцуулсан үзүүлэлтээр тээврийн хэрэгслийн гүйцэтгэл 0,1 хувиар өссөн, машин цагийн гүйцэтгэл 0,8 хувиар өссөн, рейсийн гүйцэтгэл 0,8 хувиар өссөн байна.

Үйл ажиллагааны үр дүн:

Нийтийн тээврийн чиглэлүүдэд хийсэн шуурхай зохицуулалтын үед ажлын гүйцэтгэл үнэн зөв тооцогдох нөхцөлийг бүрдүүлж, ажлын гүйцэтгэлд системээр хяналт тавьж ажилласан.

Ажлын нэгдсэн гүйцэтгэл, нэмэгдэж хасагдсан цагийн тооцоололд өдөр тутам тавих хяналт тавьж, сар бүр нэгдсэн мэдээлэл бэлтгэсэн. Гэрээ дүгнэхэд шаардлагатай мэдээллийг хугацаанд нь гарган гэрээг дүгнүүлсэн.

Ажлын гүйцэтгэл тооцох А/42 журмын зарим заалтад тус газрын даргын 2022 оны А/119 дугаар тушаалаар байгуулагдсан мэргэжлийн зөвлөлийн зөвлөмжөөр 4 удаа өөрчлөлт оруулсан. Үүнд:

1.Удирдлага мэдээллийн цахим төлбөрийн системээр нийтийн тээврийн үйлчилгээний ажлын гүйцэтгэл тооцох журам"-ын 2.4.2, 10.1 дэх заалтыг тус тус 2023 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 01 дүгээр зөвлөмжөөр системд хөгжүүлэлт хийх хэрэглэгчийн шаардлагыг 2024 оны 04 дүгээр сарын 24-ний өдөр 01/03/916 дугаартай албан бичгээр Улаанбаатар смарт карт ХХК-д хүргүүлж хөгжүүлэлтийн ажлыг хийлгэж 2023 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс хэрэгжүүлж эхэлсэн. /Мэргэжлийн зөвлөлийн 01дүгээр зөвлөмжөөр/

2.Удирдлага мэдээллийн цахим төлбөрийн системээр нийтийн тээврийн үйлчилгээний ажлын гүйцэтгэл тооцох журам"-ын 1 дүгээр заалтад нэмэлт өөрчлөлт оруулан хөгжүүлэлт хийлгэх хэрэглэгчийн шаардлагыг 2023 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн 02/03/1051 дугаартай албан бичгээр Улаанбаатар смарт карт ХХК-д хүргүүлсэн. /Мэргэжлийн зөвлөлийн 02 дугаар зөвлөмжөөр/

3.А/42 дугаар тушаалд өөрчлөлт оруулах тухай 2023 оны 06 дугаар сарын 29-ний өдрийн А/73 тушаалаар “Удирдлага мэдээллийн цахим төлбөрийн системээр нийтийн тээврийн үйлчилгээний ажлын гүйцэтгэл тооцох журам"-ын 1 дэх хэсгийн гаралт тус бүрийн гэснийг “Чиглэл тус бүрийн” гэж өөрчилж 2023 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс мөрдөж эхэлсэн. /Мэргэжлийн зөвлөлийн 02 дугаар зөвлөмжөөр/

4.А/42 дугаар тушаалд өөрчлөлт оруулах тухай 2023 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн А/104 тушаалаар “Удирдлага мэдээллийн цахим төлбөрийн системээр нийтийн тээврийн үйлчилгээний ажлын гүйцэтгэл тооцох журам"-ын 8 дэх хэсгийн2 минутаас...” гэснийг ...“....3 минутаас” гэж өөрчилж 2023 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс мөрдөж эхэлсэн. /Мэргэжлийн зөвлөлийн 04 дугаар зөвлөмжөөр/

Шинэчлэгдсэн журмын дагуу ажлын гүйцэтгэл тооцогдож байгаа байдалд хяналт тавьж, аж ахуйн нэгж байгууллагуудын сар бүрийн машин цаг, рейсийн гүйцэтгэлийг 2022-2023-2024 оны мөн үетэй харьцуулан хяналт тавьж ажилласан.




Машин цагийн гүйцэтгэл 2022-2024

Хүснэгт 12

Үзүүлэлт	1 сар	2 сар	3 сар	4 сар	5 сар	6 сар	7 сар	8 сар	9 сар	10 сар	Дундаж хувь
2022 он	92.5	91.9	93.3	93.4	91.8	91.1	89	87.7	88.7	87.4	90.7
2023 он	88.1	90.2	89.6	92.7	92.2	90.5	89.3	88.1	88.3	86.9	89.6
2024 он	83.1	82.8	92.0	95.3	95.9	96.2	95.9	96.1	96.1	96.9	93.0

2022-2024 оны 1-10-р сарын машин цагийн гүйцэтгэл

График 3



А/42 дугаар журам хэрэгжиж эхлэхээс өмнөх үеийн машин цагийг 2023, 2024 онтой харьцуулахад 3.4 хувиар өссөн үзүүлэлтэй байна.


Рейсийн гүйцэтгэл 2022-2024

Хүснэгт 13

Үзүүлэлт	1 сар	2 сар	3 сар	4 сар	5 сар	6 сар	7 сар	8 сар	9 сар	10 сар	Дундаж хувь
2022 он	78.3	78	74.7	74.7	71.3	74	77.1	71.5	68.9	65.8	73.4
2023 он	72.4	70.7	73.7	74.8	72.5	74.2	75.5	72.6	69.7	66.2	72.2
2024 он	60.0	60.1	71.1	71.4	68.8	73.8	76.9	70.1	66.9	67.7	68.7

2022-2024 оны 1-10-р сарын рейсийн гүйцэтгэл

График 4



А/42 дугаар журам хэрэгжиж эхлэхээс өмнөх үеийн рейсийг 2023, 2024 онтой харьцуулахад 3.5 хувиар буурсан үзүүлэлтэй байна.



Нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж байгууллагуудын
2022-2023-2024 онуудын ажлын цаг рейсийн гүйцэтгэл

Хүснэгт 14

Д/д	Аж ахуйн нэгж байгууллага	2022 оны Биелэлт			2023 оны Биелэлт			2024 оны Биелэлт			2022-2024 оны дундаж		
		Тээврийн хэрэгсэл	Цаг	Рейс	Тээврийн хэрэгсэл	Цаг	Рейс	Тээврийн хэрэгсэл	Цаг	Рейс	Тээврийн хэрэгслийн гүйцэтгэл /хувь/	Машин цагийн гүйцэтгэл /хувь/	Рейсийн гүйцэтгэл /хувь/
1	Зорчигч тээвэр нэгтгэл ОНӨААТҮГ	99.7	97.2	77.8	99.7	96.9	77.1	97.1	92.6	67.4	98.8	95.6	74.1
2	Зорчигч тээвэр нэг ОНӨААТҮГ							99.9	97.4	69.1	99.9	97.4	69.1
3	Зорчигч тээвэр хоёр ОНӨААТҮГ							99.6	94.9	68.4	99.6	94.9	68.4
4	Зорчигч тээвэр гурав ОНӨААТҮГ	97.9	89.3	75.1	97.6	91.0	74.4	98.1	93.8	67.7	97.9	91.4	72.4
5	Зорчигч тээвэр дөрөв ОНӨААТҮГ							100.0	98.1	72.7	100.0	98.1	72.7
6	Зорчигч тээвэр тав ОНӨААТҮГ							99.9	95.3	72.8	99.9	95.3	72.8
7	Блюбус ХХК	95.2	85.4	69.1	95.1	87.0	70.0	98.3	93.2	71.2	96.2	88.5	70.1
8	Сутгайн буянт ХХК	99.5	93.2	66.6	98.6	92.1	67.4	99.3	97.3	70.5	99.1	94.2	68.2
9	Автобус нэгдэл ХХК	97.1	89.5	81.1	88.7	81.3	72.7	97.4	95.3	88.8	94.4	88.7	80.9
10	Мяралзаа ХХК	96.5	90.3	65.5	92.1	81.8	63.7	96.0	93.6	70.1	95.5	88.6	66.4
11	Тэнүүн огоо ХХК	93.7	81.7	59.0	88.0	75.4	54.6	87.5	72.7	48.9	89.7	76.6	54.2
12	Трансбус ХХК	98.0	89.7	73.1	93.8	83.7	67.7	97.0	92.1	65.4	96.3	88.5	68.7
13	Эрдэмтранс ХХК	98.9	88.1	70.2	96.4	89.4	70.3	98.3	91.3	66.8	97.9	89.6	69.1
14	Дюц ХХК	97.2	89.4	72.3	90.8	78.8	63.4	95.5	92.5	70.3	94.5	86.9	68.7
15	Эмсид ХХК	98.6	85.0	73.7	97.7	83.6	70.8	99.1	96.6	81.4	95.6	88.4	75.3
16	Сайхан ирээдүй ХХК	98.2	92.1	86.1	96.6	92.9	83.3	99.4	96.3	81.5	95.3	93.8	83.6
17	ГБУС ХХК	94.2	82.3	63.1	84.9	71.1	55.0	98.1	94.1	65.1	92.4	82.5	61.1
18	Автотерминал ХХК	94.3	88.4	64.2	97.3	90.6	64.7	99.1	74.2	61.8	96.9	84.4	63.6
19	Тэнүүн огоо 3-р бааз УХК	96.5	87.9	69.9	87.4	79.0	62.5	94.9	82.2	58.6	92.9	83.0	63.7
20	Эс энд эй транс ХХК	100.0	99.5	80.1	100.0	99.1	78.1	99.8	97.9	73.7	99.9	98.8	77.3
21	Үнэгтийн уул ХХК	98.7	94.2	62.7	90.7	82.9	62.6	88.6	80.9	70.8	92.7	86.0	65.4
22	Буурал мянган ХХК	98.3	94.1	95.7	90.8	87.9	87.8	89.6	82.4	84.2	92.9	88.1	89.2
	Салбарын дүн	86.4	89.9	72.5	93.7	85.8	69.2	97.0	91.1	70.3	92.4	88.9	70.7

2024 оны машин цаг рейсийн гүйцэтгэлийг 2023 онтой харьцуулахад тээврийн хэрэгсэл 3.3 хувиар өссөн, машин цаг 5.3 хувиар өссөн, рейсийн гүйцэтгэл 1.1 хувиар тус тус өссөн үзүүлэлтэй байна.

2024 оны сарын нэгдсэн гүйцэтгэлд хяналт тавих хуудас

Хүснэгт 15

д/д	Он, сар	тээврийн хэрэгслийн тоо		машин цаг		рейс		гүйцэтгэлийн хувь			Ажлын гүйцэтгэлд	
		даалгавар	гүйцэтгэл	даалгавар	гүйцэтгэл	даалгавар	гүйцэтгэл	тээврийн хэрэгсэл	цаг	рейс	нэмэгдсэн цаг	хасагдсан цаг
1	2024.01	29441	26616	419545:01:30	348546:03:00	284006	170309	90.4	83.1	60.0	1729:35:00	140:37:00
2	2024.02	27691	25446	398574:39:30	329999:14:00	275987.5	165735	91.9	82.8	60.1	917:45:00	118:36:00
3	2024.03	30647	30139	435726:41:00	400885:22:30	296970.5	211200.5	98.3	92.0	71.1	195:52:00	117:30:00
4	2024.04	31165	30993	445888:5:30	425069:23:00	305309.5	217991.5	99.4	95.3	71.4	288:29:00	100:48:00
5	2024.05	32937	32696	470535:13:00	451108:15:30	323779.5	222791.5	99.3	95.9	68.8	1751:43:30	103:43:00
6	2024.06	30299	30198	433515:43:30	416942:23:00	297374	219473	99.7	96.2	73.8	410:03:30	93:53:00
7	2024.07	30650	30598	436854:06:30	418962:53:00	302172	233030.5	99.8	95.9	77.1	241:50:00	63:03:00
8	2024.08	32135	32051	461872:29:30	444045:56:30	318178	222978.5	99.7	96.1	70.1	245:26:00	64:03:00
9	2024.09	33547	33430	473541:14:30	455199:16:00	325091	217466.5	99.7	96.1	66.9	2031:00:00	230:08:00
10	2024.10	34200	34122	484334:33:00	469179:17:00	327984	222116.5	99.8	96.9	67.7	1602:35:30	83:29:00
	Нийт дүн	312712	306289	4460387:47:30	4159938:03:30	3056852	2103092.5	97.9	93.3	68.8	9414:19:30	1115:50:00

2024 оны эхний 10 сарын байдлаар нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч 19 аж ахуйн нэгж байгууллагын тээврийн хэрэгслийн гүйцэтгэл 97.9 хувь, машин цагийн гүйцэтгэл 93.3 хувь, рейсийн гүйцэтгэл 68.8 хувийн гүйцэтгэлтэй байна.




Машин цаг, рейсийн гүйцэтгэл/2024.01-10 дугаар сар/

Хүснэгт 16

Үзүүлэлт	1 сар	2 сар	3 сар	4 сар	5 сар	6 сар	7 сар	8 сар	9 сар	10 сар	Нийт дүн
Рейс /мян.рейс/	170.3	165.7	211.2	217991.5	222791.5	219473.0	233030.5	222978.5	217466.5	222116.5	1556395.2
Машин цаг /мян.цаг/	348.5	330.0	400.9	425069.0	451108.0	416942.0	418963.0	444046.0	455199.0	469179.0	3081585.4

2022-2024 оны 1-10-р сарын машин цагийн гүйцэтгэл

График 5



Оны эхнээс 10 дугаар сарын байдлаар машин цагийн гүйцэтгэл 93.3 хувь, рейсийн гүйцэтгэл 68.8 хувийн гүйцэтгэлтэй байна.

Үйлчилгээнд ажилласан тээврийн хэрэгслийн тоо

Хүснэгт 17

Үзүүлэлт	1 сар	2 сар	3 сар	4 сар	5 сар	6 сар	7 сар	8 сар	9 сар	10 сар	Нийт дүн
Тээврийн хэрэгслийн тоо	26616	25446	30139	30993	32696	30198	30598	32051	33430	34122	306,289

2024 оны эхний 10 сарын тээврийн хэрэгслийн тоо

График 6



Ажлын гүйцэтгэлд нэмэгдсэн хасагдсан цаг

Хүснэгт 18

Үзүүлэлт	1 сар	2 сар	3 сар	4 сар	5 сар	6 сар	7 сар	8 сар	9 сар	10-р сар	Нийт дүн
Нэмэгдсэн цаг	1729:35:00	918:21:00	195:52:00	288:29:00	1751:43:30	410:03:30	241:50:00	245:26:00	2031:00:00	9414:19:30	17226:39:30
Хасагдсан цаг	140:37:00	118:36:00	117:30:00	100:48:00	103:43:00	93:53:00	63:03:00	64:03:00	230:08:00	1115:50:00	2148:11:00



Ажлын гүйцэтгэлд нэмэгдсэн цаг

График 7



Ажлын гүйцэтгэлээс хасагдсан цагийн гүйцэтгэл

Хүснэгт 19

Үзүүлэлт	1 сар	2 сар	3 сар	4 сар	5 сар	6 сар	7 сар	8 сар	9 сар	10 сар	Нийт дүн
Хасагдсан цаг	141.0	119.0	118.0	101.0	104.0	94.0	63.0	64.0	230.0	1116.0	2,257.0

Ажлын гүйцэтгэлээс хасагдсан цаг

График 8



Үйл ажиллагааны үр дүн:

Нийтийн тээврийн чиглэлүүдэд хийсэн шуурхай зохицуулалтын үед ажлын гүйцэтгэл үнэн зөв тооцогдох нөхцөлийг бүрдүүлж, ажлын гүйцэтгэлд системээр хяналт тавьж ажилласан.

Ажлын нэгдсэн гүйцэтгэл, нэмэгдэж хасагдсан цагийн тооцоололд өдөр тутам тавих хяналт тавьж, сар бүр нэгдсэн мэдээлэл бэлтгэсэн.

Удаан зогссон автобуснуудын гүйцэтгэлд тээвэр зохицуулагчид болон ажлын гүйцэтгэлийн хяналтын мэргэжилтнүүд давхар хяналт тавьснаар техникийн саатал болон бусад шалтгаанаар сул зогссон тээврийн хэрэгслүүдийн гүйцэтгэлд тавих хяналт сайжирсан.

1.4.Зам, тээврийн сайд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч нар зам тээврийн салбарт 2021-2024 онд хамтран ажиллах арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлын хүрээнд:

1.4.1.Зорилт 2. Байгаль орчинд ээлтэй, тогтвортой, хүртээмжтэй, аюулгүй, олон төрөлт, ухаалаг нийтийн тээврийн үйлчилгээг хөгжүүлж, Улаанбаатар хотын зорчигчдын ариун цэвэр, аюулгүй байдлыг хангасан, нийтийн тээврийн буудлуудыг бий болгох, ачаа тээврийн нэгдсэн логистикийг хөгжүүлэх;

2024 онд төрийн өмчийн 4 байгууллага нийслэлийн нийтийн тээврийн парк шинэчлэлтийн ажлын хүрээнд импортлогдсон Yutong маркийн их багтаамжийн 231, угсраа 31, төрийн өмчийн 2 байгууллага County маркийн дунд багтаамжийн 31, хувийн хэвшлийн 10 аж ахуйн нэгж, байгууллага Yutong маркийн их багтаамжийн 333 автобусаар, 2 байгууллага дунд багтаамжийн 15 автобусаар, нийт /дизель евро-5 хөдөлгүүртэй –595, дизель евро-4 хөдөлгүүртэй – 46/, нийт 641 автобусаар парк шинэчлэлт хийсэн.

Нийслэлийн Засаг даргын 2024 оны 07 дугаар сарын 26-ны өдрийн “Хөрөнгө гаргах тухай” А/907 дугаар захирамжийн хэрэгжилтийн хүрээнд: БНХАУ-ын Эрээн хот руу тээвэрлэх явцад зам тээврийн осолд өртөж хөдөлгөөнд оролцох боломжгүй болсон Yutong ZK6116HG загварын LZYTБGE68R1040450 арлын дугаартай 1 /нэг/ автобусыг нийлүүлэгч тал автобус засварлах гэрээний дагуу засварлан ирүүлснийг уг захирамжийн дагуу Нийслэлийн Нийтийн



тээврийн бодлогын газрын Даргын 2024 оны 07 дугаар сарын 29-ний өдрийн “Автобус хүлээлцүүлэх ажлын хэсэг байгуулах тухай” А/95 дугаар тушаалаар баталсан ажлын хэсгийн бүрэлдэхүүн 2024 оны 08 дугаар сарын 09-ний өдөр хүлээн авч “Зорчигч тээвэр тав” ОНӨААТҮГ-т хүлээлгэн өгсөн.



Зураг № 19. Их багтаамжийн EBPO-5 дизель хөдөлгүүртэй угсраа автобусны тоноглолуудыг шалгаж байгаа нь.

Нийслэлийн Засаг даргын Тамгын газар болон “Тэнүүн-Огоо” ХХК-ийн хооронд байгуулсан 2023 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн ННТГ23001 гэрээ, 2023 оны 02 дүгээр сарын 10-ны өдрийн ННТГ23001-1 “Нийтийн тээврийн автобус худалдан авах гэрээ”-ний дагуу дунд оврын 50 ширхэг Каунти автобус хүлээн авах ажилд дэмжлэг үзүүлэх, холбогдох заавар зөвлөмжөөр хангаж, хяналт тавин ажиллаж 25 ширхэг автобусыг “Зорчигч тээвэр гурав” ОНӨААТҮГ-т, гаалийн барьцаанд хадгалагдаж байсан 2 ширхэг автобусыг “Багануур дүүргийн тээвэр зохицуулалтын алба” ААТҮГ-т, 1 ширхэг автобусыг “Эмээлт эко аж үйлдвэрийн парк” ХХК-д тус тус хүлээлгэн өгсөн.



Зураг № 20. Дунд оврын EBPO-4 дизель хөдөлгүүртэй автобуснуудыг техникийн үзүүлэлтийг ажлын даалгаврын дагуу шалгаж байгаа нь:

Монгол Улсын Засаг, ахиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь заалт, Нийслэлийн Засаг даргын 2024 оны “Гадаад томилолтын тухай” А/604 дугаар захирамжийн хүрээнд Нийслэлийн нийтийн тээврийн хүртээмж, үйлчилгээг сайжруулах ажлын хүрээнд троллейбус, трамвай болон олон төрөлт нийтийн тээврийн хэрэгслийн үйлдвэрлэл болон бусад асуудлыг судлах зорилгоор БНХАУ, БНЧУ, УНГАР Улсуудад Бүртгэл, техник технологийн хэлтсийн Техник хяналтын үзлэгийн төв хариуцсан ахлах менежер Э.Өлзий нь 2024 оны 05 дугаар сарын 30-ны өдрөөс 06 дугаар сарын 10-ны өдрийг хүртэлх хугацаанд томилолтоор ажилласан.



Зураг № 21. Томилолтын ажлын явц




1.4.2. Ачаа болон такси үйлчилгээний тээврийн үйлчилгээнд одоо ашиглаж байгаа программаас мэдээлэл авч нэгдсэн тайлан гаргадаг систем хөгжүүлэх

Нийслэлийн гудамж, замын хөдөлгөөнд ачааны автомашиныг цагийн хязгаарлалттайгаар оролцуулах түр зөвшөөрөл” авах иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудын хүсэлтийг “Тээврийн хэрэгслийн нэгдсэн цахим үйлчилгээний систем” www.smartcar.mn сайтаар авч, түр зөвшөөрөл олгох үйл ажиллагааг цахимжуулсан. Уг порограмд нэмэлт хөгжүүлэлт хийн Замын цагдаагийн шалгах төхөөрөмж дээр “Ачааны автомашины төв замын зөвшөөрөл” гэсэн мэдээллийг цахимаар хянах боломжтой байхаар мэдээлэл дамжуулах сервис холболт хийгдсэн.

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 102 дугаар тогтоолоор баталсан “Нийслэлийн гудамж, замын хөдөлгөөнд ачааны автомашиныг цагийн хязгаарлалттайгаар оролцуулах, түр зөвшөөрөл олгох журам”-ыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Журмын хүрээнд Нийслэлийн нутаг дэвсгэрт ачаа тээвэрлэлт хийж буй ачааны төрлийн автомашинуудад “ЕС” зөвшөөрөл болон хориглосон гудамж, замын хөдөлгөөнд ачааны автомашиныг цагийн хязгаарлалттайгаар оролцуулах “Түр” зөвшөөрөл олгох ажлыг холбогдох стандарт, дүрэм, журмыг хангуулан зохион байгуулж ажилласан.

“Нийслэлийн гудамж, замын хөдөлгөөнд ачааны автомашиныг цагийн хязгаарлалттайгаар оролцуулах, түр зөвшөөрөл олгох журам”-ыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд “Түр” зөвшөөрлийг “Тээврийн хэрэгслийн нэгдсэн цахим үйлчилгээний систем” www.smartcar.mn сайтаар олгох ажлыг 2023 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөс эхлүүлсэн.



Зураг №22. Ачаа тээврийн түр зөвшөөрөл цахимаар авах зөвлөмж

Ачааны автомашиныг цагийн хязгаарлалттайгаар оролцуулах “Түр” зөвшөөрлийг 2024 оны 01 дүгээр сарын 02-ноос 2024 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийг хүртэлх хугацаанд нийт 6562 зөвшөөрөл олгосон. Үүнээс В ангиллын 1530, С ангиллын 4835, СЕ ангиллын 197 тээврийн хэрэгсэлд олгож төрийн санд 795,580,000 төгрөг төвлөрүүлсэн.

Хүснэгт №4 2024 онд олгосон түр зөвшөөрлийн санхүүгийн мэдээ

Хүснэгт 20

Тээврийн хэрэгслийн ангилал	Тээврийн хэрэгслийн харьяалал	Тээврийн хэрэгслийн тоо /ш/	Төлбөрийн дүн /₮/
В	ААНБ	1402	128538000
В	Иргэн	128	13591000
Ангилалын дүн		1530	142129000
С	ААНБ	4309	559227000
С	Иргэн	526	67494000



Ангилалын дүн		4835	626721000
СЕ	ААНБ	152	19852000
СЕ	Иргэн	45	6878000
Ангилалын дүн		197	26730000
Нийт дүн		6562	795580000

Хүснэгт №5 2024 онд олгосон “ес” зөвшөөрөл авсан автомашины тоон мэдээ

Хүснэгт 21

Хагас	Зөвшөөрлийн тоо В	Зөвшөөрлийн тоо С	Зөвшөөрлийн тоо СЕ	Нийт зөвшөөрлийн тоо
1-р	4277	4138	491	8906
2-р	3238	3116	248	6638
Нийт	7515	7254	775	15544

Нийслэлийн нутаг дэвсгэрт ачаа тээвэрлэх эрх бүхий “ЕС” зөвшөөрлийг 2024 оны 12 дугаар 26-наас 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэл нийт 8662 тээврийн хэрэгсэлд үүнээс В ангиллын 4277, С ангиллын 7249, СЕ ангиллын 776 тээврийн хэрэгсэлд тус олгож, төрийн санд 199,405,000 төгрөг төвлөрүүлсэн.

Ачааны автомашиныг цагийн хязгаарлалттайгаар оролцуулах “Түр” зөвшөөрөл, Нийслэлийн нутаг дэвсгэрт ачаа тээвэрлэх эрх бүхий “ЕС” зөвшөөрлийн нийт орлого 1,000,000,000 (нэг тэрбум) төгрөгийг төрийн санд төвлөрүүлсэн.

2.“Нийслэлийн нутаг дэвсгэрт ачаа тээвэрлэх эрх бүхий “ЕС” зөвшөөрөл”-ийг Төрийн Үйлчилгээний Цахим /ТҮЦ/ машинаар олгох, мэдээ тайланг нэгтгэж ажиллах.

ТҮЦ машинаар “ЕС” зөвшөөрөл олгохдоо тухайн тээврийн хэрэгсэл техникийн хяналтын үзлэг оношилгоонд хамрагдаж тэнцсэн эсэх, татвар төлсөн эсэхийг хянасны үндсэн дээр зөвшөөрлийг олгон, мөн ачаа тээврийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллага иргэнээс ачаа тээврийн ажил гүйцэтгэлийн тайлан мэдээг “Нийслэлийн тээврийн газрын тайлангийн нэгдсэн систем”-ээр дамжуулан авч байна.



Зураг №23. ТҮЦ машины ес зөвшөөрөл



Зураг №24. “TYP” зөвшөөрлийн

3. Нийслэлийн нутаг дэвсгэрт ачаа тээвэрлэлтийн үйл ажиллагаа эрхэлж буй тээврийн хэрэгслийн бүртгэл, мэдээллийн санг бүрдүүлэх ажлын хүрээнд:


Ачаа тээврийн үйлчилгээ эрхлэгчдийн тээвэрлэлтийн мэдээ, тайланг “Ачаа тээвэрлэлтийн нэгдсэн мэдээллийн системээр хүлээн авч, нэгдсэн бүртгэл, мэдээллийг санг үндэслэн ачаа тээвэрлэлтийн ажлын гүйцэтгэлийн талаарх судалгаа, мэдээллийг боловсруулан ажиллаж байна.

Ачаа тээврийн үйлчилгээ эрхлэгчдийн тээвэрлэлтийн мэдээ, тайланг “Ачаа тээвэрлэлтийн нэгдсэн мэдээллийн системээр хүлээн авч, нэгдсэн бүртгэл, Ачаа тээврийн үйлчилгээ эрхлэгчдийн тээвэрлэлтийн мэдээ, тайланг “Ачаа тээвэрлэлтийн нэгдсэн мэдээллийн системээр хүлээн авч, нэгдсэн бүртгэл, мэдээллийг санг үндэслэн ачаа тээвэрлэлтийн ажлын гүйцэтгэлийн талаарх судалгаа, мэдээллийг боловсруулан ажиллаж байна.

Ачаа тээврийн үйлчилгээ эрхлэгчдийн тээвэрлэлтийн мэдээ, тайланг “Ачаа тээвэрлэлтийн нэгдсэн мэдээллийн системээр хүлээн авч, нэгдсэн бүртгэл, мэдээллийг санг үндэслэн ачаа тээвэрлэлтийн ажлын гүйцэтгэлийн талаарх судалгаа, мэдээллийг боловсруулан ажиллаж байна. 2024 оны 05 дугаар сарын 30-ний байдлаар 4856 тээврийн хэрэгслийн тайлан хүлээн авч, мэдээллийн сан үүсгэн ажилласан.

2018-2024 онд “EC” зөвшөөрөл авсан тоон судалгаа:

График 9



Хүснэгт 22


Ангилал	2018	2019	2020	2021	2022	2023	2024
Вангилал	13389	12263	12119	10216	10329	9388	7515
С ангилал	11180	9644	9891	8396	8307	8295	7255
СЕ ангилал	1783	1331	1494	989	1065	831	775
Нийт	26352	23238	23504	19601	19701	18515	15544

2018-2024 онуудад “TYP” зөвшөөрөл авсан тоон судалгаа:

График 10



ТҮР ЗӨВШӨӨРӨЛ АВСАН ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ТОО



Хүснэгт 23

Ангилал	2018	2019	2020	2021	2022	2023	2024
В ангилал	775	898	950	857	982	1194	1530
С ангилал	3604	3462	3771	3364	4184	4139	4835
СЕ ангилал	569	561	593	445	760	356	197
Нийт	4948	4921	5314	4666	5926	5689	6562

Сүүлийн 3 жилийн судалгаагаар ачаа тээвэрлэлтийн нэлээдгүй хувийг эзэлж буй Хүнсний өргөн хэрэглээ, Барилга, Аюултай ачаа тээвэрлэгч иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудтай 2024 оны хоёрдугаар улиралд уулзалт зохион байгуулан санал хүсэлтийг авч шийдвэрлэх боломжийг судлан ажилласан. Үүнд:

Барилгын бетон зуурмаг тээвэрлэгч:

- Улирлын чанартай Барилгын ажил эхлэх цаг хугацаатай уялдуулан хавар 03 сарын 01-нээс 12 сарын 01-н хүртэл 1 удаа зөвшөөрөл авдаг байх.
- Даац хэтэрсэн тээврийн хэрэгслийг оношилгоо оношилдоггүй, үүнээс зөвшөөрөл авч чадахгүй торгуулдаг тул Нийслэл хотын хязгаарлагдсан замд тээвэрлэлт хийх боломжийг шийдвэрлэн өгөх;
- Улаанбаатар хотод 8м³-ээс дээш бетон зуурмаг тээвэрлэх боломжтой болгох,
- Миксер, автомашиныг улсын дугаарын хязгаарлалтаас чөлөөлөх,
- Зарим зам, хороолол барилгад 22:00 цагаас хойш цутгалт хийх явцад ЗХД-ийн заалт зөрчсөн гэж оршин суугч, албан байгууллага гомдол гаргаж эргүүлийн цагдаа дуудаж ажил тасалдах тохиолдол их гардаг тул тодорхой шийдвэрлэж өгөх.

Хүнсний өргөн хэрэглээ тээвэрлэгч:

- “В” ангиллын тээврийн хэрэгсэл цагийн хязгаарлалттай орж байгаа гудамж замд “С” ангиллын тээврийн хэрэгслийг зорчуулах.
- Хүнсний аюулгүй тээвэрлэлтийн хүрээнд түргэн муудах, эмзэг бүтээгдэхүүн тээвэрлэж буй ачааны автомашиныг дугаарын хязгаарлалтаас чөлөөлөх.
- Өдөрт 20 гаруй томоохон худалдааны төв, 300-400 орчим жижиг дэлгүүр, сүлжээ супермаркетуудаар түгээлт хийдэг. Гэвч Нийтийн тээврийн бодлогын газраас 5-6 гудамж замд явах эрх өгдөг. Иймд санал болгож буй зорчих гудамж замыг 10-12 болгон хүрээг нэмэгдүүлэх;
- Зогсоолын хүртээмж муу, 1 дүгээр эгнээнд түр зогсож, ачаа бараа буулгадаг байх;
- Бараа бүтээгдэхүүний шөнийн түгээлтийн хэрэгжүүлэхгүй байх.

Аюултай ачаа тээвэрлэгч:

- Гудамж замд даац хэтэрсэн тээврийн хэрэгслээр оролцох асуудал үүсдэг.
- Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайдын 2009 оны 188 дугаар тушаалаар баталсан “Автотээврийн хэрэгслээр хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд аюул, хохирол учруулж болзошгүй ачаа тээвэрлэх журам”-д заасны дагуу цагдаагийн байгууллагын зөвшөөрлийг үндэслэн замын хуудас олгох;

Хүрсэн үр дүн: “Түр” зөвшөөрлийг “Тээврийн хэрэгслийн нэгдсэн цахим үйлчилгээний систем” мэдээллийн санг “Ачааны төрөл”-өөс хамаарч дараах нэр төрлөөр гарах хөгжүүлэлт хийгдсэн.



1.4.3.Авто тээврийн хэрэгслийн ашиглалтаас үүсэх хог хаягдлыг боловсруулах нэгдсэн сүлжээг бий болгох.

Авто үйлчилгээ эрхлэгчдийн үйл ажиллагаанаас үүсэх хог хаягдлын судалгааг шинэчлэх зорилгоор 9 дүүргийн Засаг даргын Тамгын газарт 2024 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн 01/04/835 дугаартай албан бичгийг хүргүүлсэн. Нийслэлийн 9 дүүргийн хэмжээнд авто үйлчилгээ эрхлэгчдийн ажил үйлчилгээнээс үүсэж буй энгийн болон аюултай хог хаягдлын төрөл, тоон хэмжээ мэдээллийг нэгтгэж, үүсэж буй хог хаягдлыг устгах, дахин боловсруулах талаар ирүүлсэн саналуудад дүн шинжилгээ хийж мэдээллийг нэгтгэн ажилласан.

Судалгаагаар Нийслэлийн 9 дүүргийн хэмжээнд 2024 оны байдлаар бүртгэлтэй 1400 авто үйлчилгээ эрхлэгч иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас хог хаягдлын судалгаанд 1100 авто үйлчилгээ эрхлэгч буюу 78,6% нь хамрагдсан байна.

ХОЁРДУГААР БҮЛЭГ. НИЙТИЙН ТЭЭВРИЙН БОДЛОГЫН ГАЗРЫН ДҮРМЭЭР ХҮЛЭЭСЭН ҮҮРГИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН.

Нийслэлийн Засаг даргын 2024 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн А/536 дугаар захирамжаар батлагдсан Нийтийн тээврийн бодлогын газрын “Дүрэм”-ээр хүлээсэн үүргийг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд хэрэгжүүлэх 8 арга хэмжээг 98,7 хувийн хэрэгжилттэй гүйцэтгэж ажилласан.

2.1.Нийтийн тээврийн үйлчилгээний зорчих үнэ, тариф, машин цагийн зардлыг шинэчлэн тогтоох тооцоо, судалгааг хийж, санал боловсруулах, нийтийн тээврийг хөгжүүлэх сантай холбоотой асуудлыг эрх бүхий байгууллагаар шийдвэрлүүлэх, хяналт тавих; 4.1.1.1.

Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хууль 2023 оны 12 дугаар сарын 07-ны өдөр Монгол Улсын Их Хурлаар батлагдсан.

2024 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 03 дугаар тогтоолоор “Нийслэлийн нийтийн тээврийг хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, захиран зарцуулах, хяналт тавих журам” батлагдсан.

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 79 дүгээр тогтоолоор батлагдсан “Машин цагийн зардлын тариф”-ыг 2024 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 26 дугаар тогтоолоор шинэчлэн батлагдаж нийтийн тээврийн салбарын жолооч нарын сарын цалин 3,5 сая төгрөг, инженер техникийн ажилчдын цалин 3,0 сая төгрөг болж тус тус нэмэгдсэн бөгөөд 2024 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс мөрдөж эхэлсэн.

2.2.Хууль тогтоомж, дүрэм, журмын хүрээнд тээвэрлэлт гүйцэтгэх аж ахуйн нэгж, байгууллагыг сонгон шалгаруулах, стандартын шаардлагыг хангаж буй эсэх талаар дүгнэлт гаргах, түвшин тогтоох /аттестатчилал/ явуулах; 4.1.1.2.

2.2.1. Нийтийн тээврийн үйлчилгээний аж ахуйн нэгж байгууллагуудын 2024-2025 оны өвөлжилтийн бэлтгэлийг хангуулах ажлын хэсгийг байгуулах, холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулна.

Нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллагуудын өвөлжилтийн бэлтгэл хангах талаар гаргасан төлөвлөгөөний дагуу авсан арга хэмжээ, үр дүн, цаг үеийн нөхцөл байдлын талаарх мэдээ, тайланг сар бүр бичгээр болон цахимаар хүлээн авч хэрэгжилтэд хяналт тавин ажилласан.

Нийтийн тээврийн бодлогын газрын даргын 2024 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн А/126 дугаар тушаалаар баталсан удирдамжийн дагуу Нийтийн тээврийн үйлчилгээний байгууллагуудын өвөлжилтийн бэлтгэлийг хангуулах, ажлын явцыг эрчимжүүлэх, өвлийн улирлыг хүндрэл бэрхшээлгүй өнгөрүүлэх зорилгоор 2 ажлын хэсэг байгуулагдаж 2024 оны 10 дугаар сарын 22-ны өдрөөс 10 дугаар сарын 24-ний өдрүүдэд шалгалтыг хийсэн.

Шалгалтад Нийтийн тээврийн бодлогын газартай гэрээ байгуулан ажилладаг үндсэн чиглэлийн 19 ААНБ хамрагдахаас 19 ААНБ буюу 100 хувь хамрагдсан.

Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанд 2023-2024, 2024-2025 оны нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллагуудын өвөлжилтийн бэлтгэл ажлын явцын мэдээг 2024.01.03, 2024.02.01, 2024.03.06, 2024.04.03, 2024.06.07, 2024.08.09,



2024.09.06, 2024.11.05-нд 01/03/63, 01/03/357, 01/03/606, 01/03/887, 02/03/1476, 02/03/1941, 01/03/2195, 01/03/2815 дугаартай албан бичгүүдийг хүргүүлсэн.

Салбарын 2024-2025 оны өвөлжилтийн бэлтгэл ажлын төлөвлөгөөний хэрэгжилтийн дундаж 83,6 хувьтай байна.

Парк шинэчлэлт буюу нөхөн хангалт 72,3 хувь, тээврийн хэрэгслийн техникийн бэлэн байдал 82,7 хувь, нийтийн тээврийн үйлчилгээг хэвийн явуулахад шаардагдах шатахуун, зайлшгүй шаардлагатай сэлбэг, шатах тослох материал, хөлддөггүй шингэн, спиртийн нөөцлөлт 83,6 хувьтай байна.

Нийт байгууллагуудын хэмжээнд 3,1 тэрбум төгрөгийн сэлбэг хэрэгсэл, 1305 ширхэг дугуй, хөлддөггүй шингэн, шатах тослох материалын нөөц 194,0 мянган тонн, аккумулятор 427 ширхэг, 2,4 тэрбум төгрөгийн шатах тослох материалыг нөөцөлсөн байсан.

Нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллагууд 2024 оны 11 дүгээр сарын 01-ний байдлаар үйлчилгээг хэвийн явуулахад шаардагдах шатахуун, зайлшгүй шаардлагатай сэлбэг, шатах тослох материал, хөлддөггүй шингэн, спиртийн нөөцлөлт, аж ахуйн нэгжийн барилга байгууламж, сантехник, дулаан, цахилгаан шугам сүлжээний засвар, дулаалга, засвар үйлчилгээг хийх, цэвэр ус, халаалтын найдвартай ажиллагааг хангахад нийт 16,9 тэрбум төгрөгийг төлөвлөгөөндөө тусган ажиллаж байна.


Шалгалтад хамрагдсан үндсэн чиглэлийн 19 аж ахуйн нэгжүүдийн 63% буюу 12 ААНБ 90-ээс дээш оноо, 27% нь буюу 5 ААНБ 80-аас 90 хүртэлх оноо, 5% нь буюу 1 ААН 70-аас 80 хүртэлх оноо, 5% нь буюу 1 ААН 70-аас доош оноотой дүгнэгдсэн.

2.2.2. Зөвшөөрлийн тухай хуулийн 3.4 дүгээр зүйлийн 3, 4 дэх хэсэг, 8.1 дүгээр зүйлийн 5.12 дахь заалт 9.6 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар “Улаанбаатар хот доторх болон хот орчмын нийтийн зорчигч тээврийн үйлчилгээ эрхлэх” тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагыг хангасан нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллагуудад олгуулах ажлыг зохион байгуулах.

Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 5.12 дахь заалтад заасан нийтийн зорчигч тээвэр, такси үйлчилгээг тусгай зөвшөөрөлтэйгөөр эрхлэх тухай зохицуулалтыг 2024 оны 10 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр хуульчилсан. Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах зорилгоор Нийслэлийн Засаг даргын 2024 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн А/1121 дүгээр захирамжаар “Байнгын үйл ажиллагаатай Комиссын бүрэлдэхүүн, ажиллах удирдамж”-ийг баталсан. Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах зорилгоор Нийслэлийн Засаг даргын 2024 оны 09 дүгээр сарын 25-ны А/1121 дугаартай захирамжаар тусгай зөвшөөрөл олгох, хугацааг сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох эсэхийг магадлан шалгах үүрэг бүхий байнгын үйл ажиллагаатай Комиссын бүрэлдэхүүн, ажиллах удирдамж батлагдсан. Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/1121 дугаартай захирамжийн хэрэгжилтийг хангах зорилгоор тус газрын даргын 2024 оны А/112 дугаар тушаалаар Ажлын хэсгүүд байгуулагдсан. Зөвшөөрлийн тухай хуульд зааснаар нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч 26 хуулийн этгээд тусгай зөвшөөрөл олгуулах хүсэлт тус газарт ирүүлсэн бөгөөд мэдээллийг Нийслэлийн Засаг даргын баталсан удирдамжийн дагуу ажлын хэсгүүд байгуулагдсан.

Ажлын хэсэг магадлан шалгаж тусгай зөвшөөрөл олгох эсэх талаар санал боловсруулж, 2024 оны 10 дугаар сарын 10, 11 дүгээр сарын 11, 12, 14, 19, 22-ны өдрийн Комиссын хуралд танилцуулсны дагуу холбогдох нөхцөл, шаардлага хангасан Зорчигч тээвэр нэг ОНӨААТҮГ, Зорчигч тээвэр хоёр ОНӨААТҮГ, Автотерминал трейд ХХК, Буянт хөлгийн жолоо ХХК, ДЮЦ ХХК, Трансбус ХХК, Зорчигч тээвэр тав ОНӨААТҮГ, Блюбус ХХК, Сутайнбуянт ХХК, Эрдэмтранс ХХК, Мязлаа ХХК, ЭМСИД ХХК, Автобус нэгдэл ХХК, Гбус ХХК, Эс Энд Эй Транс ХХК, Тэнүүн огоо гуравдугаар бааз ХХК-ууд хуульд заасан нөхцөл, шаардлагыг бүрэн хангасан тул тусгай зөвшөөрөл олгуулах санал гаргаж, Сайхан ирээдүй ХХК, Тэ бэ сервис ХХК-ууд хуульд заасан нөхцөл, шаардлагыг хангаагүй тул тусгай зөвшөөрөл олгохоос татгалзсан санал гаргаж, холбогдох санал, дүгнэлтийг Нийслэлийн Засаг даргад хүргүүлсэн. Нийт нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч 16 /үндсэн-15, буухиа-1/ аж ахуйн нэгж, байгууллагуудад тусгай зөвшөөрөл олгуулах санал хүргүүлсэн, 2 /үндсэн-1, такси-1/ аж ахуйн нэгж, байгууллагад тусгай зөвшөөрөл олгохоос татгалзсан комиссын шийдвэрийг Нийслэлийн Засаг даргад албан бичгээр хүргүүлсэн.

Нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч 24 аж ахуйн нэгж байгууллагаас тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагыг хангасан 21, хангаагүй 5 аж ахуйн нэгж байгууллага байна.



Зураг №25. тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагыг хангаж буй эсэхийг магадлан шалгаж буй байдал

2.3.Хотын доторх болон хот орчмын нийтийн зорчигч тээврийн сүлжээ, төлөвлөлт, үйлчилгээний чиглэлийг тогтоох, чиглэл, зогсоолыг шинээр нээх, хаах, өөрчлөх, бүртгэлжүүлэх, цагийн хуваарь тогтоох; 4.1.2.2.

Дагуул, хаяа хот, тосгодоод оршин суудаг иргэдийн нийтийн тээврийн зорчих эрэлтийг хангах, нийтийн тээврийн хүртээмжийг нэмэгдүүлэх, зогсоол хоорондын зайг ойртуулах үүднээс Хот орчмын чиглэлийн нийт 8 чиглэлийг шинээр нээж, 4 чиглэлийн замналд өөрчлөлт оруулж, 12 чиглэлийн замналд 27 зогсоолыг нэмж, төлөвлөлтийг сайжруулан ажилласан байна. Үүнд:

1.2024 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн А/38 дугаар тушаалаар Сонгинохайрхан дүүргийн 32 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах 20 зогсоолуудыг нийтийн тээврийн Х:10, Х:11, Х:13, Х:14, Х:15 нийт 5 чиглэлд нэмж,

2.2024 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн А/45 дугаар тушаалаар Х:17 “Улаанбаатар (Дүнжингарав худалдааны төв) – Багануур (Хэрлэн худалдааны төв)” чиглэлийн замналыг шинээр нээж,

3.2024 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн А/46 дугаар тушаалаар Х:18 “Улаанбаатар (Дүнжингарав худалдааны төв) – Багахангай эцсийн зогсоол чиглэлийн замналыг шинээр нээж,

4.Чингис хаан Олон улсын нисэх онгоцны буудлаар үйлчлүүлж буй иргэдэд нийтийн тээврийн үйлчилгээг хүргэх зорилгоор 2024 оны 04 дүгээр 17-ны өдрийн А/47 дугаар тушаалаар Х:19 “Чингис хаан Олон улсын нисэх буудал”, Х:20 “Чингис хаан Олон улсын нисэх буудал-Буянт-Ухаа спорт цогцолбор” чиглэлүүдийн замналыг шинээр нээж,

5.2024 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн А/52 дугаар тушаалаар Х:21 “Ногоон толгойн эцэс-Жаргалант/Партизан/-5 шар” чиглэлийн замналыг шинээр нээж,

6.2024 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн А/83 дугаар тушаалаар Д:6 “Шар хоолойн ам- Гачууртын эцэс”, Д:7 “Гачууртын эцэс- Арцатын ам” чиглэлүүдийг шинээр нээж

7.2024 оны 08 дугаар сарын 29-ний А/101 дүгээр тушаалаар Шарга морьт завсар (баруун) зогсоолыг Х:1 “Санзайн эцэс- Зунжин- 7 буудал”, Х:2 “Шарга морьт- 7 буудал”, ЗҮ:3 “Баянбулаг- Сүхбаатарын талбай” чиглэлүүдийн замналд нэмж,



8.2024 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн А/124 дүгээр тушаалаар Хонхор нуур, Хонхор нуур 1-р сургууль (урд, хойд) зогсоолуудыг Х:4 “Тэрэлж- Налайх- Офицеруудын ордон”, Х:5 “Налайх- Офицеруудын ордон” чиглэлүүдийн замналд нэмж,

9.Хан- Уул дүүргийн 14-р хорооны нутаг дэвсгэрт шинээр тохижуулсан Өлзийтийн зогсоол (баруун, зүүн) хос зогсоолуудыг Х:6 “Өлзийт хороолол- Яармагийн 3-р буудал” чиглэлд 2024 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн А/127 дугаар тушаалаар нэмж,

10.Налайх дүүргийн 1 дүгээр хорооны нутаг дэвсгэрт харьяалагдах Мойлтын тохой (баруун, зүүн) зогсоолуудыг 2024 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн А/124 дүгээр тушаалаар Х:4 “Тэрэлж- Налайх- Офицеруудын ордон” чиглэлийн замналд нэмж

11.Сонгинохайрхан дүүргийн 32 дугаар хорооны иргэдийн санал, хүсэлтийн дагуу 2024 оны 11 дүгээр сарын 05-ны А/131 дүгээр тушаалаар Х:11 “Хүй 7 долоо худаг- Эмээлт (хурган)- 5 шар” чиглэлийн замналыг Х:11 “Хүй 7 долоо худаг- Эмээлт - 5 шар” болгон өөрчилж,

12.Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үүднээс 2024 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн А/136 дугаар тушаалаар Х:10 “Эмээлт (хурган)- 5 шар” чиглэлийн замналыг Х:10 “Хурган 6-р гудамж - 5 шар” болгон өөрчилж,

13.Налайх дүүргийн иргэдийн санал хүсэлтийн дагуу 2024 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн А/137 дугаар тушаалаар Х:16 “Налайх- Нарлагийн зам- Нарангийн эцсийн зогсоол” чиглэлийн замналыг Х:16 “10 шар байр- 1-р хороо- Шинэ зам- Нарангийн эцсийн зогсоол” болгон өөрчилж,

14.2024 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн А/119 дүгээр тушаалаар Х:20 “Чингис хаан олон улсын нисэх онгоцны буудал- Буянт- Ухаа спорт цогцолбор” чиглэлийн замналыг “Чингис хаан олон улсын нисэх онгоцны буудал- 5 шар” болгон өөрчилж баталсан байна.

Хөшигийн хөндийн нисэх буудлыг бүс нутгийн зангилаа төв болгон хөгжүүлэх, орчин үеийн технологид тулгуурласан нийтийн тээврийн шинэ тогтолцоог Улаанбаатар хотод бий болгох судалгаа явуулах ажлын хүрээнд:

Хөшигийн хөндийд байрлах Чингис хаан Олон улсын нисэх буудал хүртэл нийтийн тээврийн үйлчилгээг хүргэхээр 2021, 2022, 2023 онуудад эхлүүлсэн боловч зорчигч урсгал багатай, ашиглалтын зардал өндөр, зардлын санхүүжилт шийдэгдээгүйгээс үйлчилгээ зогссон.

Зам тээврийн хөгжлийн яам, Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас өгсөн үүрэг чиглэлийн дагуу 2024 оны 03 дугаар сарын 19-ний өдөр Чингис хаан Олон улсын нисэх буудалд Зам тээврийн хөгжлийн яам, Нийтийн тээврийн газар, Нийслэлийн аялал жуулчлалын газар, Улаанбаатар хөгжлийн корпорац, Тээврийн Цагдаагийн алба, Нью Улаанбаатар Интернейшнл эйрпорт ХХК-ийн удирдлагууд уулзалт хийж Нийслэлийн зүгээс зардлын санхүүжилтийг төсөвт тусгах болсонтой холбоотойгоор 2024 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн 01/03/701 дугаартай албан бичгээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт нийтийн тээврийн үйлчилгээний холбогдох танилцуулга, машин цагийн зардлын тооцоо болон цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх мэдээллийг хүргүүлсэн.

Нийтийн тээврийн үйлчилгээнд Чингис хаан олон улсын нисэх онгоцны буудал-Сүхбаатарын талбай” чиглэлд тээврийн хэрэгслээр өдөр бүр үйлчилгээнд ажиллах тохиолдолд гарах зардлын тооцооллыг боловсруулсан. Үүнд:

Хувилбар:1 Ажил, амралтын өдөр 1 тээврийн хэрэгслээр 16 цаг ажиллавал 1 өдрийн машин цагийн зардал 1,292,912 төгрөг, нэг сарын нийт зардал 38,787,360 төгрөг, нэг жилийн нийт зардал (3-12 сар) 395,631,072 төгрөг

Хувилбар:2 Ажил, амралтын өдөр 1 тээврийн хэрэгслээр 24 цаг ажиллавал 1 өдрийн машин цагийн зардал 1,939,368 төгрөг, нэг сарын нийт зардал 58,181,040 төгрөг, нэг жилийн нийт зардал (3-12 сар) 593,446,608 төгрөг

Хувилбар:3 Ажил, амралтын өдөр 4 тээврийн хэрэгслээр 16 цаг ажиллавал 1 өдрийн машин цагийн зардал 5,171,648 төгрөг, нэг сарын нийт зардал 155,149,440 төгрөг, нэг жилийн нийт зардал (3-12 сар) 1,582,524,288 төгрөг

Хувилбар:4 Ажил, амралтын өдөр 4 тээврийн хэрэгслээр 24 цаг ажиллавал 1 өдрийн машин цагийн зардал 7,757,472 төгрөг, нэг сарын нийт зардал 232,724,160 төгрөг, нэг жилийн нийт зардал (3-12 сар) 2,373,786,432 төгрөг болохоор тооцоолол хийгдсэн.

Хүснэгт 24



Хувилбар:1 нэг тээврийн хэрэгсэл өдөрт 16 цаг ажиллах

Чиглэлийн №	Чиглэлийн нэр	Эргэлтийн урт /км/	Ажлын өдөр			
			Нэг өдрийн			
			Ажиллах ТХТ	ТХ-ийн ажиллах цаг	Нэг цагийн зардал	Нийт ТХ-ийн зардал /төгрөг/
Экспресс:1	“Чингис хаан Олон улсын нисэх онгоцны буудал – Сүхбаатарын талбай”	95.6	1	16:00:00	80,807	1,292,912

Амралтын өдөр				Нэг сарын зардал	Нэг жилийн зардал /3-12 сар/
Нэг өдрийн					
Ажиллах ТХТ	ТХ-ийн ажиллах цаг	Нэг цагийн зардал	Нийт ТХ-ийн зардал /төгрөг/		
1	16:00:00	80,807	1,292,912	38,787,360	395,631,072

Хувилбар:2 Нэг тээврийн хэрэгсэл өдөрт 24 цаг ажиллах

Чиглэлийн №	Чиглэлийн нэр	Эргэлтийн урт /км/	Ажлын өдөр			
			Нэг өдрийн			
			Ажиллах ТХТ	ТХ-ийн ажиллах цаг	Нэг цагийн зардал	Нийт ТХ-ийн зардал /төгрөг/
Экспресс:1	“Чингис хаан Олон улсын нисэх онгоцны буудал – Сүхбаатарын талбай”	95.6	1	24:00:00	80,807	1,939,368

Амралтын өдөр				Нэг сарын зардал	Нэг жилийн зардал /3-12 сар/
Нэг өдрийн					
Ажиллах ТХТ	ТХ-ийн ажиллах цаг	Нэг цагийн зардал	Нийт ТХ-ийн зардал /төгрөг/		
1	30:00:00	80,807	1,939,368	58,181,040	593,446,608

Хувилбар:3 Дөрвөн тээврийн хэрэгсэл өдөрт 16 цаг ажиллах

Чиглэлийн №	Чиглэлийн нэр	Эргэлтийн урт /км/	Ажлын өдөр			
			Нэг өдрийн			
			Ажиллах ТХТ	ТХ-ийн ажиллах цаг	Нэг цагийн зардал	Нийт ТХ-ийн зардал /төгрөг/
Экспресс:1	“Чингис хаан Олон улсын нисэх онгоцны буудал – Сүхбаатарын талбай”	95.6	4	64:00:00	80,807	5,171,648

Амралтын өдөр				Нэг сарын зардал	Нэг жилийн зардал /3-12 сар/
Нэг өдрийн					
Ажиллах ТХТ	ТХ-ийн ажиллах цаг	Нэг цагийн зардал	Нийт ТХ-ийн зардал /төгрөг/		
4	64:00:00	80,807	5,171,648	155,149,440	1,582,524,288




Хувилбар:4 Дөрвөн тээврийн хэрэгсэл өдөрт 24 цаг ажиллах

Чиглэлийн №	Чиглэлийн нэр	Эргэлтийн урт /км/	Ажлын өдөр			
			Нэг өдрийн			
			Ажиллах ТХТ	ТХ-ийн ажиллах цаг	Нэг цагийн зардал	Нийт ТХ-ийн зардал /төгрөг/
Экспресс:1	“Чингис хаан Олон улсын нисэх онгоцны буудал – Сүхбаатарын талбай”	95.6	4	96:00:00	80,807	7,757,472


Амралтын өдөр				Нэг сарын зардал	Нэг жилийн зардал /3-12 сар/
Нэг өдрийн					
Ажиллах ТХТ	ТХ-ийн ажиллах цаг	Нэг цагийн зардал	Нийт ТХ-ийн зардал /төгрөг/		
4	96:00:00	80,807	7,757,472	232,724,160	2,373,786,432

Чингис хаан Олон улсын нисэх онгоцны буудлаар үйлчлүүлж буй иргэдэд нийтийн тээврийн үйлчилгээг хүргэх зорилгоор Х:19 “Чингис хаан Олон улсын нисэх буудал-Сүхбаатарын талбай”, Х:20 “Чингис хаан Олон улсын нисэх буудал-Буянт-Ухаа спорт цогцолбор” чиглэлийг 2024 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн А/47 дугаар тушаалаар баталсан.

Х:20 “Чингис хаан Олон улсын нисэх буудал – Буянт-Ухаа спорт цогцолбор”



Х:19 “Чингис хаан Олон улсын нисэх буудал – Сүхбаатарын талбайн төв зогсоол”



Зураг №26. Х:19 “Чингис хаан Олон улсын нисэх буудал-Сүхбаатарын талбай”, Х:20 “Чингис хаан Олон улсын нисэх буудал-Буянт-Ухаа спорт цогцолбор” чиглэл маршрут

Тус хоёр чиглэлийн үйлчилгээг 2024 оны 07 дугаар сарын 04-ний өдрөөс эхлүүлсэн бөгөөд 2024 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар тус 2 чиглэлээр нийт 948 зорчигч үйлчлүүлсэн байгаагаас 07, 08 дугаар сар буюу аялал жуулчлалын сарууд зорчигч урсгал хамгийн их байсан.

Чингис хаан олон улсын нисэх онгоцны буудлаар үйлчлүүлж буй иргэдэд нийтийн тээврийн үйлчилгээг хүртээмжтэй хүргэх зорилгоор Х:20 “Чингис хаан олон улсын нисэх онгоцны буудал- Буянт- Ухаа спорт цогцолбор” чиглэлийн замналыг “Чингис хаан олон улсын нисэх онгоцны буудал- 5 шар” болгон өөрчилж Нийтийн тээврийн бодлогын газрын даргын 2024 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн А/119 дугаар тушаалаар баталсан. Тус чиглэлд өөрчлөлт оруулсны дараагаар зорчигч урсгал өмнөх сартай нь харьцуулахад 20 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

2.4.Нийтийн тээврийн үйлчилгээний автобусны эцсийн болон дундын зогсоолын барилга байгууламжийн ашиглалтад хяналт тавьж, тохижилт болон урсгал засварын ажлыг зохион байгуулах; 4.1.2.3.

Эдийн засаг хөгжлийн яамнаас Офицеруудын ордон, 120 мянгат орчимд терминалын зураг төсөл боловсруулах сонгон шалгаруулалтыг 2023 онд зохион байгуулж “Нийтийн тээврийн нэг маягийн 2 терминал байгуулах зураг төсөл боловсруулах” тендерт Гео зураглал



ХХК нь шалгарч 2023 оны 08 дугаар сарын 14-ний өдрийн ЭЗХЯ/94 дугаартай гэрээ байгуулан ажиллаж байна. Нийтийн тээврийн нэг маягийн 2 терминал байгуулахаар сонгосон байршилд газар чөлөөлөх асуудлаар Нийслэлийн Газар зохион байгуулалтын албанд 2024 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн 01/02/1386 дугаартай албан бичиг, Хот байгуулалт хөгжлийн газарт 2024 оны 04 дугаар сарын 25-ны өдрийн 01/06/1108 дугаартай албан бичгийг тус тус хүргүүлэн ажилласан. Мөн тус 2 байршилд терминал байгуулах хэрэгцээ шаардлага, түгжрэлд үзүүлэх нөлөөлөл, холбогдох тооцоо судалгааг ирүүлэх талаар Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах үндэсний хороонд 2024 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн 01/0/1386 дугаартай албан бичгээр хүргүүлсэн.

Нийтийн тээврийн нэг маягийн 2 терминал байгуулах зураг төсөл боловсруулах” тендерт шалгарсан Гео зураглал ХХК-тай 2023 оны 08 дугаар сарын 14-ний өдрийн ЭЗХЯ/94 дугаартай гэрээ байгуулан ажиллаж байсан. Гэвч газар чөлөөлөх асуудал эцэслэн шийдвэрлэгдээгүйгээс Эдийн засаг, хөгжлийн яамнаас төслийн санхүүжилтийг зогсоож, гэрээний хугацаа дуусгавар болсон.

Баянзүрх дүүргийн 11-р хороо, 28-р хороо, нутаг дэвсгэрт шинээр байгуулсан Усан сангийн автобусны зогсоолын байгууламжийг нийслэлд хүлээлгэж өгөх хүсэлтийн дагуу хүлээн авах комисст 2024 оны 06 дугаар сарын 13-ны өдөр ажиллаж санал өгсөн.

Сүхбаатар дүүргийн 14 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн Рашаант 2 автобусны зогсоолын шилэн самбар эвдэрч сүйдсэнийг засварлах болон эзэн холбогдогчийг тогтоох ажлыг зохион байгуулсан.



Зураг №27. Рашаант 2 автобусны зогсоолын шилэн самбар эвдэрч сүйдсэн байдал

2.4.1. Чингэлтэй дүүргийн 17,18-р хороонд Азийн хөгжлийн банкнаас хэрэгжүүлж буй “Гэр хорооллын нийтийн тээврийн үйлчилгээг сайжруулах нь” техникийн туслалцааны төслийн багтай хамтран ажиллах.

Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжиж байгаа “Гэр хорооллын тээврийн үйлчилгээг сайжруулах” техникийн туслалцааны төслийн хүрээнд дараах ажлуудыг гүйцэтгэсэн. Үүнд:

1. “Гэр хорооллын тээврийн үйлчилгээг сайжруулах” төслийн хүрээнд нийтийн тээврийн үйлчилгээний “Нийтийн тээврийн мэдээллийн систем” хөгжүүлэх ажлыг гүйцэтгэгч Инфокон ХХК-иас Нийтийн тээврийн мэдээллийн нэгдсэн системийг танилцуулах, ашиглалтын талаарх зааварчилгаа өгөх 2 удаагийн сургалтыг зохион байгуулав. Үүнд:

2. Нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж байгууллагын ажилтнуудад зориулан 2024 оны 03 дугаар сарын 28-нд зохион байгуулсан сургалтад 30 аж ахуйн нэгж, байгууллагын нийт 48 хүн хамрагдахаас 28 аж ахуйн нэгж, байгууллагын 44 ажилтан хамрагдсан бол тус байгууллагын мэргэжилтнүүдэд зориулан 2024 оны 04 дүгээр сарын 02-нд зохион байгуулсан сургалтад нийт 35 ажилтан албан хаагч тус тус хамрагдсан.



Зураг 28. Компанит ажлын сургалтын явц

Нийслэлийн гэр хорооллын гудамж, зам талбайд нийтийн тээврийн хүртээмж, үйлчилгээг сайжруулах, явган зорчигчдын аюулгүй байдлыг хангах зорилгоор Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Азийн хөгжлийн банк хамтран “Гэр хорооллын нийтийн тээврийн үйлчилгээг сайжруулах” төслийг хэрэгжүүлэн, Чингэлтэй дүүргийн 17, 18, 23 дугаар хорооны нутаг дэвсгэрт битүү хоёр, задгай 17 шинэ автобусны зогсоолыг 2024 оны 05 дугаар сарын 08-ны өдөр ашиглалтад орууллаа.



Зураг №29. Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Азийн хөгжлийн банк хамтран “Гэр хорооллын нийтийн тээврийн үйлчилгээг сайжруулах” төслийн хүрээнд тохижуулсан зогсоол

Иргэдэд үзүүлэх үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, үйлчилгээг цахимжуулах чиглэлээр үр дүнтэй арга хэмжээ авч ажилласан байна. “Гэр хорооллын тээврийн үйлчилгээг сайжруулах” төслийн хүрээнд нийтийн тээврийн үйлчилгээний "Нийтийн тээврийн мэдээллийн систем" хөгжүүлэх ажлыг гүйцэтгэгч Инфокон ХХК-иас 2024 оны 04 дүгээр сарын 02-нд зохион байгуулсан.

Нийтийн тээврийн мэдээллийн нэгдсэн системийг танилцуулах, ашиглалтын талаарх зааварчилгаа өгөх сургалтыг зохион байгуулсан.

Мөн санал, гомдлыг иргэдээс хүлээн авах цахим хуудсанд жолооч болон тээврийн хэрэгслийн мэдээллийн санг нэмэлтээр хөгжүүлж, улсын хэмжээний автотээврийн нэгдсэн



бүртгэл, мэргэшсэн жолоочийн нэгдсэн бүртгэлтэй холбогдож мэдээлэл авах боломжтой болсон. Тээвэрлэгч аж ахуйн нэгж байгууллагууд тээврийн хэрэгсэл жолооч бүртгэх хүсэлтээ өөрсдөө илгээх, бүртгэл мэдээллийн сан тоогоо вэб суурьтай хөтчөөр дамжуулан харах нөхцөл бүрдсэн.

Тус газар нь ЦХХХЯ-тай гэрээ байгуулж ХУР болон И-Монголиа ашиглан тээврийн хэрэгсэл болон жолоочийн мэдээллийг Авто тээврийн үндэсний төвөөс API ашиглан татан авч байна.

-Танилт нэвтрэлтийн ДАН систем ашиглан нэвтэрч санал хүсэлт, өргөдөл гомдол илгээх боломжтой болсон.

Өргөдөл гомдлын мэдээллийн санг бусад мэдээллүүдтэй нь холбох зорилгоор тээврийн хэрэгслийн, жолоочийн, хүний нөөцийн, зөрчлийн санал хүсэлт, өргөдөл, гомдол талархлын, чиглэл, зогсоолын зэрэг 6 төрлийн мэдээллийн сангийн хөгжүүлэлт хийгдэж дууссан бөгөөд нийт зөрчлийн тайлангийн модулийн хөгжүүлэлт дуусч Нийтийн тээврийн мэдээллийн нэгдсэн системийг танилцуулах, ашиглалтын талаарх зааварчилгаа өгөх 2 удаагийн сургалтыг зохион байгуулав. Үүнд:

-Нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж байгууллагын ажилтнуудад зориулан 2024 оны 03 дугаар сарын 28-нд зохион байгуулсан сургалтад 30 аж ахуйн нэгж, байгууллагын нийт 48 хүн хамрагдахаас 28 аж ахуйн нэгж, байгууллагын 44 ажилтан;

-Тус байгууллагын мэргэжилтнүүдэд зориулан 2024 оны 04 дүгээр сарын 02-нд зохион байгуулсан сургалтад нийт 35 ажилтан албан хаагч тус тус хамрагдсан.

2.Хэрэгжүүлэгч байгууллага болон автобусны үйлчилгээ эрхлэгч байгууллагуудын чадавхыг сайжруулах.

Энэ ажлын хүрээнд дараах ажлууд хийгдэж байна.

Нийтийн тээврийн үйлчилгээг гүйцэтгүүлэх гэрээг хянаж гэрээ болон гүйцэтгэлийг дүгнэх аргачлалыг сайжруулах зөвлөмж гаргах

Жолооч нарт болон Инженер техникийн ажилтан нарт зориулсан гарын авлагыг хянаж шинэчлэх.

Төслийн хүрээнд хийгдэж жолоочийн гарын авлагыг боловсруулж буй Трансконсалтинг компанийн зөвлөхүүдтэй цахимаар уулзалт зохион байгуулж төслийн хүрээнд цаашид хамтран хийх ажлын төлөвлөгөөг гарган ажиллаж, үндэсний мэргэжилтнүүдээр орчуулга хийлгэх хүсэлт гаргаж, жолоочийн гарын авлагатай танилцаж холбогдох саналыг өгсөн.

Мөн ААНБ-ын төлөөлөлтэй хэлэлцүүлэг зохион байгуулж саналыг тусгуулан 2024 оны 06 дугаар сарын 04, 05-ны өдрүүдэд үйлчилгээ эрхлэгч ААНБ-уудад сургагч багш бэлтгэх сургалт, тус газрын албан хаагчдад Гэрээ, манлайлалтай холбоотой сургалт хийгдсэн.

Одоогоор гарын авлагын хураангуйг орчуулж комик байдлаар боловсруулах, гэрээний зөвлөмжийг эцэслэн орчуулах ажил хийгдэж байна.

3. Олон нийтэд түшиглэн зан үйлийг өөрчлөх

“Хөөрхөн зүрх” төрийн бус байгууллагатай 2024 оны 03, 04 дүгээр сард 2 удаагийн уулзалт зохион байгуулж, хамтран зохион байгуулах нөлөөллийн аяны хүрээнд хийгдэж буй 2 ш богино хэмжээний видео, 5 төрлийн зурагт хуудасны эцсийн загварыг эцэслэн автобуснуудад байршуулахаар хэвлэлтийн ажил хийгдэж, байгууллагын цахим хуудсаар бүүст хийн түгээж байна. “Олон нийтэд хандсан компани ажил”-ыг 2024 оны 05 дугаар сарын 08-ны өдөр Чингэлтэй дүүргийн нэгдсэн үйлчилгээний төвд зохион байгуулсан.

Азийн хөгжлийн банкны төсөл хэрэгжүүлэгч ITP компанийн гадаад зөвлөх зохион байгуулсан хяналт, шинжилгээ үнэлгээний 2024 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр тус газрын холбогдох албан хаагчийг оролцуулан зохион байгуулж, уг сургалтад хамрагдсан.



Зураг №30. Постор мэдээлэл



2024 оны 05 дугаар сарын 08-ны өдөр Азийн хөгжлийн банктай хамтран нийт 2.5 сая ам долларын өртгөөр Чингэлтэй дүүргийн 17,18,19 дүгээр хорооны нутаг дэвсгэрт битүү 2, задгай 17 шинэ автобусны зогсоолыг ашиглалтад оруулж, тус хорооны иргэдээс сэтгэл ханамжийн судалгаа авсан.

Нийслэлийн Баянзүрх дүүргийн 31 дүгээр хорооноос 2024 оны 05 дугаар сарын 31-ний өдөр “Тус хорооны Монелийн 430 дугаар худаг буюу Баялаг дэлгүүрийн автобусны зогсоол нь 4 замын уулзвар дээр байрладаг тул иргэдийн санал гомдол ихээр ирүүлсэн.

Иймд тус буудлыг Монелийн 33 дугаар гудамжны үзүүрт шилжүүлж өгнө үү” гэсэн хүсэлтийн дагуу 06 дугаар сарын 07-ны өдөр газар дээр нь очиж ажилласан. Тухайн санал ирүүлсэн байршил нь замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангаагүй тул шилжүүлэх боломжгүй талаар хариу албан бичиг хүргүүлсэн.



Зураг №31. 430 дугаар худаг буюу Баялаг дэлгүүрийн автобусны зогсоол

Баянзүрх дүүргийн 34 дүгээр хорооны нутаг дэвсгэрт шинээр байгуулсан Жанжин автобусны зогсоолын байгууламжийг нийслэлд хүлээлгэн өгөх хүсэлтийн дагуу хүлээн авах комисст 2024 оны 06 дугаар сарын 25-ны өдөр ажиллан даалгавар өгсөн.



Зураг №32. Жанжин автобусны зогсоолын байгууламж

“Нийтийн тээврийн үйлчилгээний зогсоол шинээр барих, шинэчлэх ажил”-ын хүрээнд шинээр хийхээр төлөвлөж буй “Сүүдрэвч болон үйлчилгээтэй дулаан танхим хосолсон зогсоол”-ын 13 байгууламжийн байршлыг 2024 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн 01/02/2706 дугаартай албан бичгээр Улаанбаатар Захирагчийн ажлын албанд болон гүйцэтгэгч Тэгш Хүслийн Гэрэл ХХК-д хүргүүлсэн.

Хүснэгт 25



№	Байршил		Зогсоолын нэр	Зогсоолын төрөл
	Дүүрэг	Хороо		
2	Баянзүрх дүүрэг	21-р хороо	Гадна тойруугын эцэс	Эцсийн зогсоол
3	Баянгол дүүрэг	20-р хороо	ТЭЦ-4	Эцсийн зогсоол
4	Сонгинохайрхан дүүрэг	36-р хороо	Улаанчулуутын эцэс	Эцсийн зогсоол
5	Баянзүрх дүүрэг	36-р хороо	Монгол Тэмүүлэл /хойд/	Дундын зогсоол
6	Баянзүрх дүүрэг	36-р хороо	Дунжингарав эцэс	Эцсийн зогсоол
7	Чингэлтэй дүүрэг	16-р хороо	Хайлаастын шинэ эцэс	Эцсийн зогсоол
8	Сонгинохайрхан дүүрэг	34-р хороо	Орбитын шинэ эцэс	Эцсийн зогсоол
9	Баянзүрх дүүрэг	16-р хороо	Улаанхуарангын эцэс	Эцсийн зогсоол
10	Баянзүрх дүүрэг	20-р хороо	Гачууртын эцэс	Эцсийн зогсоол
11	Сүхбаатар дүүрэг	19-р хороо	Санзайн эцэс	Эцсийн зогсоол

Автобусны буудлын тохижилтын ажлын хүрээнд:

2024 оны 07 дугаар сарын 25-ны өдөр Сүхбаатар дүүргийн 16, 17, 18 дугаар хорооны нутаг дэвсгэрт шинээр тохижуулсан зогсоолыг ашиглалтад оруулах комисст ажиллаж 5 битүү зогсоол,

2024 оны 09 дүгээр сарын 16-ны өдөр ГЕТ ХХК-ний гүйцэтгэсэн “Автобусны зогсоол барьж, тохижуулах ажил” Хан-Уул дүүргийн 15, 17, 18 дугаар хороонд хийгдсэн автобусны зогсоол,

2024 оны 10 дугаар сарын 08-ны өдөр “Энгийн очир констракшн” ХХК-ний гүйцэтгэсэн Баянзүрх дүүргийн 37 дугаар хорооны нутаг дэвсгэр Жанжин клубийн автобусны зогсоол,

2024 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр Хан-Уул дүүргийн 8 дугаар хорооны эцсийн зогсоолыг байнгын ашиглалтад оруулах комисст ажиллан үүрэг даалгаврын биелэлт өгч байнгын ашиглалтад тус тус оруулсан.



Зураг №33. Хан-Уул дүүргийн 8 дугаар хорооны эцсийн зогсоол

Нийтийн тээврийн үйлчилгээний автобусны эцсийн болон дундын зогсоолын нэгдсэн үзлэгийг зохион байгуулах ажлын хүрээнд:

Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2024 оны 09 дүгээр сарын 13-ны өдрийн шуурхай зөвлөгөөнөөс өгсөн үүргийн дагуу чиглэлийн тээврийн хэрэгслийн эцсийн болон дундын зогсоолуудад хамтран үзлэг явуулахад хамтран ажиллах талаар Нийслэлийн Замын Хөгжлийн газар, Цагдаагийн Ерөнхий газрын Тээврийн цагдаагийн алба, Нийслэлийн Газар зохион байгуулалтын алба, Хот байгуулалт, Хотын стандартын газар, Хяналт Шалгалтын газарт тус тус 2024 оны 09 дүгээр сарын 26-ны өдрийн 01/02/2368 дугаартай албан бичгээр хүргүүлж ажилласан байна.

2.5. Нийтийн тээврийн хэрэгсэл, сургуулийн болон ажилчдын автобус, нийслэлийн төр, захиргааны автотээврийн хэрэгсэлд техникийн хяналтын үзлэг хийх ажлыг зохион байгуулах; 4.1.2.5.

2.5.1. Нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч ААН, байгууллагуудын тээврийн хэрэгслийг техникийн хяналтын үзлэгт хамруулах ажил гүйцэтгэх:


Нийслэлийн нийтийн тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэгийг “Автотээврийн тухай хууль”, Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 213 дугаар “Автотээврийн хэрэгслийг үзлэгт оруулах хугацаа, оношилгооны төлбөрийн жишиг үнэ батлах тухай” тогтоол, Зам, тээврийн Сайдын 2013 оны 232 дугаар “Автотээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэг явуулах журам”, Монгол улсын стандарт MNS 4598:2020 “Автотээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих ерөнхий шаардлага”, MNS 5011:2003 “Автотээврийн хэрэгслийн техникийн



хяналтын үзлэг хийх заавар. Ерөнхий шаардлага”, MNS 5012:2021 “Нийтийн зорчигч тээврийн үйлчилгээ. Ангилал ба үйлчилгээнд тавих ерөнхий шаардлага”, MNS 5013:2009 “Бензин хөдөлгүүртэй автомашин - Утааны найрлага дахь хорт бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ ба хэмжих арга”, MNS 5014:2009 “Дизель хөдөлгүүртэй автомашин - Утааны тортогжилтын зөвшөөрөгдөх дээд хэмжээ ба хэмжих арга”, MNS 5044:2010 “Автотээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэгийн төв- Ангилал - Ерөнхий шаардлага”, MNS 6440:2014 “Хүүхэд тээвэрлэх автобус ба үйлчилгээнд тавих шаардлага”, MNS 5122:2013 “Таксийн үйлчилгээ. Ерөнхий шаардлага” зэрэг стандартыг мөрдөн ажилласан.

2.5.2. Хаврын ээлжит техникийн хяналтын үзлэгийн хүрээнд:

Нийслэлийн нийтийн тээврийн бодлогын газрын Даргын “Хаврын ээлжит техникийн хяналтын үзлэг зохион байгуулах тухай” 2024 оны А/37 дугаар тушаалаар батлагдсан хуваарийн дагуу үзлэгийг 2024 оны 04 дүгээр сарын 03-ны өдрөөс 05 дугаар сарын 24-ний өдрийн хооронд зохион байгуулан ажилласан.



Зураг №34. “Хаврын ээлжит техникийн хяналтын үзлэг зохион байгуулах тухай” 2024 оны А/37 дугаар тушаал


Үндсэн чиглэлийн нийт 791 тээврийн хэрэгсэл техник хяналтын үзлэгт хамрагдаж техникийн бүрэн бүтэн байдал нь хангагдаж тэнцсэн.

Ажилчдын автобус 133 автобусанд Техникийн хяналтын үзлэг хийж, дүгнэлт гаргасан. 114 автобус техникийн бүрэн бүтэн байдал нь хангагдаж тэнцэж, 19 техникийн бүрэн бус байдлын улмаас тэнцээгүй боловч техникийн бүрэн байдлыг хангаж давтан үзлэгээр дахин орж тэнцсэн. /85,7% хамрагдсан байна/

Нийслэлийн төр захиргааны байгууллагын эзэмшилд бүртгэлтэй 92 тээврийн хэрэгсэл техникийн хяналтын үзлэгт ороод байна. 89 автобус техникийн бүрэн бүтэн байдал нь хангагдаж тэнцэж, 3 техникийн бүрэн бус байдлын улмаас тэнцээгүй ч техникийн бүрэн бүтэн байдлаа хангаж давтан үзлэгээр дахин орж тэнцсэн. /99% хамрагдсан байна/.

Таксины чиглэл /суудлын/ 164 тээврийн хэрэгсэл техникийн хяналтын үзлэгт ороод байна. 151 автобус техникийн бүрэн байдал нь хангагдаж тэнцэж, 68 техникийн бүрэн бус байдлын улмаас тэнцээгүй, 55 автобус нь техникийн бүрэн бүтэн байдлаа хангаж давтан үзлэгээр дахин орж тэнцсэн. /92,1% хамрагдсан байна/

Буухиа чиглэл /бага/-9 тээврийн хэрэгсэл техникийн хяналтын үзлэгт ороод байна. 2 техникийн бүрэн бус байдлын улмаас тэнцээгүй ч техникийн бүрэн бүтэн байдлаа хангаж давтан үзлэгээр дахин орж тэнцсэн. /100% хамрагдсан байна/




Зураг №35. Хаврын ээлжит техникийн хяналтын үзлэг хийгдэж буй байдал

2.5.3. Намрын ээлжит хүүхдийн автобусны үзлэгийн хүрээнд:

Тус газар нь Автотээврийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т заасны дагуу Зам, тээврийн хөгжлийн Сайдын 2020 оны 11 дүгээр сарын 03-ний өдрийн А/205 дугаар тушаалаар олгосон “Автотээврийн хэрэгсэлд техникийн хяналтын үзлэг хийх ажил эрхлэх” тусгай зөвшөөрлийн хүрээнд тус яамтай 2020 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн 286 тоот “Автотээврийн хэрэгсэлд техникийн хяналтын үзлэг хийх ажил эрхлэх” гэрээ байгуулан ажиллаж байна. Дээрх гэрээний хүрээнд тус газрын Техникийн хяналтын үзлэгийн төв нь “Автотээврийн тухай хууль”, Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 213 дугаар “Автотээврийн хэрэгслийг үзлэгт оруулах хугацаа, оношилогооны төлбөрийн жишиг үнэ батлах тухай” тогтоол, Зам, тээврийн Сайдын 2013 оны 232 дугаар “Автотээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэг явуулах журам”-ын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Нийслэлийн ерөнхий боловсролын сургуулийн хүүхдийг тав тухтай, аюулгүй тээвэрлэх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор 2024 оны 08 дугаар сарын 21-ний өдрийн Тээврийн цагдаагийн алба болон нийслэлийн боловсролын газартай хамтран баталсан “Хүүхэд тээвэрлэх автобусны техникийн бүрэн байдлыг хангуулах ба үйлчилгээнд хяналт шалгалт хийх тухай удирдамж”-ийн хүрээнд сургуулийн хүүхэд тээвэрлэх автобусны намрын ээлжит техникийн хяналтын үзлэгийг 2024 оны 08 дугаар сарын 21-ний өдрөөс 08 дугаар сарын 30-ний өдрийн хооронд зохион байгуулан ажилласан.

Хүснэгт 26

№	Төрөл	Бүртгэлийнс анд байгаа тээврийн	Үзлэгт орох тээврийн хэрэгслийн	Орсон		Тэнцсэн		Тэнцээгүй		Ороогүй	
				тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь
1	Хүүхдийн автобус	221	191	221	115,7	215	97,3	6	2,7	15	6,7



Зураг №36. Хаврын ээлжит техникийн хяналтын үзлэг хийгдэж буй байдал

2.5.4. Намрын ээлжит техникийн хяналтын үзлэгийн хүрээнд:



Нийтийн тээврийн бодлогын газрын даргын 2024 оны 09 дүгээр сарын 10-ны өдрийн “Намрын ээлжит техникийн хяналтын үзлэг зохион байгуулах тухай” А/105 дугаар тушаалаар нийслэлийн нийтийн тээврийн их, дунд багтаамжийн автобус, троллейбус, ажилчдын автобус болон такси үйлчилгээний тээврийн хэрэгслүүдийн Техникийн хяналтын үзлэгийг 2024 оны 09 дүгээр сарын 25-ны өдрөөс 11 дүгээр сарын 15-ны өдрийг хүртэл хугацаанд зохион байгуулж, үзлэгт хамрагдах хуваарийг хавсралтаар баталсан. Уг тушаалын дагуу Нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч 30 байгууллагын тээврийн хэрэгслийг үзлэгт хамруулах ажил хийгдсэн. Үүнд:

1. Үндсэн чиглэлийн их багтаамжийн автобусны техникийн үзлэгт нийт 555 тээврийн хэрэгсэл хамрагдахаас:

Хамрагдсан – 546

Хамрагдаагүй – 9

Тэнцсэн – 469

Тэнцээгүй – 77

Давтан үзлэгт тэнцсэн – 77

Гүйцэтгэл 78,5%

2. Ажилчдын автобусны техникийн үзлэгт нийт 219 тээврийн хэрэгсэл хамрагдахаас:

Хамрагдсан – 172

Хамрагдаагүй – 47

Тэнцсэн – 154

Тэнцээгүй – 18

Давтан үзлэгт тэнцсэн – 18

Гүйцэтгэл 98,3%

3. Нийслэлийн төр, захиргааны тээврийн хэрэгслийн техникийн үзлэгт нийт 13 тээврийн хэрэгсэл хамрагдахаас:

Хамрагдсан – 13

Тэнцсэн – 13

Гүйцэтгэл 100%

4. Таксины чиглэлийн тээврийн хэрэгслийн техникийн үзлэгт нийт 290 тээврийн хэрэгсэл хамрагдахаас:

Хамрагдсан – 242

Хамрагдаагүй – 478

Тэнцсэн – 219

Тэнцээгүй – 23

Давтан үзлэгт тэнцсэн – 23

Гүйцэтгэл 83,5%

5. Буухиа чиглэлийн тээврийн хэрэгслийн техникийн үзлэгт нийт 34 тээврийн хэрэгсэл хамрагдахаас:

Хамрагдсан – 19

Хамрагдаагүй – 15

Тэнцсэн – 14

Тэнцээгүй – 5

Давтан үзлэгт тэнцсэн – 5

Гүйцэтгэл 57,5%

6. 2024 оны 09 дүгээр сарын 25-ний өдрөөс 11 дүгээр сарын 25-ний өдрийн байдлаар техникийн үзлэгт:

Хамрагдсан – 1016

Хамрагдаагүй – 48

Тэнцсэн – 853

Тэнцээгүй – 163

Давтан үзлэгт тэнцсэн – 163

Гүйцэтгэл 95,4%

Техникийн хяналтын үзлэгийн төвийн намрын техник хяналтын үзлэгт хуваарийн дагуу зөөврийн багаж, тоног төхөөрөмжөөр 2024 оны 10 дугаар сарын 18, 11 дүгээр сарын 01-ний өдрүүдэд “Зорчигч тээвэр хоёр” ОНӨААТҮГ-т 05 цаг 30 минутад очиж, зөөврийн багаж, тоног төхөөрөмжийн тусламжтайгаар техникийн хяналтыг хэрэгжүүлсэн.

Үзлэгт нийт 24 тээврийн хэрэгслээс хамрагдсанаас 8 тээврийн хэрэгсэл тэнцсэн.



Зураг №37. Техникийн хяналтын үзлэг хийгдэж буй байдал

Нийслэлийн төсвийн орлого төвлөрүүлэлт /мян.төг/ ₮

Хүснэгт 27

№	Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь
1	Техникийн хяналтын үзлэгийн орлого	179,904,900	58,729,400	33%

Нийслэлийн төсөвт төвлөрүүлэх орлогын биелэлт бүрэн хэрэгжээгүй шалтгаан:

Техникийн хяналтын үзлэгийн төвийн 2024 оны орлогын төлөвлөгөөнд 179,904,900 төгрөгийн орлого төвлөрүүлэхээр тусгасан бөгөөд гүйцэтгэл 58,729,400 төгрөг буюу 33%-ийн биелэлттэй байна. Орлого төвлөрүүлэхэд дараах шалтгаанууд нөлөөлж байна. Үүнд:

Монгол Улсын Засгийн газрын 2016 оны “Автотээврийн хэрэгслийг техник хяналтын үзлэгт оруулах давтамж, оношилгооны төлбөрийн хэмжээг шинэчлэн батлах тухай” 213 дугаар тогтоолд “Автотээврийн хэрэгслийг үйлдвэрлэсэн оноос хойших 2 жилд техникийн хяналтын үзлэгт оруулахгүйгээр зөвхөн автотээврийн хэрэгслийн тооллогод хамруулна” гэж заасан бөгөөд Нийтийн тээврийн парк шинэчлэлтийн хүрээнд 709 тээврийн хэрэгсэл үзлэгт хамрагдаагүй.

Автотээврийн тухай хуулийн 15.9.6-д “Автотээврийн хэрэгсэл нь үйлдвэрлэснээс хойш 10-аас дээш жил ашиглагдаагүй байх” гэсэн заалтаар нийт 109 нийтийн тээврийн хэрэгсэл хасагдсан. Нийслэлийн төр захиргааны тээврийн хэрэгслүүд бүрэн хамрагдаагүй.

Техникийн хяналтын үзлэгийн тоон мэдээлэл

Хүснэгт 28

2024 оны 11 дүгээр сарын 20-ний өдрийн байдлаар:												
№	Тээврийн хэрэгслийн төрөл	Бүртгэлийн сангийн тээврийн хэрэгслийн тоо	Оношилгоон Д орох тээврийн хэрэгслийн тоо	Өссөн дүнгээр нийт орсон						Давтан		
				Орсон	Хувь	Тэнцсэн	Хувь	Тэнцээгүй	Хувь	Орсон	Тэнцээгүй	Хувь
1	Үндсэн чиглэл (том, дунд)	1412	555	1231	221.8	1218	98.9	13	1	13	13	0
2	Буухиа чиглэл (бага)	34	34	28	82.4	28	100.0	0	0			0
3	Таксины чиглэл (суудлын)	290	290	406	140.0	393	96.8	13	0			
4	Ажилчдын автобус	219	219	305	139.3	302	99.0	3	0			0
5	Нийслэлийн төр, захиргааны тээврийн хэрэгсэл			104		101	97.1	0	0			0
6	Хүүхдийн автобус	191	196	310	158.2	310	100.0	0	0			0
Нийт дүн		2146	1294	2384	184.2	2352	98.7	32	0	13	13	0

Техникийн хяналтын үзлэгийн төлбөрийг Qray төлбөр тооцооны системээр төлөгдөх бэлтгэл ажлыг хангаж байна.



Зураг №38. Крау төлбөр тооцооны системээр төлөгдөх бэлтгэл ажлыг хангаж буй байдал

2.6. Нийтийн тээврийн үйлчилгээний байгууллагуудад ангилал тогтоох, бүртгэх үйл ажиллагааг нийслэлийн хэмжээнд зохион байгуулах; 4.1.3.1.

Зам, тээврийн хөгжлийн сайдын 2016 оны 31 дүгээр тушаалаар тус газарт Нийслэлийн нутаг дэвсгэрт авто үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудад ангилал тогтоох үйл ажиллагааг зохион байгуулах эрхийг олгосон.

Зам, тээврийн хөгжлийн сайдын 2022 оны А/112 дугаар тушаалаар шинэчлэн батлагдсан "Авто үйлчилгээний байгууллагад ангилал тогтоох журам", 2016 оны А/90 дүгээр тушаалаар батлагдсан "Тээврийн хэрэгслийн техникийн үйлчилгээ, засвар хийх журам"-уудыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Зам, тээврийн хөгжлийн сайдын 2016 оны 76 дугаар тушаалаар "Харьяалах нутаг дэвсгэрт хамтран хэрэгжүүлэх" 2022 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн 28 дугаартай гэрээний хэрэгжилтийг хангах 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөө 4 зорилтын хүрээнд 12 арга хэмжээ тусгагдан батлагдаж хэрэгжилтийг ханган ажилласан.

БАТЛАВ
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН САЙДНЫ
АВТОТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ТЕХНИКИЙН ҮЙЛЧИЛГЭЭ, ЗАСВАР ХИЙХ ЖУРАМ
1. ГАЗРЫН ДАГУУ
13. МОНХНАСАН

БАТЛАВ
НИЙСЛЭЛИЙН НИЙСЛЭЛИЙН ТЭЭВРИЙН
ГАЗРЫН ДАГУУ
Д.ОТГОНЖАРГАЛ

НИЙТИЙН ТЭЭВРИЙН ГАЗАРТАЙ АВТО ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧИГЛЭЛЭЭР
2024 ОНД ХАМТРАН АЖИЛЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

2024 оны 03 дугаар сарын 28

Д/д	Зорилт, арга хэмжээ	Төсөв сая.төг	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хугацаа	Хариуцах эзэн
Нэг. Зам, тээврийн сайдын 2016 оны 30 дүгээр тушаалаар баталсан "Авто үйлчилгээний байгууллагад ангилал тогтоох журам", "Тээврийн хэрэгслийн техникийн үйлчилгээ, засвар хийх журам"-уудыг хэрэгжүүлэн ажиллах ажлын хүрээнд:							
1.1	Нийслэлийн нутаг дэвсгэрт авто үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудад ангилал тогтоох.	-	Ангилал тогтоосон иргэн, аж ахуйн нэгж байгууллагын тоо	2023 онд 131 иргэн, аж ахуйн нэгж байгууллагын 314 ажил үйлчилгээнд ангилал тогтоон, гэрээ байгуулсан олгосон.	Эхний хагас жилд 40, сүүлийн хагас жилд 100, нийт 140 иргэн, аж ахуйн нэгж байгууллагад гэрээ байгуулж ангилал тогтоосон байна.	IV улирал	НТГ
1.2	Нийслэлийн нутаг дэвсгэрт авто үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудыг үнэлгээнд хамруулах.	-	Тохирлын үнэлгээнд хамрагдсан иргэн, аж ахуйн нэгж байгууллагын тоо	2023 онд автомашинны засвар эрхлэгч байгууллагын 173 үйлчилгээ тохирлын үнэлгээнд хамрагдсан.	Эхний хагас жилд 10, сүүлийн хагас жилд 30, нийт 40 байгууллагыг тохирлын үнэлгээнд хамруулсан байна.	IV улирал	НТГ
1.3	Нийслэлийн 9-н дүүргийн нутаг дэвсгэрт авто үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудын нэгдсэн	-	Судалгаанд хамрагдсан иргэн, аж ахуйн нэгж байгууллагын тоо	2023 онд Нийслэлийн 9-н дүүргийн нутаг дэвсгэрт авто үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй	2024 онд Нийслэлийн 9-н дүүргийн нутаг дэвсгэрт авто үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй иргэн, аж ахуйн нэгж байгууллагын тоог	II улирал	НТГ

Зураг №39. Зам, Тээврийн хөгжлийн сайдтай 2024 оны Авто үйлчилгээний чиглэлээр хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө

1. Авто үйлчилгээний байгууллагад ангилал тогтоох үйл ажиллагааг журмын дагуу зохион байгуулах ажлын хүрээнд:

Зам, Тээврийн сайдын 2022 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн А/112 тушаал "Авто үйлчилгээний байгууллагад ангилал тогтоох журам"-ын хэрэгжилтийг ханган онлайн бизнес төв, биетээр болон цахимаар хүсэлтийг хүлээн авч 2024 оны жилийн эцсийн байдлаар нийт 141 иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын 365 ажил үйлчилгээнд ангилал тогтоож, гэрээ байгуулан ажилласан.

Авто үйлчилгээ эрхлэгчдийн үйл ажиллагаанд ангилал тогтоолгосон тоон үзүүлэлт /дүүргээр/

Хүснэгт 29

№	Дүүрэг	Нийт	ААНБ	Иргэн
1	Баянгол	38	17	21



2	Баянзүрх	20	6	14
3	Хан-Уул	18	9	9
4	Сонгинохайрхан	32	8	24
5	Чингэлтэй	9	1	8
6	Налайх	1	0	1
7	Сүхбаатар	12	6	6
8	Багахангай	1	0	1
9	Багануур	10	1	9
	Нийт	141	48	93

Хүрсэн үр дүн: 2024 оны жилийн эцсийн байдлаар Нийслэлийн 9 дүүргийн хэмжээнд 141 иргэн, аж ахуйн нэгж байгууллага авто үйлчилгээ эрхлэх хүсэлт ирүүлж ангиллаа тогтоолгож гэрчилгээ авсан.

2. Авто үйлчилгээ эрхлэгчдийн үйл ажиллагаанд стандартын шаардлага хангуулах, ангилал тогтоох, авто засварын үйлчилгээнд тохирлын үнэлгээ, баталгаажуулалтыг хийлгэх.

Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 291 дүгээр тогтоолоор “Автомашинь оношилгоо болон засвар” тохирлын баталгаанд заавал хамруулах бүтээгдэхүүн, үйлчилгээний жагсаалтад орсон тул авто үйлчилгээ эрхлэгчид нь “Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай” хуулийн 23 дугаар зүйлийн 23.1.2 дахь заалт, MNS ISO/IEC17065:2013 стандартын шаардлагыг хангасан байгууллагаар тохирлын үнэлгээ баталгаажуулалт хийлгэж ангиллаа тогтоолгон үйл ажиллагаа явуулах гэж заалтыг хэрэгжүүлэн ажиллаж байна.


2024 оны жилийн эцсийн байдлаар Нийслэлийн нутаг дэвсгэрт автомашины засварын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй нийт 30 иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын 220 ажил үйлчилгээнд тохирлын үнэлгээ баталгаажуулалт хийлгэн, ангилал тогтоолгоод байна.

2024 онд тохирлын үнэлгээ хийлгэсэн авто үйлчилгээ эрхлэгчдийн судалгаа

Хүснэгт 30


№	Ажил үйлчилгээний төрөл	Нийт	ААНБ	Иргэн	Баянгол	Баянзүрх	Хан-Уул	Сонгинохайрхан	Чингэлтэй	Сүхбаатар	Багахангай	Багануур	Налайх
1	Агрегат зангилаа механизмын оношилгоо, засвар	32	15	17	7	5	3	6	5	4		1	1
2	Техникийн үйлчилгээ	34	17	17	7	5	3	7	5	4		2	1
3	Хөдөлгүүрийн оношилгоо, техникийн үйлчилгээ, засвар, тохиргоо, зүгшрүүлэлт	34	15	17	7	6	3	7	4	3		3	1
4	Түлшний систем засвар, тохиргоо, зүгшрүүлэлт	29	13	6	7	5	3	6	4	3			1
5	Ажилласан хий (утаа)-г зайлуулах систем, яндангийн дуу, чимээ намсгагч, ажилласан хийг гаргах систем (EGR), DFP, DOC, катализаторын хувиргагч гэх мэт оношилгоо, засвар, техникийн үйлчилгээ, тохиргоо, зүгшрүүлэлт	0	0	0	0	0	0	0	0	0			
6	Радиатор, хөргөлт, агааржуулалтын системийн оношилгоо, техникийн үйлчилгээ, засвар, тохиргоо, зүгшрүүлэлт	9	1	8	4	1	1	1	1	1			
7	Хурдны хайрцаг, хүч дамжуулах ангийн оношилгоо, техникийн үйлчилгээ, засвар	9	1	8	4	1	1	1	1	1			
8	Жолооны механизм, явах ангийн оношилгоо, техникийн үйлчилгээ, засвар, тохиргоо, зүгшрүүлэлт	9	1	8	4	1	1	1	1	1			
9	Их биеийн засвар	17	3	14	9	2	1	2	0	3			
10	Угаалга, цэвэрлэгээ үйлчилгээ	43	12	31	7	11	9	8	3	3			2
11	Цахилгаан систем, түүний тоноглол, хэрэгсэл болон цахилгаан хөдөлгүүрийн системийн оношилгоо, техникийн үйлчилгээ, засвар, тохиргоо, зүгшрүүлэлт	8	0	8	3	1	1	1	1	1			
12	Резин дугуй засвар, дугуйн баланс тохируулга, зүгшрүүлэлт	8	2	6	1	1	3	0	0	0	1	2	
13	Автомашинь шил засварлах, суурилуулах үйлчилгээ	3	0	3	1	2	0	0	0	0			
14	Автотээврийн хэрэгсэл	6	5	1	0	0	3	0	1	2			
15	Автотээврийн хэрэгслийн сэлбэг, хэрэгсэл	50	17	33	15	5	4	11	6	5		3	1
16	Тос, тосолгооны болон ашиглалтын бусад материал	36	13	23	10	4	4	10	4	3	0	0	1
17	Оёдол доторлогоо үйлчилгээ	4	3	1	3	0	1	0	0	0			
18	Тээврийн хэрэгслийн резин дугуй, обуд	8	7	1	4	1	3	0	0	0			
19	Авто зогсоол	0	0	0	0	0	0	0	0	0			
20	Тээврийн хэрэгслийн агрегат зангилаа, эд анги, сэлбэг, хэрэгсэл хадгалах	0	0	0	0	0	0	0	0	0			
	Нийт	339	125	181	93	51	44	61	36	34	1	3	6

2024 оны жилийн эцсийн байдлаар авто үйлчилгээ эрхлэгчдийн нэгдсэн мэдээллийн санд тус онд ангилал тогтоолгосон 141 иргэн, аж ахуйн нэгж байгууллагын оноосон нэр, үйлчилгээний төрөл, хаяг байршлын мэдээллийг www.transport.ub.gov.mn веб сайтад байршуулсан.



Зураг №40. Авто үйлчилгээний мэдээллийн сан

Нийслэлийн Засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн А/987 дугаар “Бизнес эрхлэх таатай орчныг бүрдүүлж, авлига, хүнд суртлыг бууруулах талаар авах зарим арга хэмжээний тухай” захирамж батлагдаж захирамжийн биелэлтийг 14 хоног тутамд Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлэн ажилласан. “Онлайн бизнес төв”-өөр 2024 оны жилийн эцсийн байдлаар 23 иргэн, аж ахуйн нэгж байгууллагын хүсэлтийг хүлээн авч, биет болон цахимаар шийдвэрлэсэн 23, хугацаатай үүрэг даалгавар өгсөн байхгүй, утас холбогдохгүй /аваагүй/ 19, зөвлөн туслах үйлчилгээг 38 иргэн, аж ахуйн нэгж байгууллагад үзүүлсэн болно.



Зураг №41. Нийслэлийн дундын мэдээллийн сан www.autobox.mn

Арга хэмжээ №3.6 Авто үйлчилгээ эрхлэгчдийн үйл ажиллагаанд стандарт, дүрэм, журмыг мөрдүүлэх зорилгоор зөвлөн туслах үйлчилгээг зохион байгуулалтын арга хэмжээг авах, Нийслэлийн алслагдсан дүүргүүдийн авто үйлчилгээний байгууллагуудад ангилал тогтоох ажлыг эрчимжүүлэх;

Нийслэлийн алслагдсан Багануур дүүргийн Засаг даргын тамгын газартай хамтран тус дүүргүүдийн Авто үйлчилгээ эрхлэгчдийн удирдлагуудад холбогдох зөвлөн туслах зөвлөгөөн зохион байгуулах 2024 оны 08 дугаар сарын 01-ний өдөр “Авто үйлчилгээ эрхлэгч иргэд аж ахуйн нэгж байгууллагуудын удирдлагуудад холбогдох эрх зүйн мэдлэг олгох, зөвлөн туслах сургалтыг зохион байгуулж 26 иргэн, аж ахуйн нэгж байгууллага хамрагдсан.



Зураг №432. Нийслэлийн Багануур дүүргийн авто үйлчилгээ эрхлэгчдэд сургалт зохион байгуулсан

“Баянгол дүүргийн нутаг дэвсгэрт авто үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй иргэн, аж ахуй нэгжид зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх, хяналт шалгалт хийх ажлын удирдамж” 2024 оны 06 дугаар сарын 03-ны дүүргийн Засаг даргын тамгын газрын Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтэстэй хамтран авто үйлчилгээ эрхэлж буй 25 иргэн, аж ахуйн нэгж байгууллагууд хамрагдсан.



Зураг №43. Баянгол дүүргийн Авто үйлчилгээ эрхлэгчдэд зөвлөн туслах үйлчилгээний удирдамжийн хүрээнд дүүргийн хороодын хэсгийн ахлагч нар т зөвлөгөө өгсөн.

Сургалтад хамрагдсан хороодын хэсгийн ахлагч нар болон авто үйлчилгээ эрхэлж буй 51 иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудад “Авто үйлчилгээ эрхлэгч иргэн, аж ахуйн нэгжид зориулсан хууль, эрх зүйн эмхэтгэл” болон гарын авлага тарааж авто үйлчилгээ эрхлэгчд зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэн ажиллаа.



Зураг №44. Авто үйлчилгээ эрхлэгчдэд зориулсан эрх зүйн эмхэтгэл, гарын авлага

Хүрсэн үр дүн: Авто үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудад холбогдох хууль эрх зүйн сургалтыг Нийслэлийн Баянзүрх, Сүхбаатар, Баянгол, Чингэлтэй, Багануур дүүргийн нутаг дэвсгэрт авто үйлчилгээ эрхэлдэг 176 иргэн аж ахуйн нэгж байгууллагуудад хяналт шалгалт зохион байгуулж давхардсан тоогоор 280 иргэн, аж ахуй нэгж байгууллагуудад сургалт зохион байгуулж авто үйлчилгээ эрхлэгчдэд зориулсан хууль эрх зүйн эмхэтгэл, гарын авлага тараан мэдээллээ ханган зөвлөмж өгч ажилласан.

Нийслэлийн 9 дүүргийн нутаг дэвсгэрт авто үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудыг нэгдсэн судалгааг гаргах.



Мэргэжлийн байгууллагуудын уялдаа холбоог сайжруулж, авто үйлчилгээ эрхлэгчдийн нэгдсэн бүртгэлтэй болох зорилгоор 9 дүүргийн Засаг даргын Тамгын газарт дүүргийн нутаг дэвсгэрт авто үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудын судалгааг 2024 оны байдлаар шинэчлэн ирүүлэх талаар 2024 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн 01/4/654 дугаар албан бичгийг хүргүүлж мэдээллийг нэгтгэн мэдээллийн санг баяжуулан ажилласан.

2.7.Нийтийн тээврийн салбарт мөрдөж байгаа хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, дүрэм, журмын биелэлт, стандартын хэрэгжилтийг хангуулах зорилгоор автотээврийн улсын хяналт хэрэгжүүлэх; 4.1.4.1.

2.7.1.Авто үйлчилгээний байгууллагад ангилал тогтоох үйл ажиллагааг журмын дагуу хяналт шалгалт хийж, хамтарсан шалгалтыг тогтмол хийж, шаардлагатай арга хэмжээ авч хэрэгжүүлэх.

Нийтийн тээврийн бодлогын газрын даргын баталсан “Нийслэлийн нутаг дэвсгэрт авто угаалгын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудад зөвлөн туслах, үзлэг шалгалтын ажлын удирдамж”-ийн хүрээнд нийслэлийн төвийн дүүргүүдийн нутаг дэвсгэрт авто засвар, авто угаалга ажиллуулж байгаа иргэд, аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд Авто үйлчилгээнд тавих Ерөнхий шаардлага MNS 5025:2020 улсын стандарт, Авто засварын үйлчилгээ эрхлэгч нь ангиллын гэрчилгээ авсан эсэх, ажлын байрны стандарт шаардлага хангаж байгаа, техникийн аюулгүй ажиллагаа ариун цэвэр, эрүүл ахуй, хөдөлмөр хамгааллын заавар журам мөрдөж байгаа эсэхэд автотээврийн хяналтын улсын байцаагч нар батлагдсан хуваарийн дагуу хяналт шалгалтыг хийж ажилласан.

Баянзүрх дүүрэгт: Тус дүүргийн Засаг даргын Тамгын газрын Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтсийн мэргэжилтэн А.Ууганбаатар, Ус сувгийн удирдах газрын Хяналтын инженер Д.Эрдэнэчимэг, Нийтийн тээврийн газрын Автотээврийн хяналтын улсын Б.Одгэрэл, Ачаа тээвэр, логистикийн хэлтсийн Авто үйлчилгээ хариуцсан ажилтан Д.Ганбат нарын хамт 2024 оны 04 дугаар сарын 22-ны өдрөөс 26-ны өдрүүдэд.

Баянгол дүүрэгт: Байгаль орчны газрын байгаль орчны хяналтын улсын байцаагч Б.Бадамсүрэн, Дүүргийн хөдөлмөр халамжийн хэлтсийн хөдөлмөрийн хяналтын мэргэжилтэн, Улсын ахлах байцаагч Б.Нарантуяа, Хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтын улсын байцаагч, Онцгой байдлын хэлтсийн байцаагч, ахлах дэслэгч Э.Пүрэвсүрэн, , Засаг даргын тамгын газрын Хүнс худалдаа үйлчилгээний хэлтсийн Авто засвар үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн Ц.Мягмардорж, Тохижилт нийтийн аж ахуйн хэлтсийн мэргэжилтэн Ш.Батзориг, Цагдаагийн 2 дугаар хэлтсийн алба хаагч, дэслэгч Б.Сүхбат нарын бүрэлдэхүүнтэй хэсэг 2024 оны 03 дугаар сарын 05-ны өдрөөс 03 дугаар сарын 15-ны өдрүүдэд.

Жилийн хоёр дугаар хагаст Баянгол дүүргийн нутаг дэвсгэрт авто үйлчилгээ эрхэлж буй иргэн, аж ахуйн нэгжүүдэд хамтарсан хяналт шалгалт хийх тухай удирдамжийн дагуу 2024 оны 09 дүгээр сарын 16-аас 10 дугаар сарын 31-ний өдрүүдэд Баянгол дүүргийн 7, 8, 10, 13, 19, 22, 31, 32-р хорооны нутаг дэвсгэрт авто үйлчилгээ эрхлэгч иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудад Нийслэлийн нийтийн тээврийн бодлогын газрын Автотээврийн хяналтын улсын байцаагч Г.Базарсад, Авто үйлчилгээ хариуцсан ажилтан Б.Ариунтунгалаг, Э.Энхням, Нийслэлийн Баянгол дүүргийн Байгаль орчны хэлтсийн Байгаль орчны хяналтын улсын байцаагч Б.Чимэдцэеэ, Нийслэлийн Хяналт шалгалтын газрын Авто тээврийн хяналтын улсын ахлах байцаагч Ц.Хадбаатар, Автотээврийн хяналтын улсын байцаагч У.Энхтөр, Гадаадын иргэн харьяатын газраас байцаагч Б.Батгэрэл, БГД-ийн Засаг даргын тамгын газрын Хүнс, Худалдаа үйлчилгээний хэлтсийн Авто худалдаа, үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн Ц.Мягмардорж, Татварын хэлтсийн байцаагч Д.Долгион, Г.Мөнхцэцэг, Б.Мөнхчулуун Онцгой байдлын хэлтсийн байцаагч Б.Хүрэлтогоо, Баянгол дүүргийн цагдаагийн 2-р хэлтсийн ахлах дэслэгч О.Тэнгис нартай хамтран хяналт шалгалтыг хийж гүйцэтгэлээ

Сүхбаатар дүүрэгт: Тус дүүргийн Авто засвар үйлчилгээ хариуцсан мэргэжилтэнтэй Ц.Ууганцэцэг, тус газрын Авто үйлчилгээ хариуцсан ажилтан Д.Ганбат нарын хамт 2024 оны 04 дүгээр сарын 03-ны өдрөөс 04 дүгээр сарын 06-ны өдрүүдэд ажилласан.

Хан-Уул дүүрэгт: Тус газры даргын 2024 оны 11 дүгээр сарын 04-ний өдөр баталсан “Нийслэлийн Хан-Уул дүүргийн нутаг дэвсгэрт авто үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудад зөвлөн туслах, үзлэг шалгалт зохион байгуулах ажлын удирдамж”, Хан-Уул дүүргийн Засаг даргын 2024 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн “Авто үйлчилгээ эрхэлж буй иргэн, аж ахуйн нэгжүүдэд хамтарсан хяналт, шалгалт хийх тухай” А/671 дүгээр захирамжийн хүрээнд Хан-Уул дүүргийн нутаг дэвсгэрт авто засвар,



авто угаалга ажиллуулж байгаа иргэн, аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанд Авто үйлчилгээнд тавих Ерөнхий шаардлага MNS 5025:2020 улсын стандарт, Авто засвар, угаалгын үйлчилгээ эрхлэгч нь ангиллын гэрчилгээ авсан эсэх, ажлын байрны стандарт шаардлага хангаж байгаа, техникийн аюулгүй ажиллагаа ариун цэвэр, эрүүл ахуй, хөдөлмөр хамгааллын заавар журам мөрдөж байгаа эсэхэд 11 дүгээр сарын 04-ний өдрөөс 11 дүгээр сарын 25-ны өдрүүдэд автотээврийн хяналтын улсын байцаагч нар батлагдсан хуваарийн дагуу тус дүүргийн Засаг даргын Тамгын газрын Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтсийн мэргэжилтэн И.Хулан, Ус сувгийн удирдах газрын Хяналтын инженер Т.Билгүүн, Нийтийн тээврийн бодлогын газрын Автотээврийн хяналтын улсын байцаагч Ж.Бум-Эрдэнэ, Ачаа тээвэр, логистикийн хэлтсийн Авто үйлчилгээ хариуцсан ажилтан Э.Энхням, Газар зохион байгуулалтын албаны мэргэжилтэн Т.Буянбат, Ц.Уянга, Байгаль орчны газрын улсын байцаагч Ц.Дагиймаа, Хөдөлмөр халамж үйлчилгээний хэлтсийн улсын байцаагч Д.Байгалмаа, БТТХТасгийн дарга Э.Насанбат, ХУД-ийн цагдаагийн газрын хэлтэс 1-р хэсгийн цагдаагийн ахлах ахлагч Э.Одончимэг, 2-р, хэсгийн байцаагч дэслэгч Б.Отгонтөгс, М.Мөнх-Эрдэнэ, ХУД-ийн Онцгой байдлын хэлтсийн улсын байцаагч М.Жамцдорж нарын хамт авто засварын үйлчилгээ эрхлэгч иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад шалгалт хийж гүйцэтгэлээ.

Шалгалтад: авто угаалгын үйл ажиллагаа эрхэлж байгаа нийт 327 иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг хамруулж Зам, тээврийн хөгжлийн сайдын 2022 оны А/112 дугаар тушаалаар батлагдсан “Авто үйлчилгээний байгууллагад ангилал тогтоох журам”, “Тээврийн хэрэгслийн техникийн үйлчилгээ, засвар хийх журам”, “Авто үйлчилгээнд тавих. Ерөнхий шаардлага” MNS 5025:2020, “Авто машины угаалгын үйлчилгээ. Ангилал, Ерөнхий шаардлага” MNS 5347:2003 улсын стандартуудын хэрэгжилтийг хангаж байгаа эсэхэд хяналт шалгалт хийв.

Шалгалтын хүрээнд үйл ажиллагаа эрхлэгч авто үйлчилгээний газруудад Авто үйлчилгээнд тавигдах Ерөнхий шаардлага MNS5025:2020 стандартын хэрэгжилт, Тохирлын гэрчилгээ болон ангиллын гэрчилгээ авсан эсэхэд хяналт хийж, авто үйлчилгээний ангиллын гэрчилгээ сунгах болон шинээр авч буй 28 иргэн, аж ахуйн нэгж байгууллагад шинжээчийн дүгнэлт гаргаж, шинээр үйл ажиллагаа эхэлж буй авто үйлчилгээ эрхлэгчдэд зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж, ангиллын гэрчилгээ аваагүй, стандартын шаардлага хангаж ажиллаагүй 46 зөрчилд Зөрчлийн тухай хуулийн 14.6 дугаар зүйлийн 13 дэх хэсэгт зааснаар 39 иргэнийг 1,925,000 төгрөгөөр, 7 аж ахуйн нэгж байгууллагыг 3,500,000 төгрөгөөр торгох арга хэмжээ тооцож ажиллаа.

2.7.2. Аюултай ачаа тээвэрлэлтийн үйл ажиллагаанд хяналт тавина.

Автотээврийн хяналтын 11 улсын байцаагч Нийслэлийн нутаг дэвсгэрт аюултай ачаа тээвэрлэгч, тээвэрлүүлэгч иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудад Автотээврийн тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Химийн хортой болон аюултай бодисын тухай хууль түүнд нийцүүлэн гаргасан дүрэм, журмын хэрэгжилт, Зам, тээврийн хөгжлийн яамтай хамтарсан “Автотээврийн хяналтыг хамтран хэрэгжүүлэх гэрээ”-ний үүргийн биелэлтийн хүрээнд “Автотээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих ерөнхий шаардлага” MNS 4598:2020, “Аюултай ачаа. Ангилал. Тээвэрлэлтэд тавих ерөнхий шаардлага” MNS 4978:2017, “Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Химийн хорт болон аюултай бодисын шошго, анхааруулах тэмдэг” MNS 5029:2011 улсын стандартын үзүүлэлт шаардлагыг хангуулан, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх чиглэлээр шугам замд 81 тээврийн хэрэгсэлд хяналт шалгалтыг хийж ажилласан.

Шалгалтаар илэрсэн зөрчилд Зөрчлийн тухай хуулийн дагуу 4 аж ахуйн нэгж, байгууллагад 1.000.000 төгрөгийн, 18 иргэнд 450.000 төгрөгийн, нийт 22 зөрчилд 1.450.000 төгрөгийн торгох шийтгэл ногдуулж ажилласан байна.

2.7.3. Нийслэлийн нутаг дэвсгэрт нийтийн тээврийн үйлчилгээнд хяналт тавина.

2024 онд “Зөрчлийн тухай хууль”, “Төрийн хяналт шалгалтын тухай”, “Автотээврийн тухай” хуулиуд болон түүнд нийцүүлэн гаргасан дүрэм журам, “Нийтийн зорчигч тээврийн үйлчилгээ, Ангилал ба түүнд тавигдах шаардлага” MNS 5012:2021, “Автотээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих ерөнхий шаардлага” MNS 4598:2020, “Таксийн үйлчилгээ. Ерөнхий шаардлага” MNS 5122:2013, холбогдох бусад стандартын хэрэгжилтийг хангуулах зорилгоор мөн тус газрын даргын баталсан тушаал шийдвэр хэрхэн биелэгдэж байгаад хяналт тавьж ажилласан.

Хяналт шалгалтаар илэрсэн зөрчилд Зөрчлийн тухай хуулийн дагуу 40 аж ахуйн нэгж, байгууллагад 12.850.000 төгрөгийн, 475 иргэнд 16.610.000 төгрөгийн, нийт 515 зөрчилд 29.460.000 төгрөгийн торгох шийтгэл ногдуулж, Автотээврийн хяналтын улсын байцаагчийн



зөрчил арилгуулах тухай 60 заалт бүхий 28 албан шаардлагыг хүргүүлж, гүйцэтгэлийн шалгалт хийж, шаардлага биелүүлээгүй 4 аж ахуйн нэгж байгууллагад Зөрчлийн тухай хуулийн 15.1 дүгээр зүйлийн 1 дэх заалтаар тус бүр 500 нэгжээр торгож ажилласан байна.

2.7.4. Нийтийн тээврийн салбарт мөрдөж байгаа хууль тогтоомж, дүрэм, журмын биелэлт, стандартын хэрэгжилтийг хангуулах зорилгоор Автотээврийн улсын хяналт хэрэгжүүлнэ.

Нийслэлийн нийтийн тээврийн газрын даргын 2024 оны 01 дүгээр сарын 09-ний өдөр баталсан “Нийтийн зорчигч тээврийн үйлчилгээний хөлс төлөлтийн байдалд хяналт тавих шалгалтын ажлын удирдамж”-ийн дагуу Автотээврийн хяналтын улсын байцаагч болон шалгагч нар хамтран 2024 оны 01 дүгээр сарын 10-наас 11 дүгээр сарын 20-ны өдрүүдэд хяналт шалгалтын ажлыг зохион байгууллаа.

2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс өссөн дүн, давхардсан тоогоор нийт 5516 чиглэлийн их болон дунд багтаамжийн 58586 тээврийн хэрэгсэл, 117442 зорчигчдыг шалгаж, бэлэн мөнгөөр зорчсон, U money картын үлдэгдэл хүрэлцээгүй, зорчих картгүй, зорчих хөлс төлөөгүй зэрэг нийт 331604 зөрчил илрүүлж, 117237 зорчигчийг нийтийн тээврийн хэрэгслээр тээвэрлэхээс татгалзан, зорчуулахгүй буулгаж, 205222 зорчигчийн картанд Easy pay /изи пей/ посын цэнэглэлтээр 1,804,157,200 мянган төгрөгийн цэнэглэлт хийлгэж зөрчлийг газар дээр нь арилгуулсан байна. Мөн Автотээврийн хяналтын улсын байцаагч нар 45 зорчигчийн зөрчлийг илрүүлж, 450.000 төгрөгийн шийтгэл ногдуулсан байна.

Тус газрын захиргаа удирдлагын хэлтсийн даргын удирдамжийн дагуу хяналт шалгалтын хэлтсийн ахлах шалгагч болон шалгагч нар 2024 оны 08 дугаар сарын 30-наас 09 дүгээр сарын 27-ны өдрийг дуусталх 1 сарын хугацаанд Энхтайвны өргөн чөлөөнд байрлах чиглэлийн тээврийн хэрэгслийн зогсоолууд дээр хуваарийн дагуу шалгалтыг зохион байгуулж ажиллалаа.



Ахлах шалгагч, шалгагч нар тухайн чиглэлийн тээврийн хэрэгслийн зогсоолууд дээр удаан зогсож зөрчил гаргасан автомашины фото зургийг баримтжуулан “E POLICE” аппликейшн руу илгээж ажилласан бөгөөд ажлын үзүүлэлтийг нь эрэмбэлэхэд:

1. Шалгагч Б.Туяа 217 зөрчлөөс үүнээс 187,
2. Шалгагч Л.Наранцоо 191 зөрчлөөс 184,
3. Шалгагч Б.Энхжаргал 201 зөрчлөөс 172 ,
4. Шалгагч О.Нямхүү 158 зөрчлөөс 153,
5. Шалгагч Г.Ганчимэг 156 зөрчлөөс 142,
6. Шалгагч Б.Зандмаа 149 зөрчлөөс 141,
7. Шалгагч Ба. Баярмаа 125 зөрчлөөс 119,
8. Шалгагч П. Түвшингэрэл 121 зөрчлөөс 116,
9. Шалгагч Л.Одончимэг 121 зөрчлөөс 113,
10. Шалгагч Т.Түмэнжаргал 118 зөрчлөөс 112,
11. Шалгагч Л.Буяндэлгэр 111 зөрчлөөс 105,
12. Шалгагч Б.Булгантамир 112 зөрчлөөс 103 буюу

нийт 1780 зөрчлийг тус тус E police апп руу илгээснээс, 1647 зөрчилд хариуцлага тооцуулж бусдыгаа тэргүүлж ажилласан байна.

Шалгагч нарыг үзүүлэлт

График 11



2.7.5. Нийтийн тээврийн хэрэгсэл, сургуулийн болон ажилчдын автобус, нийслэлийн төр, захиргааны автотээврийн хэрэгсэлд техникийн хяналтын үзлэг хийх ажилд хяналт шалгалт хийнэ.

Нийтийн тээврийн бодлогын газрын Техникийн хяналтын үзлэгийн төвд ажиллах хуваарийн дагуу автотээврийн хяналтын улсын байцаагч нар оношлогч инженерүүдийн хамт хяналтын үзлэг шалгалтыг хийж ажиллаа.

Техникийн хяналтын үзлэгт ороогүй 10 авто машиныг замын хөдөлгөөнд оролцуулж явсан зөрчлийг шугам замын шалгалтаар илрүүлж, Зөрчлийн тухай хуулийн 14.6 дугаар зүйлийн 5-д заасны дагуу 6 аж ахуйн нэгж байгууллагыг 1.200.000 төгрөг, 11 иргэнд 2.250.000 төгрөг, нийт 3,450,000 төгрөгөөр торгох шийтгэл оногдуулж, техникийн хяналтын үзлэгт хамруулсан.

2.7.6. Аюултай болон тусгай ачаа тээврийн зохицуулалтад хяналт тавина.

Автотээврийн хяналтын 11 улсын байцаагч Нийслэлийн нутаг дэвсгэрт аюултай ачаа тээвэрлэгч, тээвэрлүүлэгч иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудад Автотээврийн тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Химийн хортой болон аюултай бодисын тухай хууль түүнд нийцүүлэн гаргасан дүрэм, журмын хэрэгжилт, Зам, тээврийн хөгжлийн яамтай хамтарсан “Автотээврийн хяналтыг хамтран хэрэгжүүлэх гэрээ”-ний үүргийн биелэлтийн хүрээнд “Автотээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих ерөнхий шаардлага” MNS 4598:2020, “Аюултай ачаа. Ангилал. Тээвэрлэлтэд тавих ерөнхий шаардлага” MNS 4978:2017, “Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Химийн хорт болон аюултай бодисын шошго, анхааруулах тэмдэг” MNS 5029:2011 улсын стандартын үзүүлэлт шаардлагыг хангуулан, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх чиглэлээр шугам замд 53 тээврийн хэрэгсэлд хяналт шалгалтыг хийж ажилласан.

Шалгалтаар илэрсэн зөрчилд Зөрчлийн тухай хуулийн 14.6 дугаар зүйлийн 9-д заасны дагуу 4 аж ахуйн нэгж, байгууллагад 1.000.000 төгрөгийн, 3 иргэнд 75.000 төгрөгийн, нийт 7 зөрчилд 1.075.000 төгрөгийн торгох шийтгэл ногдуулсан.

2.7.8. Нийслэлийн нутаг дэвсгэрт ачаа тээвэрлэлтийн үйл ажиллагаа эрхэлж буй тээврийн хэрэгслийн өдөр тутмын үйл ажиллагаанд хяналт тавина.

Тээврийн цагдаагийн алба, Нийслэлийн авто замын хөгжлийн газар, Нийтийн тээврийн бодлогын газрын хамтарсан “Нийслэлийн гудамж, замын хөдөлгөөнд оролцож байгаа ачааны автомашины ачаа тээвэрлэлт, зам, замын байгууламжийн ашиглалт, автотээврийн хэрэгслийн стандарт үзүүлэлт, шаардлагад хяналт тавих шалгалтыг 2024 онд Замын цагдаагийн алба хаагчдыг хамруулан нийслэлийн 6 дүүргийн нутаг дэвсгэрт хамтарсан шалгалтыг зохион байгуулсан.

Дүүргүүдийн нутаг дэвсгэрийн авто замаар зорчих ачааны автомашинуудад “Автотээврийн хэрэгслийн техникийн байдалд хяналт тавих. “MNS 4598:2020 стандартад зааснаар хоёр голтой тээврийн хэрэгсэлд 18 тонн, гурван голтой тээврийн хэрэгсэлд 25 тонн, дөрвөн голтой тээврийн хэрэгсэлд 38 тонн, таван голтой тээврийн хэрэгсэлд 40 тонн, зургаан голтой тээврийн хэрэгсэлд 44 тонноос тус тус хэтрээгүй байх” мөн замын хөдөлгөөний дүрмийн 3-р хавсралтаар хөдөлгөөнд оролцож буй тээврийн хэрэгслийн Монгол Улсын нутаг



дэвсгэрт мөрдөгдөж байгаа тээврийн хэрэгслийн техникийн байдалд тавигдах үндсэн шаардлагуудыг хангасан байхаас гадна зам талбай бохирдуулахгүй байх /ачиж яваа ачаа нь унахгүй, асгарахгүй, гоожихгүй, хийсэхгүй байх /талаар Нийслэлийн Засаг даргын 2008 оны А/191 дүгээр захирамжийн хэрэгжилтэд автотээврийн хяналтын улсын байцаагч нар хяналт тавьж ажилласан.

Хяналт, шалгалтаар 480 тээврийн хэрэгсэл шалгаснаас 126 иргэн, аж ахуйн нэгж байгууллагад Зөрчлийн тухай хуулийн 14.6 дугаар зүйлийн 9-д заасны дагуу 20.870.000 төгрөгийн шийтгэл ногдуулсан

2.7.9.Нийтийн тээврийн үйлчилгээний хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор автобус, таксийн зогсоол, чиглэлийн тээврийн хэрэгслийн эгнээ байранд саад учруулж буй тээврийн хэрэгслийг чөлөөлөх, хариуцлага тооцно.

Энхтайваны өргөн чөлөөний дагуу нийтийн тээврийн үйлчилгээнд хяналт тавих шалгалтын хүрээнд Чиглэлийн тээврийн хэрэгслийн эгнээг чөлөөлөх, автобусны зогсоолд зорчигчдын буух, суух нөхцөлийг хангуулах, түр болон удаан хугацаагаар зогссон суудлын автомашины зөрчлийг арилгуулахаар хөдөлгөөнт болон суурин 36 байршилд Автотээврийн хяналтын улсын байцаагч, шалгагч нар нийтийн тээврийн үйлчилгээнд хяналт шалгалт хийж ажилласан.

2024 оны байдлаар Энхтайваны өргөн чөлөөний “Чиглэлийн тээврийн хэрэгслийн нэгдүгээр эгнээ”-нд ажиллахдаа автобусны буудлын “Зогсоолын талбай”-д хориглосон цагаар зогссон 13,582 автомашины зөрчлийг фото зургаар баримтжуулан “E-Police application”-ээр Замын хөдөлгөөний удирдлагын төв рүү шилжүүлж, 8,811 зөрчил баталгаажиж, тээврийн хэрэгслийн эзэмшигчийн гэрийн хаягаар илгээн, нийт 176,220,000 төгрөгийн торгууль оногдуулсан.

2.7.10.Нийтийн тээврийн үйлчилгээний чанар, соёлыг сайжруулах ажлыг тасралтгүй зохион байгуулах ажлын хүрээнд сургалт зохион байгуулна.

Нийслэлийн Нийтийн тээврийн бодлогын газрын дарга Д.Отгонжаргалын баталсан “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийтийн тээврээр үйлчлүүлэх хүртээмжийг нэмэгдүүлэх зорилготой, Нийтийн тээврээр зорчиж буй хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд тусламж үйлчилгээ үзүүлэх арга техник онол, дадлага хосолсон сургалтын удирдамж”-ийн дагуу 2024 оны 10 дугаар сарын 15-ны өдөр нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч 21 төрийн өмчит болон, аж ахуйн нэгж байгууллагуудын ашиглалтын албаны дарга, инженер техникийн нийт 71 албан хаагчдыг хамруулан сургалт зохион байгуулсан.

Сургалтыг Нийтийн тээврийн бодлогын газар, Монголын тэргэнцэртэй иргэдийн үндэсний холбоо, Монголын хараагүйчүүдийн үндэсний холбоо нар хамтран зохион байгуулж, Нийтийн тээврээр үйлчлүүлж байгаа хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд тусламж үйлчилгээ үзүүлэх, нийтийн тээврээр үйлчлүүлэхэд жолоочоос хамаарсан аливаа саад тотгорыг арилгах, жолооч болон албан хаагч нар эдгээр иргэдэд үйлчилгээ үзүүлэх арга техникийг зааж, таниулах зорилгоор арга техникийн талаар мэдлэг, мэдээлэл, дадлага эзэмшүүлэх сургалт хийж ажиллаа.

Нийтийн тээврийн бодлогын газрын дарга Д.Отгонжаргал, “Зорчигч тээвэр тав” ОНӨААТҮГ-ын захирал С.Батзаяа нарын хамтран баталсан удирдамжийн дагуу нийтийн тээврийн үйлчилгээнд ажиллаж байгаа шалгагч нарыг чадавхжуулах “Нийтийн тээврийн салбарын өнөөгийн байдал, нийтийн тээврийн үйлчилгээнд шалгагч нарын оролцоо” сургалтыг 2024 оны 11 дүгээр сарын 01-ний өдөр “Зорчигч тээвэр тав” ОНӨААТҮГ-ын сургалтын танхимд зохион байгуулав.

Сургалтыг Нийтийн тээврийн бодлогын газрын Хяналт шалгалтын хэлтэс, Зорчигч тээврийн хэлтэс, “Зорчигч тээвэр тав” ОНӨААТҮГ-ын албан хаагчид хамтран зохион байгуулав.

Сургалтад 6 аж ахуйн нэгж байгууллагын 73 шалгагч хамрагдав.

Сургалтын эхний хэсэгт Хяналт шалгалтын хэлтсийн Орлого төвлөрүүлэлт хариуцсан ахлах менежер У.Даваажав 2024 онд Шалгагч гарын хийж гүйцэтгэсэн ажлын талаарх “Танилцуулга мэдээлэл” өгсөн бол Салбарын сургалт, хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагаа хариуцсан мэргэжилтэн Ч.Бадамханд “Нийтийн тээврийн салбарын өнөөгийн байдал, хүртээмжтэй байдлыг дээшлүүлсэн нь” сэдвээр, Автотээврийн хяналтын улсын байцаагч Б. Мягмардорж “Нийтийн тээврийн салбарын эрх зүйн актууд”, “ICT групп” ХХК-ний



төслийн менежер н. Чулуунбат нийтийн тээврийн салбарт шинэ техник, технологийн талаар мэдээлэл өгсөн.

Сургалтын хоёрдугаар хэсэгт сайхныг хуваалцагч лектор Д.Шинэбаяр “Зүрх сэтгэл ба зөв харилцаа хандлага” сэдэвт лекц уншиж, үйлчилгээний ажилтны соёл, үйлчлүүлэгчтэй харилцах хандлагын талаар мэдлэг олгосон

Сургалтын үр дүн: Сургалтыг зохион байгуулснаар Нийслэлийн нийтийн тээврийн салбарт ажиллаж буй шалгагч нар нийтийн тээврийн үйлчилгээнд шинээр нэвтэрч байгаа техник, технологи болон үйлчилгээний ажилтны зан харилцаа, сэтгэл зүйн онцлогийн талаарх мэдлэг, мэдээлэлтэй болж цаашид шалгагч нарын ажлын бүтээмж нэмэгдэж улмаар үйлчилгээний соёлтой харилцааг бий болгож хэрхэн стресс менежменийг хэрэгжүүлэх гэх мэт мэдлэг, мэдээлэлтэй болсон.

Нийслэл Улаанбаатар хотын Авто замын түгжрэлийг бууруулах үндэсний хороо, Тээврийн Цагдаагийн алба, Нийслэлийн Нийтийн тээврийн үйлчилгээний газрууд хамтран 2024 оны 04 дүгээр сарын 17-ны өдөр баталсан удирдамжийн дагуу 2024 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс 05 дугаар сарын 27-ны өдрийг дуустал хугацаанд хуваарийн дагуу нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч 18 аж ахуйн нэгж, байгууллагын инженер техникийн 45 ажилтан, 1315 жолооч, нийтийн тээврийн таксийн үйлчилгээ эрхлэгч 4 аж ахуйн нэгжийн 36 жолооч, 5 шалгах механик нийт 1401 хүнийг хамруулан 24 удаагийн сургалтыг зохион байгуулав.

Нийслэлийн Нийтийн тээврийн бодлогын газрын дарга Д.Отгонжаргалын баталсан “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийтийн тээврээр үйлчлүүлэх хүртээмжийг нэмэгдүүлэх зорилготой, Нийтийн тээврээр зорчиж буй хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд тусламж үйлчилгээ үзүүлэх арга техник онол, дадлага хосолсон сургалтын удирдамж”-ийн дагуу 2024 оны 10 дугаар сарын 15-ны өдөр нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч 21 төрийн өмчит болон, аж ахуйн нэгж байгууллагуудын ашиглалтын албаны дарга, инженер техникийн нийт 71 албан хаагчдыг хамруулан сургалт зохион байгуулсан.

Сургалтыг Нийтийн тээврийн бодлогын газар, Монголын тэргэнцэртэй иргэдийн үндэсний холбоо, Монголын хараагүйчүүдийн үндэсний холбоо нар хамтран зохион байгуулж, Нийтийн тээврээр үйлчлүүлж байгаа хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд тусламж үйлчилгээ үзүүлэх, нийтийн тээврээр үйлчлүүлэхэд жолоочоос хамаарсан аливаа саад тотгорыг арилгах, жолооч болон албан хаагч нар эдгээр иргэдэд үйлчилгээ үзүүлэх арга техникийг зааж, таниулах зорилгоор арга техникийн талаар мэдлэг, мэдээлэл, дадлага эзэмшүүлэх сургалт хийгдсэн.

Сургалтад Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, Автотээврийн тухай хууль, түүнтэй нийцүүлэн гаргасан дүрэм, журам, “Автотээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих ерөнхий шаардлага” MNS 4598:2020, “Нийтийн зорчигч тээврийн үйлчилгээ. Ангилал ба үйлчилгээнд тавих ерөнхий шаардлага” MNS 5012:2021 стандартуудын талаар мэдээлэл хүргэж, иргэдэд үйлчилгээ үзүүлэх явцад голчлон зөрчигддөг зүйл заалтуудын талаар дэлгэрэнгүй танилцуулж, мэдээлэл өгч ажилласан.

Төрөөс иргэдэд үзүүлэх үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, үйлчилгээг цахимжуулах чиглэлээр үр дүнтэй арга хэмжээ авч, байгууллагын үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлыг нэмэгдүүлж, хүнд суртлыг багасгах, авлига үүсэх эрсдэлийг бууруулна.

“Гэр хорооллын тээврийн үйлчилгээг сайжруулах” төслийн хүрээнд нийтийн тээврийн үйлчилгээний “Нийтийн тээврийн мэдээллийн систем” хөгжүүлэх ажлыг гүйцэтгэгч Инфокон ХХК-иас Нийтийн тээврийн мэдээллийн нэгдсэн системийг танилцуулах, ашиглалтын талаарх зааварчилгаа өгөх 2 удаагийн сургалтыг зохион байгуулав. Үүнд:

-Нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллагын ажилтнуудад зориулан 2024 оны 03 дугаар сарын 28-нд зохион байгуулсан сургалтад 30 аж ахуйн нэгж, байгууллагын нийт 48 хүн хамрагдахаас 28 аж ахуйн нэгж, байгууллагын 44 ажилтан хамрагдсан бол тус байгууллагын мэргэжилтнүүдэд зориулан 2024 оны 04 дүгээр сарын 02-нд зохион байгуулсан сургалтад нийт 35 ажилтан албан хаагч тус тус хамрагдсан.

Гэр хорооллын тээврийн үйлчилгээг сайжруулах” төслийн хүрээнд нийтийн тээврийн үйлчилгээний “Өргөдөл гомдлын мэдээллийн систем” программ хүлээн авах төслийн хаалтын семинарыг 2024 оны 07 дугаар сарын 05-нд зохион байгуулсан.

Сургалтад тус газраас 34, УБХК -иас 3 албан хаагч, нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч 28 ААНБ-ын 44 нийт 81 хүн хамрагдсан.



Зураг №45. Аж ахуйн нэгж, байгууллагуудад танилцуулж буй байдал

“Хүүхдийн автобус” төслийг хэрэгжүүлж буй ажилтан албан хаагч, жолооч, хүүхэд зохицуулагч нарт хүүхдийн эрхэнд суурилсан харилцаа, хандлага сэдэвт сургалтыг 2024 оны 01дүгээр сарын 22-ны өдөр Нийслэлийн боловсролын газар, Тээврийн цагдаагийн албатай хамтран зохион байгуулсан.



Зураг №46. Сургалтын үйл явцаас

Сургалтад жолооч, хүүхэд зохицуулагч 97, дүүргүүдийн уг үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн, сургуулийн нийгмийн ажилтан 15 нийт 112 хүн сургалтад хамрагдсан.

“Нийтийн тээврийн үйлчилгээнд шинээр ажиллах болон зөрчил гаргасан жолооч нарт тээврийн үйлчилгээний стандартууд, нийтийн тээврийн жолооч нарын гаргадаг нийтлэг зөрчил, анхаарах асуудлууд” сэдэвт сургалтыг зохион байгуулсан.



Зураг №47. Сургалтын үйл явцаас

Тээврийн цагдаагийн алба, Замын хөдөлгөөний удирдлагын төв НӨҮГазартай уг сургалтыг хамтран зохион байгуулж нийт 16 аж ахуйн нэгж байгууллагын 174 жолооч хамрагдсан.

2.7.11. Нийтийн тээврийн үйлчилгээнд ажиллаж байгаа залуу жолооч нар тэдгээрийн гэр бүлд зориулсан “Түмний жолооч -Түшигтэй гэр бүл” сэдэвт соён гэгээрүүлэх, урлаг, уран сайхны нэгдсэн арга хэмжээ.

Нийтийн тээврийн үйлчилгээнд ажиллаж байгаа залуу жолооч нар тэдгээрийн гэр бүлд зориулсан “Түмний жолооч -Түшигтэй гэр бүл” сэдэвт соён гэгээрүүлэх, урлаг, уран сайхны нэгдсэн арга хэмжээ 2024 оны 03 дугаар сарын 17-ны өдөр Нийслэлийн Улаанбаатар театрт амжилттай зохион байгуулагдаж нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч 18 аж ахуйн нэгж байгууллагын 185 жолооч гэр бүлийн хамт нийт 378 хүн оролцов.

Үйл ажиллагааны ивээн тэтгэгчээр нийтийн тээврийн үйлчилгээний ЭМСИД ХХК ажилласан бол Улаанбаатар театр ОНӨТҮГ нь урлагийн үзүүлбэрээр, Монголын залуучуудын холбоо ТББ шилдэг лекторуудын урьж илтгэл тавиулж, Приус центр ХХК, Акума эрин ХХК-иуд нь оролцогчдод гарын бэлэг гардуулж, Эрдэм транс ХХК, Жапан бюти ХХК-иуд нь азтан шалгаруулах үйл ажиллагааг ивээн тэтгэж оролцсон.



Зураг №48. Нийслэлийн Нийтийн тээврийн газрын дарга Д.Отгонжаргал мэндчилгээ дэвшүүлж, тус салбарт хийгдэж байгаа ажлуудын талаар мэдээлэл өгөв.

Гэр хорооллын нийтийн тээврийг хөгжүүлэх төслийн хүрээнд “Хөөрхөн зүрх” Төрийн бус байгууллагаас 5 төрлийн нийт 5000 ширхэг нийтийн тээврээр соёлтой үйлчлэхийг уриалсан стикерийг аж ахуйн нэгж, байгууллагуудад хуваарилж тараасан.

Газрын даргын 2024 оны 09 дүгээр сарын 10-ны өдөр баталсан удирдамжийн дагуу Нийслэлийн нийтийн зорчигч тээврийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллагуудын хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа эрүүл ахуйн болон ашиглалтын инженерүүдэд “Галын аюулгүй байдлыг хангах нь” онол, дадлага хосолсон сургалтыг Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн Онцгой байдлын хэлтэс, Гал түймэр унтраах 26-р ангийн 2-р хэсэг, Зорчигч тээвэр хоёр ОНӨААТҮГ-тай хамтран 09 дүгээр сарын 12-ний өдөр зохион байгуулсан. Нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч 22 аж ахуйн нэгж байгууллагын 45 ажилтан хамрагдсан.



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАГЬСЫН ХӨРӨНГӨЛӨГЧ АГЕНТАЛ
НИЙТИЙН ТЭЭВРИЙН БОДЛОГЫН ГАЗАР
 Ниадамдын зам 1200, Ардштын өв,
 23 дугаар хороо, Хэн Уул дүүрэг,
 Улаанбаатар хот-17100
 Утас/факс: (076-11) 32 79 08
 Цахим хуудас: www.niaam.gov.mn

НИЙТИЙН ТЭЭВРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ
ЭРХЛЭГЧ АЖ АХУЙН НЭГЖ,
БАЙГУУЛАГУУДАД



НИЙСЛЭЛИЙН НИЙТИЙН ЗӨРЧИГЧ ТЭЭВРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭГЧ АЖ АХУЙН НЭГЖ,
БАЙГУУЛАГУУДЫН ХӨДӨЛМӨРИЙН АСУУЛГҮЙ АЖИЛЛАГАА, ЭРҮҮЛ АХУЙН БОЛОН
АШИГЛАЛТЫН ИНЖЕНЕРҮҮДЭД "ГАЛЫН АСУУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ НЬ" ОНОЛ, ДАДЛАГА
ХОССОЛСОН СУРГАЛТЫН УДИРДАМЖ

2024 оны 09 дүгээр сарын 10-ны өдөр Улаанбаатар хот

Сургалтад камруулах тухай

Нийслэлийн нутаг дэвсгэрт нийтийн зорчигч тээврийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллагуудын Хөдөлмөрийн асуулгуй ажиллагаа, эрүүл ахуйн болон ашиглалтын инженерүүдэд гал түймрийн аюул, ослын үед цаг алдалгүй шаардлагатай арга хэмжээг авах, иргэдийг аливаа эрсдэлд орохоос урьдчилан сэргийлэх, авран хамгаалах арга барилд сургах зорилготой "Галын асуулгуй байдлыг хангах нь" онол, дадлага хосолсон сургалтыг 09 дүгээр сарын 12-ны өдөр Сонгинохайрхан дүүргийн Онцгой байдлын хэлтэстэй хамтран Зорчигч тээвэр хоёр ОНӨААТҮГ-ын сургалтын танхимд 11:00 цагаас 16:00 цагийн хооронд зохион байгуулав.

Иймд сургалтад холбогдох инженер, техникийн ажилтнуудыг оролцоог ханган, идэвхтэй оролцуулж, сургалтаар олгосон мэдлэгээр байгууллагын ажилтнуудад сургалт зохион байгуулан, тайланг 2024 оны 09 дүгээр сарын 30-ны дотор тус газарт ирүүлнэ үү.

Сургалтын удирдамжийг хавсаргав.

Хавсралт 3 хуудастай.

- Нэг. Үндэслэл**
- 1.1. Нийслэлийн нийтийн тээврийн үйлчилгээг төрийн өмчийн 5, хувийн хэвшлийн 15 аж ахуйн нэгж өдөрт 520 гаууй ачаагаа иргэдэд зургаж байна. Нийтийн тээвэрээр үйлчилгээг иргэдэд аюул осолгүй найдвартай хургаж, асуулгуй ажиллагааг ханган амилгах нь нийтийн тээврийн үйлчилгээний үндсэн шаардлагуудын нэг юм.
 - Хоёр. Сургалтын зорилго**
 - 2.1. Нийслэлийн нутаг дэвсгэрт нийтийн зорчигч тээврийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллагуудын Хөдөлмөрийн асуулгуй ажиллагаа, эрүүл ахуйн болон ашиглалтын инженерүүдэд гал түймрийн аюул, ослын үед цаг алдалгүй шаардлагатай арга хэмжээг авах, иргэдийг аливаа эрсдэлд орохоос урьдчилан сэргийлэх, авран хамгаалах арга барилд суралцаж, мөхсөн болон бусад ажилтнуудад арга сургахаад оршино.
 - Гурав. Удирдлага зохион байгуулалт**
 - 3.1. Сургалтыг Нийслэлийн Нийтийн тээврийн бодлогын газар, Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн Онцгой байдлын хэлтэс, Гал түймэр унтраах 26-р ангийн 2-р хэсэг, Зорчигч тээвэр хоёр ОНӨААТҮГ хамтран зохион байгуулав.
 - Сургалт зохион байгуулагчид дараах бүрэлдэхүүнтэй байна. Үүнд:
 - Нийслэлийн Нийтийн тээврийн бодлогын газрын албан хаагчид;
 - Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн Онцгой байдлын хэлтсийн алба хаагчид;
 - Гал түймэр унтраах 26-р ангийн 2-р хэсгийн бие бүрэлдэхүүн;
 - Зорчигч тээвэр тав ОНӨААТҮГ-ын албан хаагчид.
 - 3.2. Нийслэлийн Нийтийн тээврийн бодлогын газраас нийтийн зорчигч тээврийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллагуудын сургалтад хамрагдаж инженер, техникийн ажилчдын нэрсийн жагсаалт, хувиарийг гарган, сургалтад хамрагдагчдын оролцоог хангах ажиглана.
 - 3.3. Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн Онцгой байдлын хэлтсийн албан хаагчид Гамшгийн үеийн ойлголт, урьдчилан сэргийлэх, анхны тусламж үзүүлэх, гал унтраах тархалтын онолын болон дадлагын мэдлэг олгоно.
 - 3.4. Гал түймэр унтраах 26-р ангийн 2-р хэсгийн бие бүрэлдэхүүн нь Гал түймэр унтраах тархалтын дадлага сургалтыг хийнэ.

Нийтийн тээврийн бодлогын газар
 Удирдлага дарга
 ДАВНАМ ОТГОНЖАРГАЛ
 2024.09.11 11:58



Зураг №49. Сургалтын үйл явцаас

Нийтийн тээврийн үйлчилгээнд ажиллаж байгаа шалгагч, хяналтын ажилтнуудад зориулсан сургалт зохион байгуулах;

Нийтийн тээврийн бодлогын газрын дарга Д.Отгонжаргал, “Зорчигч тээвэр тав” ОНӨААТҮГ-ын захирал С.Батзаяа нарын хамтран баталсан удирдамжийн дагуу нийтийн тээврийн үйлчилгээнд ажиллаж байгаа шалгагч нарыг чадавхжуулах “Нийтийн тээврийн салбарын өнөөгийн байдал, нийтийн тээврийн үйлчилгээнд шалгагч нарын оролцоо” сэдэвт сургалтыг 2024 оны 11 дүгээр сарын 01-ний өдөр Хяналт шалгалтын хэлтэс, “Зорчигч тээвэр тав” ОНӨААТҮГ-ын албан хаагчидтай хамтран зохион байгуулав.

Сургалтад 6 аж ахуйн нэгж байгууллагын 73 шалгагч хамрагдсан.



Зураг №50. Сургалтын үйл явцаас

Хүрсэн үр дүн: 2024 онд нийт 50 удаагийн сургалт зохион байгуулж, 2917 ажилтан, албан хаагч хамруулсан нь 2023 онтой харьцуулахад сургалтын тоо 56.0 хувь, сургалтад хамрагдагчдын тоо 86.0 хувиар нэмэгдсэн байна.



ГУРАВДУГААР БҮЛЭГ. НИЙТИЙН ТЭЭВРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ОРЛОГО ТӨСӨВТ ТӨВЛӨРҮҮЛЭХ
ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. АРХИВ, АЛБАН ХЭРЭГ ХӨТЛӨЛТИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХЭРЭГЖИЛТ

Албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаа, зохион байгуулалтыг боловсронгуй болгох, баримт бичгийн эмх цэгц бүрдэл, хадгалалт ашиглалтыг сайжруулах зорилгоор үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Монгол Улсын Засгийн газрын 81 дүгээр тогтоол (Байгууллагын нэрийн өөрчлөлт), Нийслэлийн засаг даргын А/443 дугаар захирамж (Бүтэц орон тооны хязгаар), Нийслэлийн засаг даргын А/536 дугаар захирамж (Нийтийн тээврийн бодлогын газрын дүрэм) хүрээнд байгууллагын нэрийн өөрчлөлт Нийтийн тээврийн газар–ыг Нийтийн тээврийн бодлогын газар болгон өөрчилж бүтэц орон тооны өөрчлөлт орж Газрын даргын тамга-1ш, Тэмдэг-1ш, Хуулбар үнэн тэмдэг -1ш, Архивын нүүр тэмдэг-1ш, Ирсэн бичиг бүртгэх тэмдэг-1ш, Санхүүгийн тэмдэг-1ш, Нягтлан бодогч-1ш, Кассын тэмдэг-2ш, Техникийн үзлэгийн хяналтын төв-1ш, Онц чухал нууц 1ш , Маш нууц 1 ш, Нууц 1ш, Олшруулсан тэмдэглэгээний дардас 1ш, Хэсэгчлэн авсан тэмдэглэгээний дардас 1ш эдгээр тамга тэмдгийг шинээр хийлгэсэн.

Шинээр хийгдсэн тамга тэмдгийн дардсыг дарж тамга тэмдэг түших албан хаагчдаар гарын үсэг зуруулж, тамга тэмдэг хийлгэхээр явуулсан бичгийн хамт архивласан.




"Нийтийн тээврийн газар"-ыг "Нийтийн тээврийн бодлогын газар" болгон өөрчилж, удирдлага, зохион байгуулалтын бүтэц, орон тоо, шинэчлэн батлагдаж байгаатай холбогдуулан Газрын даргын тамга-1ш, Тэмдэг-1ш, Хуулбар үнэн тэмдэг -1ш, Архивын нүүр тэмдэг-1ш /шифр/, Ирсэн бичиг бүртгэх тэмдэг-1ш, Санхүүгийн тэмдэг-1ш, Нягтлан бодогч-1ш, Кассын тэмдэг-2ш, Техникийн үзлэгийн хяналтын төв-1ш эдгээр тэмдгийг шинээр хийлгэх хүсэлтэй байгаа тул шийдвэрлэж өгнө үү.

Хавсралт 2 хуудастай.



"Нийтийн тээврийн газар"-ыг "Нийтийн тээврийн бодлогын газар" болгон өөрчилсөнтэй холбогдуулан дараах тэмдэглэгээний дардасуудыг шинээр хийлгэх хүсэлтийг шийдвэрлэж өгнө үү. Үүнд:
1. Онц чухал нууц 1ш
2. Маш нууц 1 ш
3. Нууц 1ш
4. Олшруулсан тэмдэглэгээний дардас 1ш
5. Хэсэгчлэн авсан тэмдэглэгээний дардас 1ш

Хавсралт 2 хуудастай.



Зураг №57. Шинээр тамга тэмдэг хийлгэхээр Эхлэл ургац ХХК-д явуулсан албан бичиг

Байгууллагын нэрийн өөрчлөлт орсонтой холбогдуулан байгууллагын гэрчилгээний өөрчлөлтийг хийлгэсэн.

2024 оны 03 дугаар сарын 29-нд "Баримт нягтлан шалгах комисс"-ын 01 дүгээр хурал хуралдсан.

Монпасс ХХК-д 2024.05.15-ны өдрийн 01/01/1273 дугаартай (Тоон гарын үсэг), Нийслэлийн Архивын газар 2024.05.13-ны өдрийн 01/01/1259 дугаартай (Хэвлэмэл хуудас захиалах), Авлигатай тэмцэх газарт 2024.06.17 ны өдрийн 01/01/1534 дугаартай (Баримт хүргүүлэх тухай), Нийслэлийн Архивын газар 2024.06.18-ны өдрийн 01/01/1562 дугаар (Хэвлэмэл хуудас захиалах) албан бичгийг хүргүүлж, ирсэн 12 албан бичгийг шийдвэрлэсэн.

Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Нийслэлийн Үйлчилгээний нэгдсэн төв Чат бот үйлчилгээг нэвтрүүлж байгаатай холбогдуулан Байгууллагын хэмжээнд цахимаар үйлчилгээ үзүүлж байгаа үйлчилгээний талаар судалгаа гаргаж явуулсан.

Архиваас 1 хуудас 1 тушаал, 4 хадгаламжийн нэгж архиваас ашиглуулсан.

Байгууллагын архивт хадгалагдаж буй баримтаас 69 хуудас 14 баримтад хуулбар үнэн дарсан.

4.1.Архив, албан хэрэг хөтлөлтөд мөрдөгдөж байгаа хууль эрх зүйн дүрэм, журмын хэрэгжилтийн талаар;



MNS 5140:2021 Монгол Улсын стандарт "Албан хэрэг хөтлөлт"
 2020 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн Монгол Улсын Засгийн газрын 246 тогтоол "Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам"-г,
 2023 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн А/111 захирамж "Албан хэрэг хөтлөлтийн eDoc систем ашиглах журам батлах тухай",
 Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 226 Тогтоол "Тамга, тэмдэг, баталгааны тэмдэг, хэвлэмэл хуудас хийлгэх, хэрэглэх журам", Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2021 оны 222 дугаар тушаал "Байгууллагын архивын үйл ажиллагааны нийтлэг журам,
 Архивын ерөнхий газрын даргын 2023 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн А/91 тушаал "Архивын баримтын нэр төрөл, хадгалах хугацааны үлгэрчилсэн болон салбарын жагсаалт батлах тухай"
 2021 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн А/52 "Захирамжлалын баримт бичиг гаргах ажиллагааны журам"-г www.erp.ulaanbaatar.mn байршуулан албан хаагчдад мэдээлэл өгч ажилласан.



Зураг №58. Албан хэрэг хөтлөлтөд мөрдөгдөж буй дүрэм журам, стандарт

4.2. Дээд газраас ирсэн захирамж, тогтоол, албан даалгавар, тушаал:


Дээд газраас ирсэн захирамж, тогтоол, албан даалгавар, тушаалуудыг тухай бүр бүртгэн авч удирдлагад танилцуулан ажиллаж байна. 2024 оны жилийн байдлаар нийт 65 Захирамж тогтоол ирснээс Монгол Улсын Засгийн газрын тогтоол-1, Монгол Улсын Засгийн газрын хурлын тэмдэглэл-1, Нийслэлийн иргэдийн төлөөлөгчийн тогтоол-16, Нийслэлийн Засаг даргын захирамж-31, Нийслэлийн Засаг даргын Албан даалгавар-1, Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хурлын тэмдэглэл-4, Монгол Улсын Ерөнхий сайд албан даалгавар-1, Зам тээврийн хөгжлийн сайд, Нийслэлийн засаг даргын хамтарсан захирамж-1, Нийслэлийн дотоод аудитын хорооны тогтоол-1, Зам, тээврийн хөгжлийн яамны Улсын ахлах байцаагчийн зөвлөмж-1, Нийслэлийн прокурорын тогтоол-1, Нийслэлийн прокурорын газрын прокурорын шаардлага-1, Хотын стандарт хяналтын газрын зөвлөмж-1, Нийслэлийн онцгой комиссын удирдамж-1, Нийслэлийн онцгой комиссын албан даалгавар-1, Тээврийн прокурорын газрын прокурорын зөвшөөрөл-1, Баянгол дүүргийн засаг даргын захирамж-1 ирснийг тус тус бүртгэн зохион байгуулалтын нэгжүүдэд хувилж тараан мэдээллийн шуурхай байдлыг хангаж ажиллаж байна.

2024 оны 321 хуудас 65 тогтоол, захирамжийг сканердаж цахим файл үүсгэсэн.

График 25



4.3.Газрын даргын тушаал шийдвэр:



Зураг №59. Нийтийн тээврийн бодлогын газрын даргын 2024 оны тушаал шийдвэр

-А тушаал-148:

Төрийн албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгүүлэх хуваарийг шинэчлэн батлах тухай-2, Эргүүл жижүүр ажиллуулах тухай-1, Хөрөнгө бүртгэх тухай -3, Нийтийн зорчигч тээврийн үйлчилгээний чиглэл нэмэх тухай-2, Нийтийн зорчигч тээврийн үйлчилгээний чиглэлд өөрчлөлт оруулах тухай-16, Нийтийн зорчигч тээврийн үйлчилгээний чиглэлийн замналд, зогсоол нэмэх, хасах, тухай-15, Нийтийн зорчигч тээврийн үйлчилгээний чиглэл нээх, хаах тухай-15, Сургуулийн автобусны чиглэлд өөрчлөлт оруулах тухай-5, Томилолтоор ажиллуулах тухай-8, Авто үйлчилгээ эрхлэх үйл ажиллагаанд ангилал тогтоож гэрчилгээ олгох тухай-9, Хэвлэмэл хуудас хүчингүй болгох тухай-1, Ажлын хэсэг байгуулах тухай-22, Хөдөлмөрийн дотоод журамд өөрчлөлт оруулах тухай-2, Хөдөлмөрийн дотоод хэм хэмжээ батлах тухай-1, Нийтийн тээврийн үйлчилгээний төлөвлөлтийг шинэчлэн тогтооход хяналт тавих тухай-1, Ахмадуудад хүндэтгэл үзүүлэх тухай-2, Зардал гаргах тухай-3, Албан хаагчдын цалингийн хэмжээ шинэчлэн тогтоох тухай-1, Гэрээний үүргийн биелэлт дүгнэх журам батлах тухай-2, Эргүүл жижүүр ажиллуулах тухай-1, Ахмадын бүртгэлд авах тухай -1, Амралтын өдрүүдэд ажиллуулах тухай-2, Албан хаагчдын нэг өдрийн хоол унааны зардлын тодорхой хэсгийг олгох, хөдөлмөрийн дотоод хэм хэмжээг батлах тухай-1, Хавар, намрын ээлжит техникийн хяналтын үзлэг зохион байгуулах тухай-, Байгууллагын спортын хамтлаг шинэчлэн байгуулах тухай-1, Ажлын байрны нээлттэй өдөрлөгт оролцох тухай-1, Спортын арга хэмжээ зохион байгуулах тухай-2, Төрийн болон албаны хууль, байгууллагын нууц, хүний



хувийн мэдээллийг агуулсан баримт бичигтэй танилцах, ашиглах, хадгалах, хамгаалах журам батлах тухай-1, Зохион байгуулалтын бүтэц, ажил мэргэжлийн жагсаалт батлах тухай-1, Хяналтын дагалдах хуудасны загвар батлах тухай-1, Ажил хүлээлцүүлэх комиссын бүрэлдэхүүн шинэчлэн батлах тухай-1, Зохион байгуулалтын индекс батлах тухай-1, Зохион байгуулалтын нэгжийн үйл ажиллагааны чиг үүргийг батлах тухай-1, Хөдөлмөрийн дотоод журам батлах тухай-1, Ажлын байрны тодорхойлолт батлах тухай-1, Үнэлгээний баг байгуулах тухай -1, Долоо хоногийн ажлын нэг өдөр цахимаар ажиллуулах тухай-1, Сургалт зохион байгуулах тухай-1, архивын баримтад тооллого явуулах тухай-1, Ажлын байрны нүүлгэн шилжүүлэлтийг зохион байгуулах тухай-1, Өмч хамгаалах байнгын зөвлөлийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай-1, Хөрөнгө бүртгэх тухай-3, Нийтийн тээврийн үйлчилгээний талаар иргэдээс мэдээлэл авах зурагт хуудасны хэмжээ загвар батлах тухай-1, Орон тооны бус эмэгтэйчүүдийн зөвлөл байгуулах тухай-1, Үндсэн ба эргэлтийн хөрөнгийн 2024 оны жилийн эцсийн тооллогын ажил зохион байгуулах тухай-1, Тушаалд өөрчлөлт оруулах тухай-1

-Б тушаал-240:

Ажилд томилох тухай-43, Шилжүүлэн ажиллуулах тухай-1, Ажлаас чөлөөлөх тухай-23, Чөлөө тэтгэмж олгох тухай-7, Чөлөө олгох тухай-12, тэтгэмж олгох тухай-2, Ур чадварын нэмэгдэл олгох тухай-11, Ажил үүргийг хавсран гүйцэтгэх нэмэгдэл олгох тухай-18, Ахмадын бүртгэлд авах тухай-4, Сахилгын шийтгэл ногдуулах тухай-2, Сахилгын шийтгэлгүйд тооцох тухай-2, Хүүхэд асрах чөлөө олгох тухай-4, Төрийн болон албаны нууц хамгаалах чиг үүргийг хариуцах тухай-1, Албан хаагчдын цалингийн хэмжээ шинэчлэн батлах тухай-2 тушаалд өөрчлөлт оруулах тухай-5, Буцалтгүй тусламж олгох тухай-1, Албан хаагчдыг үргэлжлүүлэн ажиллуулах, чөлөөлж томилох тухай-1, Тушаал хүчингүй болгох тухай-2, Төрийн болон албаны нууц хамгаалах чиг үүргийг хариуцах тухай-1, Төрийн албан хаагчдад ажлын үр дүнгээр мөнгөн урамшуулал олгох тухай-1 тушаалыг хэвлэмэл хуудсанд буулгасан.

2024 оны 203 хуудас 377 тушаалыг сканердаж цахим файл үүсгэсэн.

2023 оны жилийн тушаалыг 2024 оны мөн үетэй харьцуулбал

Хүснэгт 44

Д/Д		2023 он	2024 он
1	А	109	148
2	Б	262	240

График 26





График 27



4.4. Дээд, болон бусад байгууллагуудаас ирсэн албан бичиг шийдвэрлэлтийн талаар:

Тус газарт 2024 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн байдлаар дээд, болон бусад байгууллагуудаас нийт 4541 албан бичиг ирснээс Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвөөр 62 бичиг, байгууллагаар бүртгэгдсэн 409 албан бичиг, хариутай 481 албан бичиг, хариугүй 4060 албан бичиг хүлээн авч газрын дарга болон холбогдох албан тушаалтанд танилцуулж, хүлээлгэн өгч хяналт тавьж ажилласнаас хугацаандаа шийдвэрлэгдсэн 4362, шийдвэрлэлтийн шатандаа 117, хугацаа хэтэрч шийдвэрлэгдсэн 62, Зөрчил тооцогдсон 182 албан бичгийг, байгууллагын хэмжээнд ирсэн албан бичгийн шийдвэрлэлтийн дүн 96,51%, Шийдвэрлэлтийн дундаж хугацаа (хоногоор) 4,74-тай байна.

Байгууллагад ирсэн 4541 бичгийг хэлтсээр нь авч үзэхэд:

-Удирдлага 10 албан бичиг 100% Шийдвэрлэлтийн дундаж хугацаа (хоногоор) 1,7;

-Захиргаа удирдлагын хэлтэс 530 албан бичиг 94,8% /Шийдвэрлэлтийн дундаж хугацаа (хоногоор) 4,39/;

-Санхүү аж ахуйн хэлтэс 467 албан бичиг 96,2% /Шийдвэрлэлтийн дундаж хугацаа (хоногоор) 7,09/;

-Тээврийн бодлого судалгааны хэлтэс 617 албан бичиг 97,7% /Шийдвэрлэлтийн дундаж хугацаа (хоногоор) 8,24/;

-Зорчигч тээврийн хэлтэс 2498 албан бичиг 98,8% /Шийдвэрлэлтийн дундаж хугацаа (хоногоор) 3,09/;

-Хяналт шалгалтын хэлтэс 142 албан бичиг 97,6% /Шийдвэрлэлтийн дундаж хугацаа (хоногоор) 8,72/;

-Ачаа тээвэр авто үйлчилгээний хэлтэс 81 албан бичиг 100% /Шийдвэрлэлтийн дундаж хугацаа (хоногоор) 6,27/;

-Техникийн хяналтын үзлэгийн төв 117 албан бичиг 78,3%, /Шийдвэрлэлтийн дундаж хугацаа (хоногоор) 7,21/;

-Бүртгэл, техник технологийн хэлтэс 79 албан бичиг 93,1% /Шийдвэрлэлтийн дундаж хугацаа (хоногоор) 5,89/;

Байгууллагад ирсэн 1665 хуудас 409 албан бичгийг сканердаж програмд шивж даргад шилжүүлэн шийдвэрлэлтэд хяналт тавьж ажиллав.

Албан хэрэг хөтлөлтийн edoc.ulaanbaatar.mn програмаар ирсэн байгууллагын нэр буруу-19, Албан бичиггүй-3, хавсралт файл стандартын шаардлага хангахгүй-12, дахин ирсэн-1, Гарын үсэг тамга тэмдэггүй-1 албан бичиг ирснийг буцаасан буцаасан. 10 албан бичгийн шийдвэрлэх хугацааг сунгуулсан.


Програмаар ирсэн 12 бичгийг шийдвэрлэсэн.

Байгууллагын хэмжээнд нийт 182 зөрчил тооцогдсоноос хугацаа хоцорч шилжүүлсэн-9, Явцын тэмдэглэл хөтлөөгүй-167 зөрчил тооцогдсон байна. Зөрчлийн тоог бууруулах ажлын хүрээнд 2021 оны 01 дүгээр сараас 09 дүгээр сарын хугацааны зөрчил дээр давхардсан тоогоор 49 албан хаагчдад албан мэдэгдэл өгсөн.

График 28



Ирсэн албан бичгийг хэлтэс тус бүрээр илэрхийлж үзүүлбэл:




- Удирдлага
- Санхүү аж ахуйн хэлтэс
- Зорчигч тээврийн хэлтэс
- Ачаа тээвэр, авто үйлчилгээний хэлтэс
- Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтэс
- Захиргаа удирдлагын хэлтэс
- Тээврийн бодлого, судалгааны хэлтэс
- Хяналт шалгалтын хэлтэс
- Бүртгэл, техник технологийн хэлтэс
- Орлого төвлөрүүлэлтийн тасаг

2024 оны жилийн ирсэн албан бичгийг 2023 оны мөн үетэй харьцуулбал:

Хүснэгт 45

Д/Д	2023	2024 он	Тоо
1	3954	4541	587

График 29



4.5.Өргөдөл гомдол:

Байгууллагад ирсэн 48 хуудас 32 өргөдлийг сканердаж файл үүсгэн erp.ulaanbaatar.mn програмд шивж нийт 297 өргөдөл гомдлыг шилжүүлж ажилласан.

-2024 оны Нийслэлийн засаг даргын А/91 захирамжийн хүрээнд 3 жилийн өргөдөл гомдолд дүн шинжилгээ хийхтэй холбогдуулан 2024 оны 01 дүгээр сард ирсэн 1641 өргөдлөөс 435 гомдолд дүн шинжилгээ хийсэн.

- Цэвэрлэгээтэй холбоотой-2
- Стандартын зөрчил-Автобус эвдэрсэн, хүйтэн байсан-90
- Карт унших төхөөрөмжийн талаар-9
- Чиглэл маршрут цагийн хуваарь мөрдөөгүй гомдол-299
- Нийтийн тээврийн албан хаагчидтай холбоотой гомдол-6
- Жолоочийн зан харьцаатай холбоотой гомдол-23
- Буудал зогсоол дээр зогсоогүй гомдол-4
- Тамхи татсон гомдол-1
- Ширүүн явж гэнэт тормоз гишгэсэн гомдол-1
- Жолоочийн эрх зөрчигдөж байгаа гомдол-6



Нийслэлийн засаг даргын 2024 оны А/91 захирамжийн дагуу 2021-2024 оны 2021 оны -93
2022 оны -582
2023 оны-329
2024 оны 435

Нийт-1439 гомдолд дүн шинжилгээ хийж 2024 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн 01/01/426 дугаартай албан бичгээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлсэн.



НИЙСЛЭЛИЙН НУТГИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГУУДАД

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА Л.ХОСБЯАР ТАНАА

Нийслэлийн Засаг даргын 2024 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн "Иргэдийн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийг сайжруулах талаар авах зарим арга хэмжээний тухай" А/91 дүгээр захирамжаар нийслэлийн нутгийн захиргааны бүх шатны байгууллага, албан тушаалтанд иргэдээс гаргасан өргөдөл, гомдлыг эрх хэмжээнийхээ хүрээнд бүх талаас нь судлан үзэж, хуулийн хугацаанд бүрэн барагдуулж шийдвэрлэх, хариуг иргэнд заввал өгч хэвшиг, төрийн албан хаагчдын санхүүг, хариуцлагыг дээшлүүлэх чиглэлээр тодорхой үүрэг даалгаврыг өгсөн байна.

Нийслэлийн Засаг даргын 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн "Иргэдийн өргөдөл гомдлын шийдвэрлэлтийг сайжруулах талаар авах зарим арга хэмжээний тухай" А/91 дүгээр захирамжийн хүрээнд 2021 оноос 2024 оны 01 дүгээр сар хүртэл хугацаанд тус газарт ирсэн өргөдөл гомдолд дүн шинжилгээ хийн, хүчин зүйлийг тодорхойлон, шийдвэрлэх арга хэмжээний саналыг гарган хавсралтаар хүргүүлж байна.

Иймд дээрх захирамжийн хэрэгжилтийг бүрэн хангаж, биелэлтийг иргэдийн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн үндэслэл тайлан мэдээнд тусгаж Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт албан бичгээр ирүүлж ажиллана уу.

Хавсралт 2 хуудастай.



Зураг №60. 2024 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн 01/01/426 дугаартай албан бичиг

4.6.Ирсэн бичгийн шийдвэрлэлтэд хяналт хийсэн талаар:

Ирсэн 3603 албан бичгийн шийдвэрлэлтэд хяналт хийж хангалтгүй шийдвэрлэсэн, болон үг үсгийн алдаатай нийт 173 албан бичгийг цуцлан дахин шийдвэрлүүлэв.

- 11 албан бичгийг дахин хянасан.

Ирсэн бичигт хийсэн хяналтын харьцуулалт

Хүснэгт 46

Д/Д	2023 он	2024 он	тоо
1	3954	2463	667

График 30



4.7.Гадны байгууллагад явуулсан бичиг:


Гадны байгууллагад явсан 3072 албан бичгийг 4385 байгууллагад хэвлэмэл хуудсанд буулгасан.



Гадны байгууллагад явуулсан албан бичгийг тоон гарын үсэг зурж баталгаажсаны дараа тус байгууллагуудад цаг тухайд нь илгээж ажилласан.

Гадны байгууллагад явуулсан 245 албан бичигт бүртгэл үйлдэн хаяглаж шуудангаар хүргүүлэн ажиллаж байна.

График 31




*2023 оны жилийн явсан албан бичгийг
2024 оны мөн үетэй харьцуулбал:*

Хүснэгт 47


Д/Д	2023 он	2024 он	Тоо
1	2444	3072	-628

График 32



2024 оны жилийн тогтоол, захирамж, ирсэн, явсан албан бичиг

График 33



2024 оны жилийн баримт бичгийн эргэлтийн хэмжээг тооцоолбол

Хүснэгт 48


д/д	Баримт бичиг	Баримт бичгийн тоо			Нийт
		Эх хувь	Хуудасны тоо	Скайнардсан	
1	Ирсэн баримт бичиг	4541	9082	2200	15823
2	Явуулсан баримт бичиг	3072	6144	0	9216
3	Төсөл, төлөвлөгөө, тайлан, тушаал, захирамж, протокол, гэрээ, акт зэрэг дотоодын баримт бичиг	65	130	321	516
Дүн		7678	15356	2521	25555

4.8. Байгууллагын хэвлэмэл хуудас ашиглалтын талаар:

Монгол Улсын Засгийн газрын 81 дүгээр тогтоол, Нийслэлийн Засаг даргын А/443 дугаар Захирамжийн хүрээнд байгууллагын нэрийн өөрчлөлт, бүтэц орон тооны өөрчлөлт орсон тул хэвлэмэл хуудсыг <https://edoc.ulaanbaatar.mn/>- системд байгууллагын нэрийн өөрчлөлт болон хаягийн өөрчлөлт хийн Нийслэлийн архивын газраар хянуулан <https://edoc.ulaanbaatar.mn/>- системээр А5-3700ш, А4-3900ш Тушаал-1700ш, Албан даалгавар-100ш, Захиргааны зөвлөлийн хурлын тэмдэглэл-100ш, Техникийн дүгнэлт-1200ш, Албан шаардлага-510ш захиалж хэвлүүлсэн.

Хэвлэмэл хуудасны бүртгэл хөтөлж ажилласан. Хэвлэмэл хуудасны тооцоог тухай бүр гарган ажиллаж байна.

2023 оны хүчингүй болгосон хэвлэмэл хуудас Захиргааны зөвлөлийн хурлын тэмдэглэл-22, А5-15ш, А4-28ш тушаал-73ш, Автотээврийн хяналтын улсын байцаагчийн дүгнэлт-149ш, Автотээврийн хяналтын улсын байцаагчийн албан шаардлага-20ш, Нийт 307 хэвлэмэл хуудсыг 2024 оны 01 дүгээр сарын 16-ны А/09 тушаалаар хүчингүй болгосон. Хүчингүй болгосон 307 хэвлэмэл хуудсыг устгалд оруулсан.



Зураг №61. Хүчингүй болгосон 307 хэвлэмэл хуудсыг устгалд оруулж буй байдал

2024 оны хэвлэмэл хуудасуудыг ашиглалтад бэлтгэн, төрлөөр нь ялгаж дугаарлан ашиглалт, хадгалалт, хамгаалалтыг хариуцаж, бүртгэлийн тэмдэг дардсыг зааврын дагуу Тушаал, А4, А5 хэвлэмэл хуудасны бүртгэлийн тэмдэг дардсыг даран дугаарласан. (А5-1-1524-1524Ш А4-1-3375-3375Ш Тушаал--1-960-960ш) Хэвлэмэл хуудасны бүртгэл хөтөлж ажилласан.

2024 оны хэвлэмэл хуудасны тооцоо

Хүснэгт 49

д/д	Нэр төрөл	Захиалж авсан	Нийт	Зарцуулсан	Хүчингүй болгосон	Үлдэгдэл
1	А-4	3900	5800	3374	56	1900
2	А-5	3700	5450	1521	27	1750
3	Тушаал	1700	2980	954	114	1280
4	Албан даалгавар	100	100	0	0	100
5	Хурлын тэмдэглэл	100	100	6	0	94
6	Гадаад харилцаа	0	0	0	0	0
7	АТХУБ дүгнэлт	1200	1563	486	44	363
8	АТХУБ албан шаардлага	510	1594	58	2	1084
9	АТХУБ Акт	0	0	0	0	0
Дүн						

2024 оны хүчингүй болгосон хэвлэмэл хуудас

Хүснэгт 50

д/д	Нэр төрөл	Хүчингүй болгосон хэвлэмэл хуудасны индекс	Тоо
1	Тушаал	55, 56, 57, 59, 61, 80, 81, 90, 91, 115, 116, 201, 202, 210, 211, 255, 256, 308, 309, 310, 311, 312, 317, 318, 339, 340, 384, 385, 388, 389, 410, 411, 433, 468, 469, 486, 487, 494, 495, 498, 499, 510, 511, 512, 513, 517, 518, 521, 522, 524, 537, 538, 561, 562, 563, 564, 567, 568, 569, 570, 577, 590, 591, 596, 600, 602, 603, 604, 611, 612, 613, 619, 620, 621, 622, 623, 624, 625, 626, 627, 628, 629, 630, 631, 633, 634, 635, 637, 638, 641, 642, 643, 646, 651, 652, 653, 654, 705, 706, 707, 741, 742, 747, 748, 753, 754, 777, 778, 795, 796, 801, 802, 816, 817,	114
2	Албан бичиг (А5)	145, 149, 411, 412, 912, 913, 1002, 1004, 1009, 1040, 1041, 1042, 1043, 1047, 1048, 1054, 1055, 1057, 1063, 1065, 1066, 1076, 1077, 1081, 1096, 1189, 1199,	27
3	Албан бичиг (А4)	26, 27, 28, 42, 250, 730, 731, 732, 1092, 1124, 1131, 1135, 1136, 1137, 1138, 1140, 1141, 1142, 1143, 1144, 1149, 1156, 1158, 1159, 1160, 1161, 1162, 1226, 1231, 1227, 1249, 1251, 1270, 1277, 1283, 1284, 1285, 1315, 1332, 1339, 1340, 1418, 1419, 1420, 1400, 1401, 1430, 1431, 1435, 1437, 1439, 1447, 1576, 1577, 1602, 1608,	56
4	АТХУБ дүгнэлт	5, 8, 9, 22, 23, 48, 57, 60, 61, 72, 73, 97, 157, 166, 232, 233, 250, 251, 254, 259, 260, 261, 265, 293, 313, 314, 339, 340, 342, 347, 361, 368, 374, 375, 376-2ш, 378, 384, 398, 472, 473, 474, 420, 421,	44
5	АТХУБ албан шаардл	25,26	2
		Нийт	81


4.9.Сургалтын талаар:



Нийслэлийн хэмжээнд тоон гарын үсгээ ашиглан албан бичгээ нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудад илгээх, хариу хүлээн авах, хянах, болсонтой холбогдуулан албан хаагчдад www.edoc.ub.gov.mn програм ашиглалтын талаар байгууллагын нийт албан хаагчид албан хэрэг хөтлөлтэй холбоотой журмыг дагаж мөрдүүлэх, Удирдлагын үйл ажиллагааг баримтжуулах, албан бичиг баримтыг эмхлэн бүрдүүлэх, өөрийн үйл ажиллагааны явцад үүсэх баримтыг хадгалж, баримт бичигтэй ажиллах ажлыг зохион байгуулах дэг, горимыг баримталж ашиглах талаар албан хаагчдад Архив, албан хэрэг хөтлөлт, програм ашиглалт, албан бичгийн шийдвэрлэлт, хугацаанд нь шилжүүлэх, шийдвэрлэх зөрчлийг бууруулах, шийдвэрлэлтийн дундаж хоног бууруулах талаар мэдээлэл өгч ажилласан.

Хэлний бодлогын үндэсний зөвлөлөөс зохион байгуулсан Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 96, 2022 оны 07 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол бичгээр баримт бичгийг зохион бүрдүүлэх” сэдэвт сургалтад 2024 оны 05 дугаар сарын 14-д хамрагдсан.

2024 оны 08 дугаар сарын 19-ний өдөр 10 албан хаагчдад програм болон албан хэрэг хөтлөлтийн сургалт зохион байгуулсан.



Зураг №62. Албан хэрэг хөтлөлтийн сургалт

2024 оны 08 дугаар сарын 21-ний өдрөөс 09 дүгээр сарын 02-ны өдрийн хооронд 55 албан хаагчдаас албан хэрэг хөтлөлтийн тестээр шалгалт авсан.



Зураг №63. Албан хэрэг хөтлөлтийн сургалт

2024 оны 08 дугаар сарын 21-ний өдрөөс 09 дүгээр сарын 02-ны өдрийн хооронд 7 хэлтсийн 55 албан хаагчдаас албан хэрэг хөтлөлтийн тестээр шалгалт авсан.

Шалгалтаар 55 албан хаагчид 1100 онооноос 881 оноо авч 80 хувь, дүнгийн голч нь 16 (80%) байна.

**A-15 Эзлэх хувь-27,2****D-7 Эзлэх хувь-12,7****B-21 Эзлэх хувь-38,1****F-3 Эзлэх хувь-5,4****C-9 Эзлэх хувь-16,3**

2024 оны 11 дугаар сарын 18-ны өдөр шинээр ажилд орсон 18 албан хаагчдад програм болон албан хэрэг хөтлөлтийн сургалт зохион байгуулсан.



Зураг №64. Албан хэрэг хөтлөлтийн сургалт

Нийт 2 удаа програм ашиглалт болон Архив, албан хэрэг хөтлөлийн сургалтад хамруулсан бөгөөд 55 албан хаагчдаас албан хэрэг хөтлөлтийн стандартын талаар шалгалт авсан.

Монгол хэлний тухай хууль, Засгийн газрын 2020 оны 96 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол бичгийн үндэсний хөтөлбөр-III”, Засгийн газрын 2022 оны 07 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол хэлний тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” шийдвэрийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Нийслэлийн Архивын газар Хэлний бодлогын үндэсний зөвлөлтэй хамтран 2024 оны 05 дугаар сарын 14-ний өдөр “Монгол бичгээр баримт бичгийг зохион бүрдүүлэх” сэдэвт сургалтад байгууллагын оффист ажилладаг албан хаагчдыг цахим /zoom meeting/-аар хамруулсан.

4.10.Нөхөн бүрдүүлэлтийн талаар:

2024 онд 2023 оны баримтыг эмхэлж цэгцлэх, үдэж хавтаслах, дотоод товъёог үйлдэх, баталгаа болон хадгаламжийн нэгжийн нүүр хуудас бичих зэрэг техник боловсруулалт хийж Явуулсан албан бичиг 68 боть, Ирсэн бичиг-16 боть, Дээд газраас ирсэн захирамж тогтоол-1, Дээд газраас ирсэн хурлын тэмдэглэл, тушаал-1, Бичиг хэргийн ажилтны тайлан-1, Төлөвлөгөө, төлөвлөгөөний биелэлт-1, бүртгэлийн дэвтэр-6, Ирсэн бичгийн бүртгэл хяналтын карт-3, ирсэн бичгийн шийдвэрлэлийн мэдээ-1 боть, А-тушаалын саналын хуудас 3 боть, Б.Тушаалын саналын хуудас 4 боть, Хэвлэмэл хуудасны ашиглалт зарцуулалтад хийсэн тооцоо-1 боть, Баримт бичгийн эргэлтийн мэдээ-1 боть нийт 94 боть баримт үдэж, хавтаслан хадгаламжийн нэгж бүрдүүлэн архивт нөхөн бүрдүүлэлт хийсэн.

2024 оны баримтыг эмхэлж цэгцлэх, үдэж хавтаслах, дотоод товъёог үйлдэх, баталгаа болон хадгаламжийн нэгжийн нүүр хуудас бичих зэрэг техник боловсруулалт хийж А тушаалын саналын хуудас-2 боть, Б тушаалын саналын хуудас-3 боть, Ирсэн бичиг-5 боть, Явуулсан албан бичиг 120 боть баримт үдэж, хавтаслан нийт -130 баримт үдэж хадгаламжийн нэгж бүрдүүлсэн.

ТАВДУГААР БҮЛЭГ. БУСАД АЖЛЫН ХҮРЭЭНД:

“Хаврын их цэвэрлэгээ” нэгдсэн арга хэмжээг 2024 оны 04 дүгээр сарын 08-19-ний өдрүүдэд зохион байгуулах ажлын хүрээнд 2024 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн 13:00-16:00 цагийн хооронд Улаанбаатар хотын захирагчийн ажлын албанаас ирүүлсэн нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайн цэвэрлэх хуваарийн дагуу Жуулчны гудамж, Цаг уурын уулзвараас баруун тийш бөмбөгөр захын баруун урд талын гэрлэн дохио хүртэл 20000 кв нийтийн эзэмшлийн зам талбайд хуримтлагдсан хог хаягдлыг ачих, шон дээр наасан зарлал



наалтыг хуулах, гэрлийн шон, замын тэмдэг тэмдэглэгээг угааж цэвэрлэх, автобусны буудал түүний ойр орчим нийтийн эзэмшлийн эд хогшил, хайс, хашлага, мод бут, зам талбайг угааж цэвэрлэсэн.

Иргэдийн амьдрах таатай орчныг бүрдүүлэхээр 2024 оныг “Тохижилт-Бүтээн байгуулалтын жил” болгон зарласантай холбогдуулан Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын албан хаагчдын санаачилгаар “Хаврын их цэвэрлэгээ” нэгдсэн арга хэмжээ 2024 оны 04 дүгээр сарын 08-19-ний өдрүүдэд зохион байгуулагдсан.

Нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж байгууллагуудад “Хаврын их цэвэрлэгээ” нэгдсэн арга хэмжээнд оролцох тухай 2024 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн 01/03/917, автобусны зогсоолыг угааж цэвэрлэх тухай албан бичгийг 2024 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн 01/03/968 дугаартай албан бичгээр тус тус хүргүүлэв.



НИЙТИЙН ТЭЭВРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭГЧ АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГУУДАД



“Хаврын их цэвэрлэгээ” нэгдсэн арга хэмжээнд оролцох тухай

“Хаврын их цэвэрлэгээ” нэгдсэн арга хэмжээ зохион байгуулах тухай

Иргэдийн амьдрах таатай орчныг бүрдүүлэхээр 2024 оныг “Тохижилт-Бүтээн байгуулалтын жил” болгон зарласантай холбогдуулан Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын албан хаагчдын санаачилгаар “Хаврын их цэвэрлэгээ” нэгдсэн арга хэмжээ 2024 оны 04 дүгээр сарын 08-19-ний өдрүүдэд зохион байгуулагдана.

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.21 дэх заалт, 63 дугаар зүйлийн 63.1.1 дэх заалт, 69 дугаар зүйлийн 69.1 дэх хэсэг, 74 дүгээр зүйлийн 74.1 дэх хэсэг, 77 дугаар зүйлийн 77.1 дэх хэсэг, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5 дэх хэсэг, Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3.6 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь.

Нэгдсэн арга хэмжээний хүрээнд иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор нийслэлийн нутаг дэвсгэрт оршин сууж, үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг орчны 50 метр хүртэлх газрын бохирдол, хог хаягдлыг цэвэрлэхийг үүрэг болгосон байна.

1. Иргэдийн амьдрах таатай орчныг бүрдүүлэхээр 2024 оныг “Тохижилт-Бүтээн байгуулалтын жил” болгон зарласантай холбогдуулан Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын албан хаагчдын санаачилгаар “Хаврын их цэвэрлэгээ” нэгдсэн арга хэмжээ 2024 оны 04 дүгээр сарын 08-19-ний өдрүүдэд зохион байгуулагдана.
2. Нэгдсэн арга хэмжээний хүрээнд иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор нийслэлийн нутаг дэвсгэрт оршин сууж, үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг орчны 50 метр хүртэлх газрын бохирдол, хог хаягдлыг цэвэрлэхийг үүрэг болгосугай.
3. Орчны бохирдол, хог хаягдлыг цэвэрлэж, “Хаврын их цэвэрлэгээ” арга хэмжээнд идэвхтэй оролцохыг төрийн болон нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, төрийн бус байгууллага, сууц өмчлөгчдийн холбоо, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад үүрэг болгосугай.
4. “Хаврын их цэвэрлэгээ” нэгдсэн арга хэмжээг зохион байгуулах удирдамжийг баталж, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллах Ажлын хэсгийн бүрэлдэхүүний хавсралтаар баталсугай.
5. Энэ захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Засаг даргын эдийн засаг, дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч П.Сайнааригт үүрэг болгосугай.

Иймд “Хаврын бүх нийтийн их цэвэрлэгээ” арга хэмжээг зохион байгуулах удирдамжийн 5-д заасан цэвэрлэгээний ажлын чиглэлийн хүрээнд 6-д заасан холбогдох ажлуудыг хийж гүйцэтгэн тайланг 2024 оны 04 дүгээр сарын 18-ны дотор тус газарт ирүүлнэ үү.

Нийслэлийн Засаг даргын захирамж болон “Хаврын бүх нийтийн их цэвэрлэгээ” арга хэмжээг зохион байгуулах удирдамжийг хавсралтаар хүргүүлэв.

Хавсралт 9 хуудастай.



Зураг №65. ААНБ-уудад Засаг даргын захирамжыг хүргүүлэв.



НИЙСЛЭЛИЙН НИЙТИЙН ТЭЭВРИЙН ГАЗАРТ

Тус газраас 2024 оны 04 дүгээр сарын 05-ний өдөр ирүүлсэн 01/03/917 тоот албан мэдэгдлийн дагуу манай компани “Хаврын их цэвэрлэгээ” нэгдсэн арга хэмжээнд бүх нийтийг хамарсан ажил зохион байгуулан ажиллаа.

Цэвэрлэгээ хийсэн зураг болон оролцсон хүмүүсийн гарын үсгийг хавсралтаар хүргүүлэв.

Хавсралт 17 хуудастай.



Зураг №66. Үүрэг даалгаварын биелэлт ирүүлсэн байдал

Нийслэлийн Засаг даргын 2024 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн А/348 дугаар удирдамжийн дагуу “Хаврын их цэвэрлэгээ” нэгдсэн арга хэмжээний хүрээнд 2024 оны 04 дүгээр сарын 09-ний өдөр “Нийслэлийн засаг захиргааны 4-р байр”-ны эргэн тойрны нийт 828 мкв замын нийтийн эзэмшлийн зам талбай, 2024 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн 13:00-16:00 цагийн хооронд Улаанбаатар хотын захирагчийн ажлын албанаас ирүүлсэн нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайн цэвэрлэх хуваарийн дагуу Жуулчны гудамж, Цаг уурын уулзвараас баруун тийш бөмбөгөр захын баруун урд талын гэрлэн дохио хүртэл 20000 мкв нийтийн эзэмшлийн зам талбайд хуримтлагдсан хог хаягдлыг цэвэрлэхэд тус тус оролцсон.



Зураг №67. Цаг уурын уулзвараас Бөмбөгөр захын урд талын гэрлэн дохио хүртэлх хог хаягдлыг цэвэрлэсэн.

**НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
НИЙТИЙН ТЭЭВРИЙН ГАЗАР**

Нийслэлийн засаг захиргааны IV байр,
Баян тойруу 15, 4 дугаар хороо,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас/Факс: (976-11) 32 79 68
Цахим хуудас: www.transport.ub.gov.mn

2024.04.19 № 01/03/1045
Танай _____ -ны № _____ Т

**УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧИЙН
АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА Ц.ТӨРХҮҮ ТАНАА**

"Хаврын их цэвэрлэгээ" нэгдсэн арга хэмжээнд тус газраас болон нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллагуудаас хийж гүйцэтгэсэн ажлын тайлан мэдээг хүргүүлж байна.

Хавсралт 8 хуудастай.

 Нийслэлийн нийтийн тээврийн газар
Удирдлага
Дарга
Давааням **ОТГОНЖАРГАЛ**
2024.04.19 15:41

НИЙСЛЭЛИЙН НИЙТИЙН ТЭЭВРИЙН ГАЗРААС "ХАВРЫН ИХ ЦЭВЭРЛЭГЭЭ" НЭГДСЭН АРГА ХЭМЖЭЭНИЙ ХҮРЭЭНД ХИЙЖ ГҮЙЦЭТГЭСЭН АЖЛЫН ТАЙЛАН.

2024 оны 04 дугаар сарын 19-ний өдөр Улаанбаатар хот

Нэг. Нийслэлийн хариуцлагын хүрээнд Нийслэлийн Нийтийн тээврийн газрын ажилтан, албан хаагчид нийтийн эзэмшлийн гудамж, талбайн угаалга цэвэрлэгээг хийж гүйцэтгэв.

1. Нийслэлийн Засаг даргын 2024 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн а/348 дугаар захираагийн дагуу "Хаврын их цэвэрлэгээ" нэгдсэн арга хэмжээ зохион байгуулах хүрээнд Нийслэлийн нийтийн тээврийн газраас 30 албан хаагч энэ оны 04 дугаар сарын 09-ны өдөр "Нийслэлийн засаг захиргааны 4-р байр"-ны эргэн тойрон нийт 828 мкв замын нийтийн эзэмшлийн зам талбайд ил задгай хуримтлагдсан хог хаягдал, тамхины иш, цаас гэх мэт хогыг цэвэрлэсэн.



2. Иргэдийг ажиллах амьдрах таатай орчныг бүрдүүлэхээр зорилгоор "Хаврын их цэвэрлэгээ" нэгдсэн арга хэмжээг 2024 оны 04 дугаар сарын 09-19-ний өдрүүдэд зохион байгуулах ажлын хүрээнд Нийслэлийн нийтийн тээврийн газраас 74 албан хаагч энэ оны 04 дугаар сарын 12-ны өдрийн 13:00-16:00 цагийн хооронд Улаанбаатар хотын захиргааны алсын албанаас ирүүлсэн нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайн хуваарийн дагуу Жугутны гудамж, Цэг уурин уулзвараас баруун тийш Бөмбөгөр замын баруун урд талын сарлан дохио хүртэл 20000 мкв нийтийн эзэмшлийн зам талбайд хуримтлагдсан хог хаягдлыг авч, шон дээр наасан зарлал

Зураг №68. Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанд тайланг хүргүүлэв.


Хяналт, шалгалтын хэлтсээс цэвэрлэгээ хийх зогсоолын хуваарийг гаргаж, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллан Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанд дээрх ажлын тайланг 2024 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн 01/03/1045 дугаартай албан бичгээр хүргүүлэв.

Нийслэлийн Нийтийн тээврийн газрын даргын 2024 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн А/30 дугаар тушаалаар 2024 оны 03 дугаар сарын 09, 10-ны өдрүүдэд Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 35-р хорооны суурьшлын бүсэд байгаа мал амьтдыг гаргах ажилд оролцож, мал амьтдыг тууж цуглуулан хашиж, эздэд нь хүргүүлэх ажлыг гүйцэтгэсэн.



Зураг №69. СХД-ийн 35-р хорооны суурьшлын бүсэд байгаа малыг гаргаж хашиж, эздэд нь хүргүүлэх ажил

6.1. Нийтийн тээврийн бодлогын газар нь Хан-Уул дүүргийн 23 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын цогцолбор барилгын "Б" блок байрны 4 давхарт шинэ байранд нүүж олсон.



Зураг №70. Нүүлгэн шилжүүлэлтийн ажил

НҮБ-ын Ази, номхон далайн эдийн засаг, нийгмийн комисстой хамтран “Цахилгаан тээврийн хэрэгслийн чиглэлээр судалгаа хийх, бодлогын баримт бичгийг боловсруулах” төслийн хүрээнд тус комиссын Тээврийн хэлтсийн тээврийн судалгаа, бодлогын албаны дарга Катрин Лугер, Зөвлөх Проф. Ёссопанг Лаунуйл, Зам тээврийн яамны бодлого төлөвлөлтийн газрын судалгаа, стандарт, статистикийн ахлах шинжээч Ө.Одгэрэл нар 2024 оны 09 дүгээр сарын 18-ны өдөр байгууллагын хурлын зааланд цахилгаан тээврийн хэрэгслийн ашиглалттай холбоотой асуудлаар хүлээн авч уулзалт зохион байгуулсан.




Зураг №71. Цахилгаан тээврийн хэрэгслийн ашиглалттай холбоотой асуудлаар хүлээн авч уулзалт

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчид хүргүүлэх “Эрдэм транс” ХХК-д холбогдох 2009 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийлүүлэгдсэн 30 автобусны санхүүгийн түрээсийн өр, төлбөр болон нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэх тээвэрлэлтийн гэрээний торгуульд хуримтлагдсан өр төлбөрийг суутгуулах талаарх ирүүлсэн мэдээллийг бэлтгэж Газрын даргад танилцуулж ажилласан.

6.4. 2024 оны 11 дүгээр сарын 02, 03-ны өдрүүдэд Нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч нийт 18 ААНБ-д бүртгэлтэй Юутонг, Голден драгон, Скайвелл, Шиамеи голден драгон, Маз, Юнлонг, Хьюндай аеро сити 540, Хьюндай Каунти маркын автобуснуудын болон 10 ширхэг троллейбусны дугуйг MNS 4598:2020 стандартын 5.14.4, 5.14.5 дах заалтыг хангаж байгаа эсэхийг шалгах зорилгоор Техникийн хяналтын үзлэгийн инженер Г.Ганбаатар, Э.Энхзул, С.Анхбаяр, Ж.Мөнхбат нар гүйцэтгэсэн. Шалгалтын ажлын илтгэх хуудсыг Газрын даргад танилцуулж ажилласан. Шалгалтаар дугуйн хэмжээ даац нь тухайн тээврийн хэрэгслийн төрөлд тохирсон бөгөөд MNS 4598:2020 стандартын 5.14.4, 5.14.5 дах: Тээврийн хэрэгслийн



дугуй нь улирал, цаг агаарын нөхцөлд тохирсон тэмдэглэгээтэй байна гэсэн заалтыг хангаж байгаа эсэхийг шалгахад /M+S/ шавар+цас гэх товчилсон тэмдэглэгээтэй байна. Энэ нь дээрх стандартад заасан өвлийн дугуйтай гэж дүгнэсэн.



Зураг №72. Цахилгаан тээврийн хэрэгслийн ашиглалттай холбоотой асуудлаар хүлээн авч уулзалт

Нийтийн тээврийн бодлогын газрын Даргын 2024 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн “Техникийн дэмжлэг үзүүлэх ажлын хэсгийг шинэчлэн батлах тухай” А/139 дүгээр тушаалын хавсралтаар МУ-ын Засгийн газар болон Дэлхийн банкны олон улсын сэргээн босголт, хөгжлийн банкны хамтран хэрэгжүүлж буй “Улаанбаатар хотын тогтвортой авто, зам тээврийн төсөл”-ийн үйл ажиллагааг дэмжин ажиллах “Техникийн ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг баталсан бөгөөд уг ажлын хэсгийн бүрэлдэхүүнд Бүртгэл техик технологийн хэлтсийн дарга шинээр орсон бөгөөд “Улаанбаатар хотын тогтвортой авто, зам тээврийн төсөл”-ийн тайлантай танилцаж, санал өгсөн.



Зураг №73. “Улаанбаатар хотын тогтвортой авто, зам тээврийн төсөл”-ийн хүрээнд хийгдсэн уулзалт

Нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж байгууллагуудын жолооч нарын дунд Уран жолоодлого-2024 тэмцээнийг 2024 оны 09 дүгээр сарын 14-ний өдөр зохион байгууллаа.





Зураг №74. Уран жолоодлого-2024

Нийтийн тээврийн бодлогын газраас 2024 оны 11 дүгээр сарын 23-ны өдөр Хан-Уулын нэгдсэн эмнэлэгт байгууллагын нийт 85 албан хаагчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулсан. “Багц урьдчилан сэргийлэх эрт илрүүлэг, үзлэг, оношилгоо”-нд эмчийн ерөнхий үзлэг, ерөнхий биохимийн шинжилгээ, цус болон шээсний ерөнхий шинжилгээ, ходоодны дуран, зүрхний цахилгаан бичлэг, цээжний рентген зураг нийт 6 төрлийн шинжилгээнд бүрэн хамруулсан. Шинжилгээнд нийт 85 албан хаагч хамрагдсанаас 29 оффисын ажилтан, 56 шалгагчийг бүрэн хамруулсан.





Зураг №75. Багц урьдчилан сэргийлэх эрт илрүүлэг, үзлэг, оношилгоонд хамрагдаж буй байдал

Нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллагуудын жолооч нарын дунд Уран жолоодлого-2024 тэмцээнийг 2024 оны 09 дүгээр сарын 14-ний өдөр зохион байгуулан, шилдгээр тодорсон 15 жолоочид Нийслэлийн Засаг даргын 2024 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн "Түрээслээд өмчлөх хэлбэрийн орон сууцны 100-150 сая төгрөгийн батламж"-аар тус тус шагнасан.

Нийслэлийн нийтийн тээврийн бодлогын газрын үүсэн байгуулагдсаны түүхт 55 жилийн ойн хүрээнд Улсын Нийслэл Улаанбаатар хотын хөгжил, цэцэглэлтэд бодитой хувь нэмэр оруулан салбартаа олон жил идэвх санаачилга үр бүтээлтэй онцгой амжилт гаргаж байгаа дараах албан хаагчдыг Нийслэлийн Засаг даргын 2024 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн "Түрээслээд өмчлөх хэлбэрийн орон сууцны 100 сая төгрөгийн батламж"-аар тус газрын 5 албан хаагчийг шагнасан.



Зураг №76. Түрээслээд өмчлөх хэлбэрийн орон сууцны 100 сая төгрөгийн батламж





Зураг №77. Түрээслээд өмчлөх хэлбэрийн орон сууцын 100-150 сая төгрөгийн батламжаар шагнагдаж буй буй байдал

Нийтийн тээврийн бодлогын газрын аварга шалгаруулах “Спортын 5 төрөлт” тэмцээн 2024 оны 04 дүгээр сарын 27-ны өдөр “Трансбус” ХХК-ийн спорт зааланд зохион байгуулагдсан бөгөөд хэлтсийн албан хаагчид амжилттай оролцсон.



Зураг №78. “Спортын 5 төрөлт” тэмцээн

Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас зохион байгуулсан UB QUIZ-385 тэмцээнд 2024 оны 05 дугаар сарын 22-ны өдөр оролцон багаараа тусгай байранд шалгарсан.



Зураг №79. UB QUIZ-385 тэмцээн

**ХИЙГДСЭН АЖЛЫГ НЭГТГЭН ДҮГНЭХЭД.**

Бодлогын бичиг баримтын хүрээнд:

“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх зорилго, зорилт, үйл ажиллагааны 2024 оны жилийн эцсийн хэрэгжилтийн дундаж 87,5 хувь;

“Шинэ сэргэлтийн бодлого”-ын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх хөгжлийн төслийн 2024 оны жилийн эцсийн хэрэгжилтийн дундаж 100 хувь;

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт туссан тус газарт хамаарал бүхий арга хэмжээний хэрэгжилтийн дундаж 100 хувь;

Зам, Тээврийн Хөгжлийн сайд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч нарын Зам, тээврийн салбарт 2020-2024 онд хамтран ажиллах “Санамж бичиг”-т туссан хамаарал бүхий арга хэмжээний 2024 оны жилийн эцсийн хэрэгжилт 99,4 хувь;

Тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийн 20 арга хэмжээний хэрэгжилт 86,3 хувь;

“Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах салбар зөвлөлийн”-ийн хэрэгжилтийн дундаж 100 хувь;

“Нийтийн тээврийн бодлогын газрын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө”-ний 2024 оны жилийн эцсийн хэрэгжилтийн дундаж 98,3% байна.

Нийслэлийн Засаг даргын Тамгын газар болон Yutong Bus Co.,Ltd хооронд 2023 оны 12 дугаар сарын 15-ны өдөр байгуулагдсан Нийтийн тээврийн автобус нийлүүлэх НЗДТГ/202310014 дугаартай гэрээнд захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэн, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Өвөр Монголын Өөртөө Засах орны Эрээн хотод очин захиалагчийн хяналт тавин, хуваарийн дагуу 565 автобус, “Нийтийн тээврийн автобус нийлүүлэх гэрээ”, НЗДТГ/202310014-02 дугаартай нэмэлт гэрээ”-нд заасан “Нийтийн тээврийн автобус нийлүүлэх нэмэлт гэрээ”-нд заасан чанар, стандарт, шаардлагад нийцсэн их багтаамжийн 31 автобус нийт 596 автобусыг хүлээн авч үйлчилгээнд гаргасан.

Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/110, А/546, А/1285 дугаар захирамжийн дагуу нийслэлийн 9 дүүргийн сургуулиудад хуваарилагдсан 58 автобусыг үйлчилгээнд гарган, ажлын гүйцэтгэлийг тооцох нөхцөлийг ханган ажилласан. 2024 онд 83 сургуулийн 69 автобус, 69 чиглэлд үйлчилгээнд ажиллаж өмнөх оны мөн үеэс 493158 хүүхдийг илүү тээвэрлэн үйлчилгээ үзүүлсэн байна. 58 чиглэлд сургуулийн хүүхдийн 58 автобусаар 1339493 сурагч тээвэрлэсэн байна.

Нийтийн тээврийн үйлчилгээнд шинэлэг менежментийг нэвтрүүлэх ажлын хүрээнд “Нийтийн тээврийн үйлчилгээний ажлын гүйцэтгэл тооцох журам, аргачлал”-ын шинэчлэн боловсруулж тус газрын даргын 2023 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн А/42 дугаар тушаалаар батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2014 оны 102 дугаар тогтоол “Нийслэлийн гудамж, замын хөдөлгөөнд ачааны автомашиныг цагийн хязгаартайгаар оролцуулах, түр зөвшөөрөл олгох журам”-ыг шинэчлэн, уг журмыг Нийслэлийн засаг даргын захирамжаар батлуулах саналын төслийг боловсруулан Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын дарга нараас санал авч, 2024 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулан, дэмжигдсэн.

“Гэр хорооллын тээврийн үйлчилгээг сайжруулах” төслийн хүрээнд нийтийн тээврийн үйлчилгээний “Нийтийн тээврийн мэдээллийн систем” хөгжүүлэх ажлыг гүйцэтгэгч Инфокон ХХК-иас эцсийн тайланг танилцуулснаар тус газарт хэрэгжүүлж эхэлсэн.

2024 онд төрийн өмчийн 4 байгууллага нийслэлийн нийтийн тээврийн парк шинэчлэлтийн ажлын хүрээнд импортлогдсон Yutong маркийн их багтаамжийн 231, угсраа 31, төрийн өмчийн 2 байгууллага County маркийн дунд багтаамжийн 31, хувийн хэвшлийн 10 аж ахуйн нэгж, байгууллага Yutong маркийн их багтаамжийн 333 автобусаар, 2 байгууллага дунд багтаамжийн 15 автобусаар, нийт /дизель евро-5 хөдөлгүүртэй – 595, дизель евро-4 хөдөлгүүртэй – 46/, нийт 641 автобусаар парк шинэчлэлт хийсэн. Хувийн хэвшлийн 7 байгууллага их багтаамжийн дизель хөдөлгүүртэй 27 автобус, 1 байгууллага дунд багтаамжийн 2, таксийн 5 байгууллага 100, буухиа үйлчилгээний 2 байгууллага 7 тээврийн



хэрэгслээр нөхөн хангалт хийсэн. 2024 онд нийт 670 тээврийн хэрэгслээр нөхөн хангалт хийгдсэн нь сүүлийн 5 жилийн хамгийн өндөр үзүүлэлт юм.

Замын хөдөлгөөний дүрмийн 11.10 дах заалт, Нийслэлийн засаг даргын 2020 оны А/1037 дугаар захирамжийг үндэслэн ажилчдын болон хүүхдийн автобусанд чиглэлийн тээврийн хэрэгслийн эгнээгээр зорчих зөвшөөрөл олгох ажил хийгдэж байна.

2024 оны эхнээс www.Smartcar.mn цахим сайтаар хүүхдийн автобустай холбоотой давхардсан тоогоор 66 хүсэлт ирүүлснээс 4 байгууллагын 13 тээврийн хэрэгсэлд зөвшөөрөл олгосон. Ажилчдын автобустай холбоотой давхардсан тоогоор 262 хүсэлт ирүүлснээс шинээр 16 байгууллагын 22 тээврийн хэрэгсэлд зөвшөөрөл олгосон. Ачааны автомашиныг цагийн хязгаарлалттайгаар оролцуулах “Түр” зөвшөөрлийг 2024 оны 01 дүгээр сарын 02-ноос 2024 оны 11 дүгээр сарын 30-ний өдрийг хүртэлх хугацаанд нийт 6562 зөвшөөрөл олгосон.

Ажил гүйцэтгэх гэрээ /Нийтийн тээврийн үйлчилгээг гүйцэтгүүлэх/, Санхүүжилтийн гэрээг сунгасан.

“Ажил гүйцэтгэх гэрээний үүргийн биелэлтийн дүнг нэгтгэх журам батлах тухай” тушаалын төслийг боловсруулж Газрын даргын 2023 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн А/52 дугаар тушаалаар баталсан журмын дагуу 2024 оны 1-11-р сарын гэрээг дүгнэсэн.

Нийтийн тээврийн үйлчилгээнд чиг үүргийн дагуу хяналт тавьж зөрчил илрүүлсэн болон зохицуулалт хийж богино эргүүлсэн тээврийн хэрэгслүүдийн мэдээлэлд системээр хяналт тавьж, тайлант хугацаанд ажлын гүйцэтгэл тооцох тухай нийт 168 удаагийн албан бичгийг Улаанбаатар смарт карт ХХК-д хүргүүлэн ажлын гүйцэтгэлд тооцуулсан.

ААНБ-н тээврийн хэрэгслийн утаатай, шугам замд зам эвдэрч зогссон болон шалтгаангүй зогссон тээврийн хэрэгслийн зөрчлийг ААН-д мэдэгдэж зөрчлийг арилгуулах шаардлага тавьж ажилласан мөн шалтгаангүй зогссон 3851 тээврийн хэрэгслийн 1051:52 цагийг ажлын гүйцэтгэлээс хасаж ажилласан.

Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/1121 дугаартай захирамжийн хэрэгжилтийг хангах зорилгоор тус газрын даргын 2024 оны А/112 дугаар тушаалаар Ажлын хэсгүүд байгуулагдсан. Зөвшөөрлийн тухай хуульд зааснаар нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч 26 хуулийн этгээд тусгай зөвшөөрөл олгуулах хүсэлт тус газарт ирүүлсний дагуу магадлан шалгаж тусгай зөвшөөрөл олгох эсэх талаар санал боловсруулж, 2024 оны 10 дугаар сарын 10, 11 дүгээр сарын 11, 12, 14, 19, 22-ны өдрийн Комиссын хуралд танилцуулсны дагуу холбогдох нөхцөл, шаардлага хангасан Зорчигч тээвэр нэг ОНӨААТҮГ, Зорчигч тээвэр хоёр ОНӨААТҮГ, Автотерминал трейд ХХК, Буянт хөлгийн жолоо ХХК, ДЮЦ ХХК, Трансбус ХХК, Зорчигч тээвэр тав ОНӨААТҮГ, Блюбус ХХК, Сутайнбуянт ХХК, Эрдэмтранс ХХК, Мязрзлаа ХХК, ЭМСИД ХХК, Автобус нэгдэл ХХК, Гбус ХХК, Эс Энд Эй Транс ХХК, Тэнүүн огоо гуравдугаар бааз ХХК-ууд хуульд заасан нөхцөл, шаардлагыг бүрэн хангасан тул тусгай зөвшөөрөл олгуулах санал гаргаж, Сайхан ирээдүй ХХК, Тэ бэ сервис ХХК-ууд хуульд заасан нөхцөл, шаардлагыг хангаагүй тул тусгай зөвшөөрөл олгохоос татгалзсан санал гаргаж, холбогдох санал, дүгнэлтийг Нийслэлийн Засаг даргад хүргүүлсэн. Нийт нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч 16 /үндсэн-15, буухиа-1/ аж ахуйн нэгж, байгууллагуудад тусгай зөвшөөрөл олгуулах санал хүргүүлсэн, 2 /үндсэн-1, такси-1/ аж ахуйн нэгж, байгууллагад тусгай зөвшөөрөл олгохоос татгалзсан комиссын шийдвэрийг Нийслэлийн Засаг даргад албан бичгээр хүргүүлсэн.

Нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллагуудын шуурхай зөвлөгөөнийг 7 хоног бүрийн даваа гарагт зохион байгуулж хэвшсэн.

2024 онд нийтийн тээврийн үйлчилгээний чиглэл бүрийн рейсийн гүйцэтгэлийн хувь, цагийн гүйцэтгэлд өдөр бүр системээр хяналт тавьж, хөдөлгөөнд оролцоогүй сул зогссон боловч ажлын гүйцэтгэлд тооцогдсон 3905 зөрчлийн 1038 цагийн гүйцэтгэлийг ажлын гүйцэтгэлээс хасаж тооцуулсан.

2024 онд нийт 4 чиглэлээр 50 удаагийн сургалтаар нийт 28 аж ахуйн нэгж, байгууллагын 2917 инженер, техникийн ажилтан, жолооч, захиргааны ажилчдыг салбарт



мөрдөгддөг хууль эрх зүйн актууд, нийтийн тээврийн үйлчилгээний соёлыг дээшлүүлэх хүрээнд дөрвөн чиглэлээр сургалтад хамруулсан байна. Үүнд:

Нийтийн тээврийн үйлчилгээнд ажиллаж байгаа жолооч нарт чиглэсэн 34 удаагийн сургалтаар 2278 жолооч;

Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн чиглэлээр хийгдсэн 4 удаагийн 183 инженер, техникийн ажилчид;

Салбарт хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрийн чиглэлээр 7 удаагийн сургалтаар 259 инженер, техникийн ажилчид;

Нийтийн тээврийн салбарын бусад чиглэлээр 4 удаагийн сургалтаар 197 инженер, техникийн ажилчдыг тус тус сургалтад хамруулсан.

Нийслэл Улаанбаатар хотын Авто замын түгжрэлийг бууруулах үндэсний хороо, Тээврийн Цагдаагийн алба, Нийслэлийн Нийтийн тээврийн бодлогын газрууд хамтран 2024 оны 04 дүгээр сарын 17-ны өдөр баталсан удирдамжийн дагуу 2024 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс 05 дугаар сарын 27-ны өдрийг дуустал хуваарийн дагуу нийт 19 удаагийн сургалтаар 1356 жолоочийг хамруулсан нь нийтийн тээврийн үйлчилгээг соёлтой хүргэх, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах чиглэлээр өмнө нь хийгдэж байгаагүй томоохон сургалт зохион байгуулагдсан гэж үзэж байна.

Шинжлэх Ухаан Технологийн Их Сургуулийн Механик тээврийн сургуультай хамтран зохион байгуулсан сургалтууд нь салбарын инженер техникийн ажилтнуудад чухал мэдлэг мэдээллийг өгсөн.

“Түмний жолооч-Түшигтэй гэр бүл” соён гэгээрүүлэх арга хэмжээг төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран 200 залуу жолоочийг гэр бүлийнх нь хамт оролцуулан зохион байгуулсан нь жолооч нарыг ажил мэргэжлээрээ бахархах, гэр бүлтэйгээ цагийг дурсамжтай өнгөрөөх боломжийг бүрдүүлсэн.

Замын хөдөлгөөний удирдлагын төв НӨҮГ, Тээврийн цагдаагийн албатай хамтран нийтийн тээврийн салбарт шинээр ажилд орж байгаа болон зөрчил гаргасан жолооч нарт зориулсан сургалтыг зохион байгуулж хэвшсэн.

2024 оны 11 дүгээр сараас эхлэн Гэрэгэ киоск ххк-тай хамтран ЕС болон ТҮР зөвшөөрлийг “ХУР” системтэй холбосон шинэ систем нэвтрүүлэн иргэдэд хурдан шуурхай үйлчилж тус зөвшөөрлийг цахимаар олгохоор программ хөгжүүлэлтийн үе шатандаа явагдаж байна.

Авто үйлчилгээний чиглэлээр иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын 150-н ангилал тогтоож гэрээ байгуулан ажилласан.

Ачааны автомашиныг цагийн хязгаарлалттайгаар оролцуулах “Түр” зөвшөөрөл, Нийслэлийн нутаг дэвсгэрт ачаа тээвэрлэх эрх бүхий “ЕС” зөвшөөрлийн нийт орлого НЭГ ТЭРБУМ – 1,100,000,000 төгрөгийг төрийн санд төвлөрүүлэн ажиллана.

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 79 дүгээр тогтоолоор батлагдсан “Машин цагийн зардлын тариф”-ыг 2024 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 26 дугаар тогтоолоор шинэчлэн батлагдаж нийтийн тээврийн салбарын жолооч нарын сарын цалин 3,5 сая төгрөг, инженер техникийн ажилчдын цалин 3,0 сая төгрөг болж тус тус нэмэгдсэн бөгөөд 2024 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс мөрдөж эхэлсэн.

Нийтийн тээврийн бодлогын газрын даргын 2024 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн А/126 дугаар тушаалаар баталсан удирдамжийн дагуу Нийтийн тээврийн үйлчилгээний байгууллагуудын өвөлжилтийн бэлтгэлийг хангуулах, ажлын явцыг эрчимжүүлэх, өвлийн улирлыг хүндрэл бэрхшээлгүй өнгөрүүлэх зорилгоор 2 ажлын хэсэг байгуулагдаж 2024 оны 10 дугаар сарын 22-ны өдрөөс 10 дугаар сарын 24-ний өдрүүдэд шалгалтын ажлыг зохион байгуулж, өвөлжилтийн бэлтгэлийг бүрэн хангасан зэрэг ажлуудыг 2024 онд хийж хэрэгжүүлсэн байна.

ЦААШИД ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН САНАЛ.

Нийтийн тээврийн бодлогын газраас дараах ажлуудыг хэрэгжүүлэх саналтай байна. Үүнд:

1. Үндсэн чиглэлийн үйлчилгээ эрхлэгч байгууллагуудын гэрээг шинэчлэх;



2. Удирдлага, мэдээллийн болон цахим төлбөрийн системийн програм хангамжид хөгжүүлэлт хийлгэхээр Улаанбаатар смарт карт ХХК-д хүргүүлсэн хэрэглэгчийн шаардлагуудын дагуу хөгжүүлэлтийг хийлгэх ажилд хяналт тавих;
3. Хүний нөөцийн мэдээллийн сангийн програмын ашиглалтыг сайжруулан, салбарын ажиллагсдын нэгдсэн тоон мэдээллийн баазыг сайжруулж, аж ахуйн нэгж, байгууллагуудыг бүрэн ашиглуулж хэвшүүлэх;
4. Санал гомдол, бүртгэл мэдээллийн сангийн программ хангамжийг хөгжүүлж дууссан бөгөөд цаашид бүрэн ашиглаж хэвшүүлэх ;
5. Жолооч инженер техникийн ажилтны гарын авлагыг эцэслэн боловсруулахад хяналт тавьж эцэслүүлж, сургалтыг зохион байгуулах.
6. Зорчигч, иргэдэд чиглэсэн эерэг хандлагыг түгээх компани ажил зохион байгуулах;
7. Ажлын гүйцэтгэл тооцох журмын хэрэгжилтэд хяналт тавьж, журам хэрэгжиж эхэлснээс хойших гүйцэтгэлийг өмнөх онуудын гүйцэтгэлтэй харьцуулсан судалгааг хийх.
8. Аж ахуйн нэгж, байгууллагуудын санал гомдол хүлээн авдаг утсыг ажиллагаатай болгож, аж ахуйн нэгжтэй холбоотой ирсэн санал гомдлыг байгууллага өөрөө шийдвэрлэдэг болгох.
9. Техник хяналтын үзлэгт ороод тэнцсэн тээврийн хэрэгсэл сар болоогүй гомдол ирж байгаа тул үзлэг оношилгоог сайжруулж, хяналт тавьж ажиллах.
10. Сургалтын үйл ажиллагаанд шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах /Зөөврийн компьютер гэх мэт/;
11. Сургалт, судалгааны мэргэжлийн байгууллагуудаас төлбөртэй сургалт авах зардлыг шийдвэрлүүлэх;
12. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа эрүүл ахуйн чиглэлээр сургалтад хамрагдах, мэргэжлийн байгууллагаас нийт ажилтны сургалт авах;
13. Сэтгэл судлал, хүний хөгжил, зан харилцаатай холбоотой мэргэшсэн сургагч эсвэл сэтгэл зүйчтэй болох;
14. Сургалтын үйл ажиллагаа явуулахтай холбоотой зардлыг шийдвэрлэх;
15. Сургалтын үйл ажиллагаанд холбогдох хэлтсүүдийн албан хаагчдыг идэвхтэй оролцуулж хамтарч ажилладаг байх.;
16. Төлбөрийн менежментийн системийн хөгжүүлэлт хийгдэх ажилд хяналт тавих.
17. Тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагыг хангасан аж ахуйн нэгж, байгууллагуудад тусгай зөвшөөрөл олгуулах ажлын хэсгийн санал, комиссын шийдвэрийг Нийслэлийн Засаг даргад албан бичгээр хүргүүлж ажиллах.
18. Сургуулийн автобусны үйлчилгээнд ажиллаж байгаа тээврийн хэрэгслүүдийг 100 хувь бүртгэлийн төхөөрөмжтэй болгосноор ажлын гүйцэтгэл үнэн зөв тооцогдоход нөлөөлнө.
19. Нийтийн тээврийн үйлчилгээний ажлын гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахад ажлын ачаалал их байгаа тул Ажлын гүйцэтгэлийн хяналтын мэргэжилтний сул орон тоонд холбогдох ажлын байрны тодорхойлолтын шаардлага хангасан мэргэжилтэн сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулах.
20. Нийслэлийн төр захиргааны эзэмшилд бүртгэлтэй тээврийн хэрэгсэлд техникийн хяналтын үзлэг хийх ажлыг эрчимжүүлэх.
21. Техникийн хяналтын үзлэгийн төвийг Итгэмжлэлд хамруулах ажлыг зохион байгуулах.
22. Техникийн хяналтын үзлэгийн төвийн тоног төхөөрөмжийн хэвийн найдвартай ажиллагааг хангахтай холбогдуулан зарим шаардлагатай сэлбэг хэрэгслийг шинэчлэх.
23. Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 102 дугаар тогтоолоор баталсан “Нийслэлийн гудамж, замын хөдөлгөөнд ачааны автомашиныг цагийн хязгаарлалттайгаар оролцуулах, түр зөвшөөрөл олгох журам”-д нэмэлт өөрчлөлт оруулахаар 2025 оны 1 дүгээр сард Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчаар батлуулах.
24. Гэрэгэ киоск ххк-тай хамтран ЕС болон ТҮР зөвшөөрлийг “ХУР” системтэй холбосон шинэ систем нэвтрүүлэн иргэдэд хурдан шуурхай үйлчилж тус зөвшөөрлийг цахимаар олгохоор программ хөгжүүлэлтийн 2025 оны 1 улиралд хийж гүйцэтгэх.
25. Аюултай болон тэсэрч дэлбэрэх ачаа тээвэрлэх хуулийн этгээд нь тухайн тээврийн хэрэгслийн “GPS” буюу байршил тогтоогчийг системд суурилуулах.
26. Авто үйлчилгээний бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан байгуулж, авто үйлчилгээний салбарт баталгаат үйлчилгээний тогтолцоог сайжруулах;
27. Зорчигчийн урсгалаас хамааруулан дагуул, хаяа хотуудыг холбосон их багтаамжийн тээврийг нэвтрүүлэх ажлын хүрээнд зорчигчийн урсгалаас хамааруулан дагуул, хаяа хотуудыг холбосон их багтаамжийн тээврийг нэвтрүүлэх;



28. Улаанбаатар хотод хийгдэх тойрог замын зохион байгуулалт, нийтийн тээврийн гол ба туслах замуудын нийтийн тээврийн үйлчилгээг зөв оновчтой байдлаар төлөвлөх;
29. Нийтийн тээврийн хэрэгслийн замналын дагуух саравчтай болон дулаан зогсоолуудын тоог нэмэгдүүлэх;
30. Нийтийн тээврийн автобусны дулаан зогсоолуудыг камерын нэгдсэн хяналттай болгох;
31. Гэр хорооллын 5 чиглэлд дунд оврын автобусны үйлчилгээг нэвтрүүлэх;
32. Нийтийн тээврийг хөгжүүлэх мастер төлөвлөгөөг боловсруулах сонгон шалгаруулах ажилд анхааран, ажлын явцыг эрчимжүүлэх;
33. Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого Алсын хараа 2050 бодлогын баримт бичгийн хүрээнд Салбарын хөгжлийн төлөвлөгөө боловсруулах;
34. Салбарын хэмжээнд хэрэгжиж буй төсөл хөтөлбөрийн хүрээнд тогтмол мэдээлэл солилцон нэгдсэн мэдээллээр шаардлагатай байгууллага, албан хаагчийг хангах;
35. Салбарын хэмжээнд ашиглагдаж буй стандартыг шинэчлэх саналыг гарган холбогдох өөрчлөлтийн саналыг холбогдох хэлтэс, байгууллагуудад тухай бүр хүргүүлэх, санал өгөх;
36. Автозамын сангийн хөрөнгөд нийтийн тээврийн үйлчилгээний зогсоол байгуулах хөрөнгийг 2025 оны төсөвт тусгуулах арга хэмжээ авах;
37. Нийтийн тээврийн зогсоолын нэгдсэн үзлэгийг зохион байгуулж, зогсоолын мэдээллийн санг, шинэчлэх;
38. Шинэ суурьшлын цэгүүдэд нийтийн тээврийн үйлчилгээг хүргэх;
39. Нийтийн тээврийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх шаардлагатай чиглэлүүдийг тодорхойлж, шийдүүлэх арга хэмжээ авах;
40. Нийтийн тээврийн төлбөрийн менежментийн систем төсөл, арга хэмжээний хүрээнд хийгдэж байгаа системийн шинэчлэлийн ажлын хүрээнд нийтийн тээврийн үйлчилгээнд ажиллаж буй тээврийн хэрэгслийн цагийн хуваарийг динамик байдлаар боловсруулах талаар идэвх санаачилгатай ажиллах. Төслийг гүйцэтгэгч ICT компанитай хамтарч ажиллах;
41. Нийтийн тээврийн үйлчилгээний сүлжээ төлөвлөлтийг бодит тоон мэдээлэлд үндэслэн боловсруулахад мэдээллийн big data-тай болох замаар өрхийн зорчилтын судалгааг зохион байгуулах, судалгааны тооцооллыг хийж шаардагдах санхүүжилтийг холбогдох байгууллагуудад хүргүүлэн шийдвэрлүүлэх;
42. Нийтийн тээврийн үйлчилгээний үйл ажиллагаатай холбоотой хийгддэг судалгаанууд буюу эргэлтийн хугацааны судалгаа, зогсоол хоорондын хугацаа, зорчигч урсгалын судалгаа, эрэлтийн судалгаа, сэтгэл ханамжийн судалгаа, орлогын судалгаа, давхцалын судалгаа, гудамж замын ашиглалтын хурдны судалгааг 7 хоногоор, 14 хоногоор, сараар, улирлаар, жилээр гарган дүн шинжилгээ харьцуулалтуудыг хийж судалгааны мэдээллийн санг үүсгэх;
43. Нийтийн тээврийн үйлчилгээний үнэ тарифын бодит тооцоо судалгааг хийж, цаашид орлого нэмэгдүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх арга хэмжээний санал боловсруулан холбогдох хэлтэстэй хамтран танилцуулан шийдвэрлүүлэх;
44. Зорчигчийн хөлс төлөлтөд хяналт тавих байгууллагын судалгаа тайланг шинжлэх, хамтран судалгааны ажил зохион байгуулж шаардлагатай арга хэмжээ авч ажиллах;
45. Нийтийн зорчигч тээврийн үйлчилгээний зогсоол, чиглэл, автобусны паркийн байршлын мэдээллийг Arc GIS программд оруулан, Нийслэлийн дундын мэдээллийн санд холбох зэрэг ажлуудыг хэрэгжүүлэх саналтай байна.

ТАНИЛЦСАН:

ДАРГА

Д.ОТГОНЖАРГАЛ

ХЯНАСАН:

ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН

ХЭЛТСИЙН ДАРГА

З.ЦЭВЭЭНДОРЖ

ТАЙЛАНГ НЭГТГЭСЭН:

ХҮНИЙ НӨӨЦ ХАРИУЦСАН

АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Б.БОЛОРЦЭЦЭГ